

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо



Үндэсний Статистикийн Хорооны  
даргын 2012 оны 04 дүгээр сарын  
30-ны өдрийн 1/61 дүгээр тушаалын  
3 дугаар хавсралт

# **ХАА-Н ТООЛЛОГЫН АСУУЛГЫГ НӨХӨХ ЗААВАР**

**Улаанбаатар  
хот, 2012**

# АГУУЛГА

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХОД АШИГЛАХ ИТГЭЛЦҮҮР .....	2
БҮЛЭГ I. ХАА-Н ТООЛЛОГЫН ЗОРИЛГО, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС .....	3
1.1.ХАА-н тооллогын зорилго, ач холбогдол.....	3
1.2.Тооллогыг явуулах эрх зүйн үндэс .....	4
1.3.Тооллогын тов, хугацаа .....	4
1.4.Тооллогын хамрах хүрээ, нэгж.....	4
1.5.Тооллого явуулах үндсэн зарчим .....	4
1.6.Тооллогын удирдлага, зохион байгуулалт .....	5
БҮЛЭГ II. ТООЛОГЧ, ШАЛГАГЧИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛС.....	5
2.1.Тоологчийн баримтлах зарчим, үүрэг, хориглох зүйлс .....	5
2.1.1. Тоологчийн баримтлах зарчим .....	5
2.1.2. Тоологчийн гүйцэтгэх ажил үүрэг.....	6
2.1.3. Тооллогын асуулга, бусад материалын аюулгүй байдлыг хангах .....	7
2.1.4. Тоологчийн хориглох зүйлс .....	7
2.1.5. Тоологчийн эрүүл мэнд, аюулгүй байдал.....	7
2.2.Ахлагчийн үүрэг, баримтлах зарчим болон хориглох зүйлс .....	8
2.2.1. Ахлагчийн үүрэг.....	8
2.2.2. Ахлагчийн хориглох зүйлс .....	9
2.3.Шалгагчийн үүрэг, баримтлах зарчим болон хориглох зүйлс .....	9
2.3.1. Шалгагчийн үүрэг .....	9
2.3.2. Шалгагчийн хориглох зүйлс.....	10
БҮЛЭГ III. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР .....	11
БҮЛЭГ IV. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР.....	32
БҮЛЭГ V. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР .....	46
БҮЛЭГ VI. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР .....	77
БҮЛЭГ VII. ОЙН АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР.....	101
БҮЛЭГ VIII. АН АГНУУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР .....	107

БҮЛЭГ IX. ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР.....	114
БҮЛЭГ X. ЗАСАГ ЗАХИРГААНЫ АНХАН ШАТНЫ НЭГЖИЙН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР .....	120
БҮЛЭГ IX. ГАЗРЫН ЗУРАГ АШИГЛАХ ЗААВАР .....	123
ЯРИЛЦЛАГЫН ТӨГСГӨЛ .....	138

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА
ҮСХ	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ХАА	ХӨДӨӨ АЖ АХУЙ
ХААТ	ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГО
ХХААБ	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА
ЭЗҮАСА	<u>Э</u> ДИЙН <u>З</u> АСГИЙН БҮХ ТӨРЛИЙН <u>Ү</u> ЙЛ <u>Д</u> ЖИЛЛАГААНЫ <u>С</u> АЛБАРЫН <u>Д</u> НГИЛАЛ

# МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХОД АШИГЛАХ ИТГЭЛЦҮҮР

## Тариалсан талбай

1 га	=	10000	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000 м <sup>2</sup>	=	1 га

## Хураасан ургац

1 кг	=	1000 гр
1 т	=	1000 кг
1 л	=	1.03 кг

## Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	=	5 хонь
1 адуу	=	7 хонь
1 үхэр	=	6 хонь
1 хонь	=	1 хонь
1 ямаа	=	0.9 хонь

## Бод малд шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	=	1 бод
1 тэмээ	=	1.5 бод
6 хонь	=	1 бод
8 ямаа	=	1 бод

# БҮЛЭГ I. ХАА-Н ТООЛЛОГЫН ЗОРИЛГО, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

## 1.1. ХАА-н тооллогын зорилго, ач холбогдол

**ХАА-н тооллого гэж юу вэ? ХАА-н тооллого** гэдэг нь улс орныг бүхэлд нь эсвэл тодорхой нэг гол нутаг дэвсгэрийг хамруулан тоо мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах зорилго бүхий статистикийн үйл ажиллагаа юм. ХАА-н тооллогоор ХАА-н үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, өрх, тэдгээрийн тоо, эзэмшил газар, газар ашиглалт, хураасан ургацын талбай, усжуулалт, малын тоо, толгой, ажиллах хүчин болон хөдөө аж ахуйн бусад орцуудын талаарх тоо мэдээллийг цуглуулдаг.

Тооллогоор ХАА эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, өрхүүдээс мэдээллийг шууд цуглуулах ба анхан шатны засаг захиргааны түвшний зарим үзүүлэлтүүдийг мөн цуглуулдаг. ХАА-н тооллогоор хөдөө аж ахуйн үндсэн үзүүлэлтүүдийг нэлэнхүй тооллогоор, харин илүү дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг түүвэр судалгаагаар цуглуулна.

Хөдөө аж ахуйн салбар нь зөвхөн газар тариалан болон мал аж ахуйн үйлдвэрлэлээр хязгаарлагддаггүй, ой, ан агнуур болон загасны аж ахуй, түүнчлэн хүнс болон хөдөө аж ахуйтай холбоотой бусад үйл ажиллагааг хамардаг өргөн цар хүрээтэй салбар билээ.

**ХАА-н тооллогын Дэлхийн хөтөлбөр. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага үүсэн байгуулагдсанаас хойш өөрийн гишүүн орнуудтайгаа хүнс, хөдөө аж ахуйн статистик мэдээллийн хамралт, үнэн зөв байдал, чанарыг дээшлүүлэх тал дээр хамтран ажилласаар ирсэн.**

Тус байгууллагын үйл ажиллагааны чухал элементүүдийн нэг нь 10 жил тутам зохион явуулдаг **ХАА-н тооллогын Дэлхийн Хөтөлбөрт** дэмжлэг үзүүлэх явдал юм. Анх 1945 онд эхэлснээс хойш нийт **8 удаагийн хөтөлбөр** хэрэгжсэн бөгөөд НҮБ-ын ХХААБ гишүүн орнууддаа ХАА-н тооллогыг төлөвлөх, зохион байгуулж, явуулах тал дээр туслах зорилгоор ХАА-н тооллогын ойлголт, тодорхойлолт, ангилал болон арга зүйн гарын авлагыг хариуцан бэлтгэсээр ирсэн.

**ХАА-н тооллогыг 10 жил тутам 1 удаа** зохион байгуулах бөгөөд 2012 оны ХАА-н анхны тооллого нь шинэ арга зүйн дагуу, ХАА-н тооллого, судалгааны нэгдсэн системийн хүрээнд ХАА-н тооллогыг зохион явуулахыг чухалчилж байгаа үндэсний статистикийн системийн өргөн хүрээтэй ажил болж байна.

НҮБ-ын ХХААБ-аас **ХАА-н тооллогыг 2006-2015 онд явуулах Нэгдсэн Хөтөлбөрийг** боловсруулсан байна. Улс орнуудын зохион байгуулалтын болоод санхүүгийн боломж зэрэг олон хүчин зүйлүүдээс хамаарч тооллогын хугацаа улс орнуудад харилцан адилгүй байна.

НҮБ-ын ХХААБ улс орнуудыг ХАА-н тооллогоо аль болох 2010 онтой ойролцоо жилүүдэд зохион явуулж, олон улстай зэрэгцүүлэгдэхүйц, ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулахыг уриалсан байна.

**2000 оны ХАА-н тооллогод дэлхийн 100 гаруй орон оролцож, дэлхийн хүн амын 84 хувийг хамарсан бол 2010 он орчмын тооллогод оролцох улсын тоо 100-аас дээш болж** нэмэгдэх тооцоог НҮБ-ын ХХААБ-аас тооцоолж байна. Тооллогын хамрах хугацаа нь **1 жил буюу 12 сар** байна. Өнөөдөр ХАА-н тооллогын Дэлхийн 9 дэх хөтөлбөр явагдаж байна.

2010 он орчмын ХАА-н тооллогын Дэлхийн хөтөлбөрийн хувьд, ХАА-н тооллого, судалгааны нэгдсэн системийн хүрээнд ХАА-н тооллогыг зохион байгуулж, явуулахыг онцолж байгаа билээ. Нэгдсэн систем нь 2 элементээс бүрдэнэ. Үүнд:

(1) Нэгдсэн системийн цөм болох **ХАА-н тооллого**

(2) ХАА-н тооллого дээр үндэслэн явагдах ХАА-н түүвэр судалгаа болно.

**ХАА-н тооллогын зорилго нь** ХАА-н салбарын мэдээллийг цуглуулах, цогц үзүүлэлтийг дэлгэрэнгүй түвшинд түүнчлэн анхан шатны засаг захиргааны түвшний талаарх үзүүлэлтүүдийг цуглуулж мэдээллийн нэгдсэн санг бий болгох, одоо байгаа хөдөө аж ахуйн статистик мэдээллийг сайжруулах суурь мэдээллийг бий болгох, ХАА-н түүвэр судалгааны хүрээг бэлтгэх, Дэлхий нийтийн хөгжлийн зорилтуудыг, ялангуяа хөдөөгийн МХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг цуглуулахад чиглэж байгаа юм.

**ХАА-н тооллогын ач холбогдол нь** мэдээллийн иж бүрэн системийг бүрдүүлж, ХАА-н салбарт төлөвлөлт, бодлого боловсруулалт, гарч буй шийдвэрийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг үнэлэх, дүн шинжилгээ хийх, бизнес эрхлэгчдэд шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад зориулсан нарийвчилсан мэдээллийн эх үүсвэрийг бий болгоход оршино.

## 1.2. Тооллогыг явуулах эрх зүйн үндэс

ХАА-н тооллогыг дараах хууль, эрх зүйд үндэслэн зохион байгуулж явуулна. Үүнд:

- Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт “*л /Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллого, судалгааг 5 жил тутам*” явуулах;
- Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ХАА-н тооллогын тов тогтоох тухай 137 тоот тогтоол;
- ХАА-н тооллогын бэлтгэл ажлыг ханган ажиллах тухай Улсын комиссын ажлын төлөвлөгөө;
- Үндэсний статистикийн хорооны даргын 2012 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ХАА-н тооллогын асуулга, тэдгээрийг нөхөх зааврыг батлах тухай 1/61 дүгээр тушаал;

## 1.3. Тооллогын тов, хугацаа

ХАА-н тооллогыг товын дагуу 2012 оны 5 дугаар сарын 25-наас 2012 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулж явуулна. ХАА-н тооллого нь 2012 оны 5 дугаар сарын 25-ны өглөөний 09 цагт улс орон даяар зэрэг эхэлнэ.

## 1.4. Тооллогын хамрах хүрээ, нэгж

ХАА-н тооллогын хамрах хүрээ нь тооллого, судалгааны хувьд улс орон бүхэлдээ байх бөгөөд хамрах нэгж нь мал аж ахуй болон газар тариалан, ой, загас, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, өрх байна.

## 1.5. Тооллого явуулах үндсэн зарчим

Тооллогыг явуулахад дараах **зарчмыг** баримтална. Үүнд:

- Тооллогын тайлант хугацаа нь нийт 12 сар байх ба **2011 оны гүйцэтгэл дээр үндэслэх;**
- Тоологчид аж ахуйн нэгж, байгууллага, өрх бүрт очиж, тооллогын асуулгыг биечлэн танилцуулан, байгууллагын удирдлага, бусад хүмүүс, өрхийн гишүүдтэй хамтран нөхөх журмаар тооллогыг явуулах;
- Тогтоосон хугацаанд сонгогдсон нутаг дэвсгэрт нэгэн зэрэг тоолох;

- Тоологч тоолох ажлыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгэн зэрэг эхлүүлж, дуусгах;
- Тоологч тооллогын асуулгыг зааврын дагуу алдаагүй, үнэн зөв нөхөх;
- Хувь хүн, аж ахуйн нэгжийн мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
- Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн”, “Мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага”-ын судалгаанд хамрагдана. Судалгаанд мал аж ахуй эрхэлдэг өрх түүврээр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэлэнхүй ажиглалтаар хамруулна. ҮСХ-ноос хүргүүлсэн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийн дагуу судалгаанд хамруулна.
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь “Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх”-ийн, “Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага”-ын тооллогод хамрагдана. Тооллогод газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага нэлэнхүйгээр хамрагдана. Тооллогын хамрах хүрээг өрх, аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийн жагсаалтаар ҮСХ-ноос хүргүүлнэ.
- Газар тариалан эрхэлдэг өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн судалгаанд хамрагдахаар түүвэрт сонгогдсон тохиолдолд уг өрх мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн судалгаа болон малын түүвэр судалгаанд гурвууланд хамрагдаж “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн асуулга”, “Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн асуулга”, “Малын түүвэр судалгаа”-ны асуулгыг тус тус нөхнө.
- Ойн аж ахуй, ан агнуур, загасны аж ахуй эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг мөн ҮСХ-ноос хүргүүлсэн нэрсийн дагуу судалгаанд хамруулна.
- Засаг захиргааны анхан шатны нэгжийн судалгаанд бүх сумд хамрагдах бөгөөд сумдын төрийн сангийн төлөөлөгч буюу статистик хариуцсан ажилтан хариуцан нөхнө.
- Тооллого, судалгааг явуулахад нутаг дэвсгэрийн болон засаг захиргааны гэсэн 2 зарчмыг баримтална.

## **1.6. Тооллогын удирдлага, зохион байгуулалт**

Тооллогын удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь Улсын комисс, ҮСХ-ны тооллогын ажлын баг, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комисс, бүх шатны ахлагч, тоологч, шалгагч, шивэгч нараас бүрдэнэ.

Нэлэнхүй тооллогод хамрагдах нэгжийг бүрэн хамруулахад анхаарч ажиллана.

## **БҮЛЭГ II. ТООЛОГЧ, ШАЛГАГЧИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛС**

### **2.1. Тоологчийн баримтлах зарчим, үүрэг, хориглох зүйлс**

#### **2.1.1. Тоологчийн баримтлах зарчим**

1. Тооллогын нэгжийг зөвхөн тогтоогдсон хугацаанд буюу 2012 оны 5 дугаар сарын 25-наас 6 дугаар сарын 15-ны өдрүүдэд тоолох;
2. Тооллогын комиссын баталсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн газрын зургийн дагуу зөвхөн өөрийн хариуцан тоолох хэсгийн тооллогын нэгжийг тоолох;

3. Тоологчийн үнэмлэхийг биедээ байнга авч явж, тоолуулагчид үзүүлж байх;
4. Тооллогын асуулга, бусад маягыг зөвхөн зааврын дагуу үнэн зөв, бүрэн нөхөх;
5. Асуулгад нөхөгдсөн хариултыг “Байгууллагын нууцын тухай” Монгол Улсын хууль, “Хувь хүний нууцын тухай” Монгол Улсын хууль болон “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу нууцлан хадгалах;

### 2.1.2. Тоологчийн гүйцэтгэх ажил үүрэг

Тоологч нь баг, хорооны удирдлагын өдөр тутмын хяналт дор ААНБ, өрхийг тооллогод бүрэн хамруулах, тэдний өгсөн мэдээллийг асуулгад үнэн зөв, бүрэн нөхөх, тооллогын мэдээллийг тогтоосон хугацаанд цуглуулах, материалыг шалгуулж, хүлээлгэн өгөх үндсэн үүрэгтэйгээр ажиллана.

1. Тооллогын ажилтан бэлтгэх сургалтад идэвхтэй оролцож, бүрэн хамрагдах; тооллогын асуулгын асуулт нэг бүрийн агуулга, зорилгыг ойлгох, тоолуулагчид ойлгуулах, асуулга, бусад баримт бичгийг бүрэн, үнэн зөв нөхөх мэдлэг, чадвартай болох;
2. Асуулга, бусад маягт, зааврыг урьдчилан сайн судалж, туршиж, бүрэн эзэмших; өөрийн ойлголтоор болон заавраас өөрөөр дур мэдэн асуулгыг нөхөхгүй байх; ойлгомжгүй болон лавлах зүйл байвал ахлагчаас асууж тодруулах, шаардлагатай гэж үзвэл тухайн шатны тооллогын комисс, тооллогын ажлын хэсгийн ажилтнуудаас асууж, тэдний зааврын дагуу ажиллах;
3. Тооллогын асуулга, бусад маягт болон багцыг тооллогын ажлын хэсгээс нарийн тоолж хүлээн авах, тооллого дууссаны дараа нөхөгдсөн, нөхөгдөөгүйгээр нь ялган асуулга, маягтуудыг анх хүлээж авсан тоотойгоо тохируулан тухайн шатны тооллогын ажлын хэсэгт багцын хамт хүлээлгэн өгөх;
4. Тооллого эхлэхээс өмнө өөрийн хариуцан тоолох ААНБ, өрхийн жагсаалтыг тооллогын комиссын баталсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн газрын зурагтай тулган, хэрэв зөрүүтэй байвал шалгагчид, шаардлагатай гэж үзвэл тухайн шатны тооллогын ажлын хэсэгт мэдэгдэж, зохих шийдвэр гаргуулах;
5. Тоологч тооллого эхлэхээс өмнө өөрийн хариуцсан хэсэгт байгаа ААНБ, өрхүүдийн байршлыг тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн зургийн дагуу тооллогын ажлын хэсгийн гишүүдийн тусламжтайгаар тодруулж, урьдчилан сайтар судлах;
6. Тооллогыг **2012 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн өглөөний 09 цагт** (орон нутгийн цагаар) эхлүүлэх;
7. Тоологчийн үнэмлэх нь тоологчийг ХААТ-ын ажилтан мөн болохын албан ёсны баталгаа болох учраас тооллогын комиссоос олгосон тоологчийн үнэмлэхийг тооллогын хугацаанд биедээ байнга авч явж, өөрийгөө танилцуулахдаа ААНБ, өрхийн гишүүдэд үзүүлэх; тоологчийн үнэмлэхээ гэж үрэгдүүлсэн тохиолдолд хэн нэгэн буруугаар ашиглахаас сэрэмжилж, тэр даруйдаа өөрийн биеэр тухайн шатны статистикийн байгууллага болон цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
8. Нийт ААНБ, өрхийг 10 хоногийн хугацаанд бүрэн тоолж амжихаар, өдөрт нийт тоолох ачааллаа жигд хуваарилж, өдөр тутам тооллогыг хаанаас эхлүүлж, хаана дуусгахыг урьдчилан төлөвлөх;
9. Тоолох үед эзэнгүй байх ААНБ, өрхийг судалж, хэдийд тоолж болох өдөр, цагийг урьдчилан тохиролцох;

10. Тоолох урьдчилан мэдэгдэх хуудас хүргүүлэх, хугацааг товлох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
11. ААНБ, өрхөд орохдоо найрсгаар мэндчилж, тоологчийн үнэмлэхээ үзүүлж, ХААТ-ын талаар яваа зорилгоо танилцуулан асуулга авахдаа асуулт бүрийн учир утгыг тоолуулж байгаа хүнд ойлгуулан, асуултын дараалал болон найруулгыг солихгүйгээр хариултыг үнэн зөв авах; хариулагчийг яаруулж тэвдүүлэхгүй, татгалзах байдалд хүргэхгүйгээр үргэлж эелдэг харьцаж, төлөв даруу, төвийг сахих;
12. Иргэдэд тооллогын зорилго, ач холбогдлыг таниулж, “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу ААНБ, өрх бүр тооллогын асуулгад үнэн зөв, бүрэн хариулт өгөх үүргийг ухуулан таниулах;
13. Тогтоосон өдөр, цагт тооллогын асуулгыг нөхсөн байдлыг ахлагч, багийн засаг даргаар хянуулж, алдаа гарсан тохиолдолд тоолуулагчаас дахин лавлаж засварлах;
14. Тооллогын өдөр тутмын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, тохиолдсон хүндрэл бэрхшээл, түүнийг арилгах талаар санал бодлоо тухайн шатны тооллогын комисс, тооллогын ажлын хэсэгт илэрхийлэх; тооллогыг хугацаанд нь багтааж бүрэн дуусгах талаар идэвх санаачлагатай ажиллах;
15. Асуулгыг цэвэр нямбай, гэмтээхгүй авч явж, асуулга, бусад маягтуудыг тусгай бэлдсэн хавтсанд хадгалах;
16. Тооллого дууссаны эцэст тухайн шатны тооллогын ажлын хэсэгт ажлаа тайлагнаж, дүгнүүлэх, ажлын тайлан боловсруулан хүлээлгэж өгөх;

#### **2.1.3. Тооллогын асуулга, бусад материалын аюулгүй байдлыг хангах**

1. Тооллогын бүхий л хугацаанд тооллогын асуулга, бусад материалыг үрэгдүүлэх, дутах, шатах, устах, гэмтэх, норхохоос сэргийлэх (ажлын явцад болон гэртээ байлгах тохиолдолд);
2. Асуулга авахаар ААНБ, өрхөд орох зэрэг тооллогын материалыг унаа тэргэндээ (машин, мотоцикл, морь, тэмээ г.м) орхих тохиолдолд алдах, гэмтэхээс болгоомжилж, сайтар далдлах, хүлээлгэн өгөх хүртэл тоологч өөртөө хадгалах;
3. Тооллогын нөхөгдсөн асуулгыг тооллогын асуулгын дугаарын дагуу дараалуулан, газрын зураг болон бусад материалуудын хамт шороо тоос, ус нэвтрэхгүй материалаар дөрвөн талаас нь сайтар ороож, архивын хавтсанд хийж аймагт буюу хариуцсан шалгагчид хүлээлгэн өгөхөд бэлтгэх;

#### **2.1.4. Тоологчийн хориглох зүйлс**

1. Асуулгын хариултыг тухайн шатны тооллогын комисс, ажлын хэсгийн ажилтнууд болон шалгагчаас бусад хүнд шилжүүлэх, үзүүлэх, задруулах;
2. Өөрийгөө төлөөлүүлэн бусдыг дур мэдэн ажиллуулах;
3. Тооллогын нөхөгдсөн асуулга бусад материалыг алдаж үрэгдүүлэх;
4. Тооллогын асуулгыг нугалах, үнгэх, урах, тасдах, дутаах, бохирдуулах, гэмтээх;
5. Цэнхэр өнгийн тосон балаас өөр өнгийн балаар асуулгыг нөхөх;

#### **2.1.5. Тоологчийн эрүүл мэнд, аюулгүй байдал**

1. Тоологч эрүүл мэнд болон аюулгүй байдлаа хэвийн байлгах талаар тогтмол анхаарах;

2. Хамгийн ойрын зайд байгаа эмнэлэг болон цагдаагийн байгууллагын утасны дугаарыг тооллогын ажлын хэсгээс авч, шаардлагатай тохиолдолд ашиглах;
3. Тухайн өдрийн цаг агаарт тохируулан хувцаслах;
4. Хэт ганган хээнцэр хувцас, үнэт эдлэлтэй явахгүй байх;
5. Ойр зуур хэрэглэгдэх эм, эмнэлгийн тусламжийн хэрэгслийг биедээ авч явах;
6. Тоолуулагч согтууруулах ундаа хэрэглэсэн эсвэл дарангуйлсан өнгөөр харьцах тохиолдолд цаг хугацаа гаргасанд нь талархлаа илэрхийлэн яаралтай гарч явах, дараа дахин очиж асуулгыг авах;
7. Шөнө ажиллах, тээврийн хэрэгслээр зорчихдоо сэрэмжтэй байх;
8. Гэр хорооллоор явахдаа нохойноос болгоомжлон явах;

## **2.2. Ахлагчийн үүрэг, баримтлах зарчим болон хориглох зүйлс**

- Ахлагч нь аймаг, сумын түвшинд ажиллах бөгөөд аймгийн статистикийн хэлтсийн дарга, сумын төрийн сангийн төлөөлөгч байна.
- Аймагт ажиллах ахлагч нь аймгийн хэмжээнд ХАА-н тооллогыг зохион байгуулах, тооллогын сургалт зохион байгуулах, тоологч, ахлагч, шалгагч нарт заавар, зөвлөгөө өгөх, аргачлал арга зүйгээр хангах, ажилд нь хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Суманд ажиллах ахлагч нь тооллогын ажлыг хугацаанд нь чанартай, бүрэн хамралттай явуулахын тулд тоологч нарын ажилд байнгын хяналт тавьж, асуулгын хариултын үнэн зөв, бүрэн байдлыг хангах, тоологч нараас нөхөгдсөн асуулгыг шалгаж хүлээн авах, шаардлагатай тохиолдолд эргэн тодруулж засуулах, хяналтыг хийхэд оролцох үндсэн үүрэгтэйгээр ажиллана.

### **2.2.1. Ахлагчийн үүрэг**

1. Сум, дүүргийн тооллогын комисс, баг, хорооны тооллогын ажлын хэсгээс өгсөн удирдамж, зөвлөгөө, зааварчилгааг удирдлага болгон ажиллах;
2. Тоологч, шалгагч нарын сургалтад идэвхтэй оролцож, бүрэн хамрагдах, тооллогын асуулга, бусад маягт, зааврыг нэг бүрчлэн сайн судалж, тоологчийн гаргасан алдааг илрүүлж, засуулах, зааварчилгаа өгөх чадвар эзэмшсэн байх;
3. Орон нутагт ХАА-н тооллогын тоологч нарын сургалтыг зохион байгуулахад оролцох, зохион байгуулах;
4. Тооллогын комисс, ажлын хэсгийн дарга, гишүүдийн хамт өөрийн хариуцсан ААНБ, өрхийн жагсаалтыг тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн баталсан зурагтай тулгах; хэрэв зөрүүтэй байвал тодотгол хийх;
5. Тоологч бүрт баталсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн газрын зургийг өгч, танилцуулах;
6. Тооллогын комиссоос баталсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн зургийн дагуу тоологч нар өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулан тоолж байгаа эсэхэд нь хяналт тавих;
7. Иргэдэд тооллогын зорилго, ач холбогдлыг сурталчлахад идэвхтэй оролцох;
8. Тооллогын бэлтгэл ажлын шатанд болон тооллого явуулах, тооллогын материал хүлээн авах үед тоологчтой ажиллах ажлын цагийн хуваарийг нарийвчлан гаргаж, тооллогын ажлын хэсгээр батлуулан тоологчдод танилцуулж, түүнийг мөрдөн ажиллах;

9. Тооллогын эхний өдөр бүх тоологч ажилдаа гарсан эсэхийг шалгаж, хэрэв тоологч ирээгүй бол шалтгааныг тодруулан энэ талаар тухайн шатны тооллогын комисс, ажлын хэсгийн даргад мэдэгдэж, зохих шийдвэрийг гаргуулах;
10. Тоологч тооллогын үед өөрийн нутаг дэвсгэртээ эзгүй байж болзошгүй ААНБ-ын судалгааг гаргасан эсэхийг шалгаж, тэднийг хэдийд, яаж, хаана тооллогод хамруулах талаар тухайн шатны ажлын хэсэгт мэдэгдэж, нэгдсэн арга хэмжээ авахуулах;
11. Асуулга нь тооллогын үр дүнг нэгтгэн гаргахад ашиглах үндсэн баримт болох тул асуулга, бусад маягтыг цэвэр нямбай гэмтээхгүй нөхөх талаар тоологч нарт хяналт тавих, нөхсөн асуулгыг шалгахдаа зааврын дагуу цэвэр нямбай ажиллах;
12. Тухайн шатны тооллогын комисс, ажлын хэсгээс зохион байгуулж явуулах хяналтад биечлэн оролцох;
13. Тооллогын өдөр тутмын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, тохиолдсон хүндрэл бэрхшээл, түүнийг арилгах талаар санал бодлоо тухайн шатны тооллогын комисс, ажлын хэсэгт илэрхийлэх;
14. Асуулга, бусад маягтыг тоологч нарт багцын хамт нарийн тоолж хүлээлгэн өгөх; тооллого дууссаны эцэст нөхсөн, нөхөөгүйгээр нь ялган, шаардлагатай бол асуулга, бусад маягтуудыг дахин нөхүүлж, багцыг хүлээн авч, тухайн шатны ажлын хэсэгт хүлээлгэж өгөх;
15. Асуулгын хариултыг “Байгууллагын нууцын тухай” Монгол Улсын хууль, “Хувь хүний нууцын тухай” Монгол Улсын хууль болон “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу нууцлан хадгалах;
16. Тооллого дууссаны эцэст тухайн шатны тооллогын ажлын хэсэгт ажлаа тайлагнаж, дүгнүүлэх, ажлын тайлан бичиж, хүлээлгэн өгөх;

### **2.2.2. Ахлагчийн хориглох зүйлс**

1. Асуулгын хариултыг тухайн шатны тооллогын комисс, ажлын хэсгийн ажилтнуудаас бусад хүнд шилжүүлэх, үзүүлэх, задруулах,
2. Дур мэдэн хэн нэгнийг өөрийнхөө өмнөөс төлөөлүүлэн ажиллуулах,
3. Нөхөгдсөн асуулгыг алдаж үрэгдүүлэх;
4. Асуулгыг нугалах, үнгэх, урах, тасдах, дутаах, бохирдуулах, гэмтээх;
5. Улаан өнгийн тосон балаас өөр өнгийн балаар асуулгыг засах;

### **2.3. Шалгагчийн үүрэг, баримтлах зарчим болон хориглох зүйлс**

Аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд нь ХАА-н тооллогын материалыг сумдаас хүлээн авах, шалгах, кодлох ажлыг хариуцсан шалгагчаар ажиллана.

#### **2.3.1. Шалгагчийн үүрэг**

1. Тооллогын ажлын хэсгээс өгсөн удирдамж, зөвлөгөө, зааварчилгааг удирдлага болгон ажиллах;
2. Тоологч, шалгагч нарын сургалтад идэвхтэй оролцож, бүрэн хамрагдах, тооллогын асуулга, бусад маягт, зааврыг нэг бүрчлэн сайн судалж, тоологчийн гаргасан алдааг илрүүлж, засуулах, зааварчилгаа өгөх чадвар эзэмшсэн байх;

3. Тооллогын комиссоос баталсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн зургийн дагуу тоологч нар өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулан тоолж байгаа эсэхэд нь хяналт тавих;
4. Иргэдэд тооллогын зорилго, ач холбогдлыг сурталчлахад идэвхтэй оролцох;
5. Тооллогын бэлтгэл ажлын шатанд болон тооллого явуулах, тооллогын материал хүлээн авах үед сумдтай ажиллах ажлын цагийн хуваарийг нарийвчлан гаргаж, тооллогын ажлын хэсгээр батлуулан түүнийг мөрдөн ажиллах;
6. Тоологын материалыг сумдаас тоо ёсоор хүлээн авч шалгах, нөхсөн асуулгыг шалгахдаа зааврын дагуу цэвэр нямбай ажиллах;
7. Тухайн шатны тооллогын комисс, ажлын хэсгээс зохион байгуулж явуулах хяналтад биечлэн оролцох;
8. Асуулга, бусад маягтыг тоологч нарт багцын хамт нарийн тоолж хүлээлгэн өгөх; тооллого дууссаны эцэст нөхсөн, нөхөөгүйгээр нь ялган, шаардлагатай бол асуулга, бусад маягтуудыг дахин нөхүүлж, багцыг хүлээн авч, тухайн шатны ажлын хэсэгт хүлээлгэж өгөх;
9. Асуулгын хариултыг “Байгууллагын нууцын тухай” Монгол Улсын хууль, “Хувь хүний нууцын тухай” Монгол Улсын хууль болон “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу нууцлан хадгалах;
10. Тооллого дууссаны эцэст тухайн шатны тооллогын ажлын хэсэгт ажлаа тайлагнаж, дүгнүүлэх, ажлын тайлан боловсруулж хүлээлгэн өгөх;

### **2.3.2. Шалгагчийн хориглох зүйлс**

1. Асуулгын хариултыг тухайн шатны тооллогын комисс, ажлын хэсгийн ажилтнуудаас бусад хүнд шилжүүлэх, үзүүлэх, задруулах;
2. Дур мэдэн хэн нэгнийг өөрийнхөө өмнөөс төлөөлүүлэн ажиллуулах;
3. Нөхөгдсөн асуулгыг алдаж үрэгдүүлэх, дур мэдэн засах;
4. Асуулгыг нугалах, үнгэх, урах, тасдах, дутаах, бохирдуулах, гэмтээх;
5. Улаан өнгийн тосон балаас өөр өнгийн балаар асуулгыг засах;

## БҮЛЭГ III. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР

Асуулга нь ерөнхий болон үндсэн бүлгээс бүрдэх бөгөөд 11 бүлэг асуултаас бүрдэнэ. Үүнд:

- I. Ерөнхий мэдээлэл
- II. Ажиллах хүч
- III. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт
- IV. Газар, машин, тоног төхөөрөмж
- V. Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламж
- VI. Худаг, усан сан
- VII. Малын хашаа
- VIII. Хөрсний доройтол
- IX. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлэх зарим үйлчилгээ
- X. Хүнсний хангамж
- XI. Ой, ан агнуур, загасны аж ахуйн үйл ажиллагаа

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг нэгжийн хаягийн хэсэг нь тухайн нэгжийг засаг захиргааны аль нэгж эсвэл мал аж ахуйн ямар бүсэд байгааг илэрхийлэхээс гадна мал аж ахуйн тооллогын үр дүнг нэгтгэх үндсэн чухал хэсэг болно. Мөн хаягийн хэсэг нь газар зүйн мэдээллийн системээр тооллогын үр дүнгийн тайланг гаргах болон мэдээллийг бусад эх үүсвэртэй холбоход ашиглагдах юм.

“Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг нэгж” гэдэгт мал аж ахуйг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй эрхэлдэг болон мал аж ахуйн үйлдвэрлэл тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх, ААНБ-ыг хамруулна.

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дугаарыг бичнэ. Тооллогын комиссын дугаарыг **Хавсралт 1** буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харна. Уг дугаар нь хүн ам орон, сууцны тооллогод ашигласан дугаартай ижил байна.

**2. Аймаг, нийслэлийн нэр, код.** Энэ асуултад тухайн аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг **Хавсралт 1** буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**3. Сум, дүүргийн нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг **Хавсралт 1** буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**4. Баг, хорооны нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг **Хавсралт 1** буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**5. Тоологчийн нэр, дугаар.** Тоологч өөрийн нэрийг эцэг/ эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө: **Тоологчийн нэр, дугаар** гэсэн мөрийн 2 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрвээ 1 оронтой дугаар бол “01” гэх мэтчилэн өмнөх оронг “0” тавьж гүйцээнэ. Тоологчийн дугаарыг сум, дүүрэг дотроо 1-ээс эхлэн дугаарлана. **Жишээ нь:** тухайн сум, дүүрэгт 5 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-05 хүртэлх дугаар өгнө, 2 дугаар сум, дүүрэгт 10 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-10 хүртэлх дугаар өгнө.

**6. Тооллогын асуулгын дугаар.** Тооллогын асуулгын дугаарыг тоологч бүр тоолж эхэлсэн эхний өрхөөс эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Хэрэв тухайн тоологч 2 багт ажиллах бол асуулгын хуудсыг баг тус бүрд 1-ээс эхлэн дугаарлана.

Тоологч тооллогын асуулгын дугаарыг давхардуулан олгож болохгүй.

**7. Шалгагч, кодлогчийн нэр, код.** Сумын түвшинд тоологчоос тооллогын материалыг багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч шалган хүлээж авна. Аймгийн түвшинд аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд сумдын тооллогын материалыг хүлээн авч, шалгах, кодлох ажлыг хийнэ.

Шалгагч, кодлогч асуулгын хуудсыг шалгах аас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 1 оронтой дугаар бол “01” гэх ба өмнөх оронг “0” тавьж гүйцээж бичнэ. Шалгагч асуулгын хуудсыг үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон алхамыг зөв хийсэн эсэхийг хянаж, алдааг засварлана. Кодлохдоо аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, тоологч, шалгагч, гудамж, хороолол, бүсчлэл, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн зэрэг кодлолтыг хавсралтыг ашиглаж нөхнө.

**8. Шивэгчийн нэр, дугаар.** Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Шивэлтийг ҮСХ хариуцан хийх учраас шивэгч бүрт тусгайлан код давхардуулахгүйгээр олгоно.

**9. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар.** Өрх бүр дээр хөтлөгддөг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр дээр нөхөгдсөн 12 оронтой дугаарыг авч бичнэ. Өөрөөр хэлбэл хүн ам, өрхийн бүртгэлийн дугаар буюу 2011 онд хэрэглэгдэж байсан хуучин өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаартай ижил байна.

“Өрх гэдэг” нь **(а)** өөрийн амьжиргаанд шаардлагатай хоол хүнсний болоод бусад хэрэгцээгээ өөр хүмүүс болон өөр өрхийн гишүүдтэй хамтралгүйгээр хангаж байгаа нэг хүнтэй өрх **(б)** хоёр, түүнээс дээш эсвэл хэсэг бүлэг хүмүүс хамтран өөрийн амьжиргаанд шаардлагатай хүнсний болоод бусад хэрэгцээгээ хангаж байгаа олон хүнтэй өрхийн аль, алинийг хэлнэ. Өрхийн гишүүд нь орлогоо нийлүүлдэг, нэг төсөвтэй, гэхдээ тэд хууль ёсны хамаатнууд ч байж болно, бас биш ч байж болно.

## **1.2 ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт тооллогод хамрагдаж байгаа өрхийн тэргүүлэгчийн талаарх мэдээллийг асууж нөхнө.

**10. Эцэг (эх)-ийн нэр.** Тухайн өрхийн тэргүүлэгчийн эцэг (эх)-ийн нэрийг асууж, нөхнө.

**11. Өрхийн тэргүүлэгчийн нэр.** Өрхийн тэргүүлэгчийн нэрийг асууж нөхнө.

**12. Өрхийн тэргүүлэгчийн регистрийн дугаар.** Өрхийн тэргүүлэгчээс иргэний үнэмлэхийн регистрийн дугаарыг асууж, нөхнө.

**13. Хүйс.** Энэ асуулт ХАА-н үйлдвэрлэл дэх жендерийн байдлыг судлах ялангуяа, ХАА-н үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийг үнэлэх чухал үзүүлэлт болно. Энэ асуултын хариултыг нөхөхдөө өрхийн тэргүүлэгчийн хүйсийг эрэгтэй гэж 1, эмэгтэй гэж 2 гэсний аль тохирох кодыг дугуйлна.

**14. Нас (бүтэн жилээр).** Өрхийн тэргүүлэгчийн насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь тооллого явагдаж байгаа жилээр гүйцэд тооцож тогтооно.

**15. Боловсролын түвшин.** Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшинг асууж, боловсролын түвшинд тохирох кодыг сонгон дугуйлна.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол** - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/** - Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**16. Ажилласан жил.** Өрхийн тэргүүлэгчийн ажилласан жилд тухайн хүний хөдөлмөр эрхэлж эхэлсэн үеэс судалгаа авч байгаа үе хүртэлх хугацааг оруулна. Дээрх хугацаанд хөдөлмөр эрхлээгүй үе гарвал тус хугацааг ажилласан жилд оруулахгүй. Ажилласан нийт жилийг бүтэн жилээр нөхнө.

**1. Бүгд.** Улсад ажилласан бүх жилийг бүтэн жилээр нөхнө.

**2. Үүнээс: Мал аж ахуйн салбарт.** Нийт ажилласан хугацаанаас Мал аж ахуйн салбарт ажилласан нийт жилийг асууж нөхнө. Зөвхөн мал аж ахуйн салбарт ажиллаж ирсэн бол ажилласан жил нь “Мал аж ахуйн салбарт ажилласан жил”-тэй тэнцүү байна.

**17. Та дараах даатгалд хамрагдсан уу?** Тухайн өрхийн тэргүүлэгчээс эрүүл мэндийн, нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг эсэхийг асууж, тохирох хариултыг нөхнө.

**18. Ам бүлийн тоо.** Тухайн өрхийн ам бүлийн тоог асууж нөхнө.

**19. Үүнээс 16 хүртэлх насны хүүхдийн тоо.** Тухайн өрхийн 16 хүртэлх насны хүүхдийн тоог асууж нөхнө. 16 хүртэлх насны хүүхдийн тоо нь ам бүлийн тооноос бага буюу тэнцүү байна.

**20. Танайх ямар төрлийн сууцанд амьдардаг вэ?** Тухайн өрх, хүн амын амьдарч байгаа бүх төрлийн орон байр, сууц багтана. Тухайн өрхийн амьдарч байгаа сууцны төрлийг асууж, тохирох хариултыг нөхнө.

**Гэр** – Бүх төрлийн монгол гэр, цаатны урц хамаарагдана.

**Байшин** - Байшинд нэг болон олон өрөөтэй дээвэртэй, гадуураа ханатай, сууринаас дээвэр хүртэл ханаас хуваагдсан талбай бүхий орон байр багтана. Байшинд орон сууны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин (гэр хорооллын хашаа болон өвөлжөө, хаваржаанд барьсан шавар болон модон ханатай сууцны байшин) нийтийн болон нийтийн бус зориулалтын бусад байр орно.

**Зориулалтын бус сууц** - Анхнаасаа хүн амьдрахад зориулж бариагүй эсвэл хүн амьдрахад засаж тохижуулан өөрчилсөн, хүн амьдарч байгаа сууцыг хамруулна. Жишээ нь: вагончик, амбаар, агуулах, дэлгүүр гэх мэт.

**Бусад сууц** - Дээрх 3 төрлийн сууцанд хамаарагдаагүй хүн амьдарч байгаа бүх төрлийн сууцыг хамруулна.

**21. Танай сууцны цахилгааны эх үүсвэр юу вэ?** Тухайн өрхийн цахилгааны эх үүсвэрийг төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр, цахилгааны эх үүсвэргүй гэсэн ангиллаар асууж бүртгэнэ.

Тухайн өрх хэд хэдэн цахилгааны эх үүсвэртэй байж болох бөгөөд цахилгааны **үндсэн эх үүсвэрийн** талаар асууж, тохирох кодыг дугуйлна.

**Төвлөрсөн систем** - Улсын цахилгаан болон усан станцаас цахилгаан хэрэглэж байвал тухайн сууцыг төвлөрсөн системтэй гэж үзнэ. Төвлөрсөн цахилгаан станцад холбогдсон дэд станцыг төвлөрсөн гэж үзнэ. Говь-Алтай, Завхан аймгаас бусад аймгийн хувьд төвлөрсөн системтэй гэж үзнэ.

**Дизель станц** - Тухайн орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон болон цахилгааны сүлжээтэй холбогдсон орон сууцыг хамруулна.

**Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж** - Нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч бий болгодог төхөөрөмжийг хамруулна.

**Бага оврын цахилгаан үүсгүүр** - Тухайн өрх нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг үүнд хамруулна.

**Цахилгааны эх үүсвэргүй** - Тухайн өрх цахилгаан огт хэрэглэдэггүй бол цахилгааны эх үүсвэргүйд хамруулна.

**22. Танай ундны эх үүсвэр юу вэ?** Тухайн өрхийн ундны эх үүсвэрийг тодорхойлоход энэ үзүүлэлт чухал юм. Ундны усыг төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, хамгаалагдсан худаг, хамгаалагдсан булаг, шанд, цэвэршүүлэн савласан ус, төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр, зөөврийн ус, гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд гэсэн ангиллаар асууж бүртгэнэ. Хэрэв тухай өрх нь ундны усаа олон эх үүсвэрээс хангадаг бол ихэвчлэн хэрэглэдэг **үндсэн гол үүсвэрийг сонгож**, тохирох кодыг сонгож, дугуйлна.

**Төвлөрсөн систем** - Улсын болон тухайн орон нутгийн усан хангамжийн төвлөрсөн системээс бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, орон сууцны байшин, нийтийн болон нийтийн эзэмшлийн бусад байранд төвлөрсөн байдлаар ус түгээж байгаа усны системийг хэлнэ.

**Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр** - Хот суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон ус түгээх байр орно.

**Хамгаалагдсан худаг** - Зураг төслийн дагуу баригдсан мотор буюу бусад төхөөрөмжөөр усаа шууд авдаг, дээгүүрээ байгууламжтай, эрүүл ахуйн бүс тогтоож хашсан, хамгаалалтанд байдаг, мал амьтан орх боломжгүй худгийг хамруулна. Үүнд өрөмдмөл гүний худаг орно.

**Хамгаалагдсан булаг, шанд** - тусгай хамгаалалтад байдаг, засаж тохижуулсан, хашиж хамгаалсан, мал, амьтан орох боломжгүй булаг, шандыг хамгаалагдсан гэж үзнэ.

**Цэвэршүүлэн савласан ус** - Аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн цэвэршүүлэн савласан ундны зориулалтаар бэлтгэгдсэн усыг хэлнэ.

**Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр** - Эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн зориулалтын авто машинаар ус түгээх байрт зөөвөрлөн түгээдэг байр багтана.

**Зөөврийн ус** - Эрх бүхий байгууллага, хувийн аж ахуйн нэгж, иргэд хувиараа машин болон ердийн хөсгөөр айл өрхөд шууд зөөвөрлөн түгээдэг бол энд орно.

**Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд** - Иргэд өөрсдөө ухаж гаргасан, хамгаалалтгүй уурхайн худаг, булаг, шанд орно. Мөн гол, мөрөн, нуур, бороо, цасны болон тогтоол усыг хамруулна.

Хэрэв тухайн өрх нь ундны усаа төвлөрсөн системээс авдаг бол **Асуулт 25 руу** шилжинэ.

**23. Танайх ундны усаа хэр холоос зөөвөрлөдөг вэ?** - Ундны усны эх үүсвэр нь төвлөрсөн системээс бусад эх үүсвэрээр хангагддаг бол ундны усандаа хүрэх зайг өвөл, зун, хавар, намрын улирал тус бүрээр тухайн өрхийн гишүүний тооцоолсноор ойролцоогоор асууж нөхнө. Зайг метрээр асууж бүртгэнэ.

**24. Танайх ундны болон ахуйн хэрэглээний усаа хэрхэн зөөвөрлөдөг вэ?** Тухайн өрхийн ундны усаа зөөвөрлөж байгаа байдлыг “Явганаар”, “Ердийн хөсгөөр”, “Өөрийн машин, мотоциклоор”, “Бусад” гэсэн ангиллаар, хавар, зун, намар, өвлийн улирлаар асууж нөхнө. Голлон зөөвөрлөдөг хэлбэрээ сонгоно.

**Явганаар** - ундны усаа ойролцоох худаг, гол, нуур зэргээс бидон, хувин, саваар зөөвөрлөхийг;

**Ердийн хөсгөөр**- Тэмээ, морь, үхэр тэрэг ашиглан ундны усаа зөөвөрлөхийг;

**Өөрийн машин, мотоциклоор** – Өөрийн эзэмшлийн машин, мотоциклоор зөөвөрлөхийг;

**Бусад** - Ундны усаа зөөвөрлөх дээрх гурван ангилалд багтаагүй хэлбэрээр ус зөөвөрлөхийг хэлнэ.

### **I.3 ӨРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**25. Танайх 2011 онд мал аж ахуйгаас бусад ямар чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн бэ?** Тухайн өрхөөс мал аж ахуйгаас бусад чиглэлийн ямар үйл ажиллагаа үйл эрхэлснийг асууж нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

Бусад үйл ажиллагааны чиглэлийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн, эсвэл борлуулалтын өндөр орлоготойгоос бага руу нь дараалуулах аргаар тодорхойлно. Тухайлбал: Тухайн өрх мал аж ахуйгаас гадна газар тариалан, худалдааны үйл ажиллагаа давхар эрхэлдэг бол худалдаа эрхэлснээс олсон орлого нь газар тариалангийн бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогоос их байвал эхлээд худалдаа, дараа нь газар тариалан гэж дараалуулан бичнэ.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийнзасгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC-4.0) хувилбарын дагуу номноос (кодлогч) нөхнө.

**26. Та малын тоогоо 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Тухайн өрхийн 2011 оны жилийн эцэст тоолуулсан малын тоог бүгд дүн, таван төрлөөр асууж бүртгэнэ. Малын тоог жилийн эцсийн мал тооллогын дүнг тулгах, мэдээллийг холбоход ашиглах зорилгоор оруулсан учраас үнэн зөв бөглөхөд сайтар анхаарна.

**27. Танайх ямар хэлбэрийн мал аж ахуй эрхэлдэг вэ?** Тухайн өрхөөс уламжлалт, эрчимжсэн, холимог мал аж ахуйн аль төрлийг эрхэлдгийг асууж, тохирох хариултыг нөхнө.

**Уламжлалт** - Уламжлалт аргаар нүүдлийн мал аж ахуй эрхэлж байгаа өрхийг хамруулна.

**Эрчимжсэн** - Ашиг шимт үүлдэр, хэвшлийн мал, тэжээвэр амьтныг суурин болон хагас суурин байдлаар технологийн дагуу маллан үйлдвэрлэл эрхэлж, бүтээгдэхүүнээ төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлдэг өрхийг хэлнэ.

**Холимог** - Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан эрхэлж буй өрхийг хэлнэ.

## II. АЖИЛЛАХ ХҮЧ

**28. Танайх 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан эсэхийг асууж хөлсөлсөн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, хөлслөөгүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлна. Жишээлбэл: туслах малчин, саальчин, ажилчин зэргийг аж ахуйдаа тодорхой хугацаанд хөлслөн ажиллуулсан байж болно. Мөн цалин хөлс авдаг байнгын ажиллагчид орно.

**29. Танайх байнгын ажиллагчидтай юу?** Тухайн өрх байнгын ажиллагчидтай эсэхийг асууж нөхнө. Малчин өрхийн ядаж 1 гишүүн нь байнгын ажиллагч байна.

**30. Байнгын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Байнгын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**Байнгын ажиллагчид** гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хэлнэ (“Хөдөлмөрийн тухай” хуулийн 3.1.15.).

Ажиллагчдын тоонд өрхийн тэргүүлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, захирал орно. Мөн өрхийн гишүүд аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байвал ажиллагчдын тоонд оруулна. Харин ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй.

**31. Байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж

хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр хавар, зун, намар, өвлийн улирлаар асууж нөхнө.

**32. Байнгын ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын тоог хүснэгтэд заасан насны ангиллаар, хүйсээр задлан асууж нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр8)
- Насаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь насаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1>=багана2)

**33. Байнгын ажиллагчдын тоо, гэрлэлтийн байдал, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын тоог гэрлэлтийн байдлаар 4 ангилалд хуваан асууж бүртгэнэ.

**Гэрлэсэн/хамт амьдардаг** – Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг энд хамруулна. Мөн гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч /хугацаа харгалзахгүйгээр/ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хамруулна.

**Огт гэрлэж байгаагүй** – Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

**Тусгаарласан/цуцалсан** – Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүмүүсийг “тусгаарласан” гэнэ. Тусдаа амьдардаг гэдэгт амьжиргааны болон бусад нөхцөлөөр тусдаа амьдардаг /жишээлбэл: эхнэр, нөхрийн аль нэг нь гадаадад амьдардаг, хүүхдүүдээ сургуульд суулгахын тулд сумын төвд хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг гэх мэт/ тохиолдлуудыг оруулахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлээгүй хүмүүсийг “цуцалсан” гэнэ.

**Бэлбэсэн** – Эхнэр юмуу нөхөр нь нас барснаас хойш дахин гэрлээгүй бол “бэлбэсэн” гэж үзнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)
- Гэрлэлтийн байдлаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь гэрлэлтийн байдлаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1>=багана2)

**34. Байнгын ажиллагчдын тоо, боловсролын түвшин, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын тоог боловсролын түвшингээр асууж бүртгэнэ. Боловсролын түвшинг ойлголт, тодорхойлолтын дагуу харж нөхнө.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол** - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/** - Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Боловсролын түвшингээр задалсан дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр10)
- Боловсролын түвшингээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь боловсролын түвшингээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.

(багана1)>=багана2

**35. Байнгын ажиллагчдаас мэргэжлийн ажиллагчдын тоо, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн мэргэжлийн ажиллагчдын тоог хүснэгтэд өгөгдсөн ангиллаар асууж, бүртгэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Мэргэжлийн ажиллагч тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)
- Мэргэжлээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь мэргэжлээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.

(багана1)>=багана2)

**36. Танайх улирлын ажиллагчидтай юу?** Тухайн өрхийг улирлын ажиллагчидтай эсэхийг асууж, улирлын ажиллагчидтай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ажиллагчидгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 39 руу** шилжинэ.

**Улирлын ажиллагчдад** улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хамруулна.

**37. Улирлын ажиллагчдыг тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Тухайн өрхийн улирлын байнгын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**38. Улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн өрхийн улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь тооцоолон хэлснээр, улирлаар асууж нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**39. Танайх түр ажиллагчид 2011 онд авч ажиллуулсан уу?** Тухайн өрх нь 2011 онд түр ажиллагч авч ажиллуулсан эсэхийг асууж, бүртгэнэ. Хэрэв түр ажиллагч авч ажиллуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлж, хөлслөөгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 42 руу** шилжинэ.

**Түр ажиллагчдад** хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг хамруулна.

**40. Түр ажилласан ажиллагчдын тоог хэлнэ үү.** Тухайн өрхийн түр ажиллагчдын тоог 2011 оны байдлаар асууж нөхнө.

**41. Түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн өрхийн түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр, улирлаар асууж нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**42. Танайд ажиллах хүчтэй холбоотой дараах хүндрэл, бэрхшээл тулгарч байна уу?** Энэ асуулт нь ажиллах хүчинтэй холбогдолтойгоор үүссэн хүндрэлийг тодорхойлох зорилготой.

Тухайн өрхийн хувьд гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг хүснэгтэд тавигдсан "Ажиллах хүч дутагдалтай", "Мэргэжлийн ажиллах хүч дутагдалтай", "Ажиллах хүчний тогтвор суурьшил муу", "Ажиллагчдын ажлын хариуцлага сул", "Өндөр цалин хөлс шаарддаг", "Ажиллах нөхцөл, ажлын байрны тухтай байдал хангагдаагүй", "Бусад" гэсэн ангиллаар асууж нөхнө. Хэрэв дурдсан хүндрэл, бэрхшээл тулгардаггүй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, тулгардаг бол Үгүй гэж 2-ыг дугуйлна. Бусдад хүснэгтэд дурдснаас өөр бусад хүндрэл, бэрхшээлийг оруулна.

### **III. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ**

**43. Хөдөө аж ахуйн гаралтай 2011 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг 2011 оны байдлаар асууж нөхнө.

Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүний хэрэглээ, зарцуулалтыг (борлуулсан, өөртөө хэрэглэсэн, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн, бусад) хүснэгтэд нэр заан өгсөн мал аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрлөөр асууж бүртгэнэ. Нийт

үйлдвэрлэлт нь “Борлуулсан”, “Өөртөө хэрэглэсэн”, “Ажиллагчдад цалин хөлсөнд олгосон”, “Нөөцөлсөн” болон “Бусад” гэсэн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна.

“Бусад” гэдэгт тухайн өрх үр хүүхэд, хамаатан садангийнхаа болон бусдын хэрэглээнд зориулан үнэ төлбөргүйгээр нийлүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт орно. Жишээ нь: оюутан хүүхдийн хүнсэнд зориулж өгсөн мах, мал, сүү гэх мэт.

Бүртгэхдээ хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжийг сайтар анхаарна. Хариулагч хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжээс өөрөөр хэлсэн тохиолдолд тавигдсан нэгж рүү шилжүүлэхдээ итгэлцүүрийг ашиглана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тухайн өрхөөс асуух замаар, сайтар ярилцаж бүртгэнэ.

$1 \text{ кг} = 1000 \text{ г}$	$1 \text{ т} = 1000 \text{ кг}$	$1 \text{ л} = 1.03 \text{ кг}$
---------------------------------	---------------------------------	---------------------------------

Хүснэгтэд нэр зааснаас өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бол 35-37 дугаар мөрөнд нөхөж бичнэ.

**Дараах балансын шалгалтыг хийнэ.** Үүнд:

- Нийт үйлдвэрлэлт нь борлуулсан, өөртөө хэрэглэсэн, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн болон бусад бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна. (багана1=багана2:багана7)
- Махны төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт үйлдвэрлэсэн махтай тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр9)
- Арьс, ширний төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт үйлдвэрлэсэн арьс, ширтэй тэнцүү байна. (мөр28=мөр29:мөр33)

Айрганд гүүний айраг, үхрийн айраг, ямааны айраг, ингэний айраг буюу ундаа зэргийг, үслэг арьсанд минж, булга, үнэгний арьс зэрэг ангийн арьсыг хамруулна.

**44. Танайх 2011 онд мал борлуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд мал борлуулсан эсэхийг асууж, борлуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлна, борлуулаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 46 руу** шилжинэ.

**45. Танайх 2011 онд борлуулсан малын тоогоо хэлнэ үү.** Тухайн өрхийн 2011 онд борлуулсан малын тоог асууж, толгойн тоогоор нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Малын тооны төрөл тус бүрийн дүн нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр6)

**46. Танайх бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг вэ?** Тухайн өрх үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж байгааг “Хувь хүн ирж авдаг”, “Мах, сүү, ноос бэлтгэлийн компанид”, “Зах зээлд өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Борлуулалтыг нөхөхдөө хамгийн их борлуулалт хийдэг 3-аас илүүгүй хэлбэрийг дугуйлна.

Бүтээгдэхүүнээ хөдөөд ярьж заншснаар өрх, хувь хүнд борлуулсан бол “Хувь хүн ирж авдаг”, мах, ноос бэлтгэдэг компанийн төлөөлөгчид борлуулсан бол “Мах, ноос, сүү бэлтгэлийн компанид”, сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол “Зах зээлд өөрсдөө борлуулдаг” гэсэн сонголтыг хийнэ. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол “Бусад” гэсэн ангилалд оруулна. Бусад хэлбэр байвал нөхөж бичнэ.

**47. Танай бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой гардаг хүндрэлээ хэлнэ үү.** Тухайн өрхийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад гарч байгаа хүндрэлийг “Борлуулалт удаашралтай”, “Хэрэглэгч цөөн”, “Өрсөлдөгч олон”, “Үнэ хямд”, “Бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай”, “Зах зээлээс алслагдсан”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж нөхнө. Хүндрэлийг нөхөхдөө хамгийн их тохиолддог 3-аас илүүгүй хүндрэлийг сонгоно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**48. Танайх бүтээгдэхүүнийхээ үнийг хэрхэн тогтоодог вэ?** Тухайн өрхийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнээ хэрхэн тогтоож байгааг “Зардал дээр ашгийг нэмэх замаар”, “Хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр”, “Өрсөлдөгчийн үнээс хамаарч”, “Зах зээлийн үнэ, ханшаар”, “Бусад” гэсэн төрлөөр асууж нөхнө. Үнэ тогтоодог бусад арга байвал нөхөж бичнэ. Үнэ тогтоодог 3-аас илүүгүй аргыг сонгоно.

#### **IV. ГАЗАР, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

**49. Танайх өөрийн өмчлөлийн газартай юу ?** Тухайн өрх нь газар өмчилж авсан эсэхийг асууж, өмчилж авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, өмчилж аваагүй бол бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 52 руу** шилжинэ.

**50. Газрын үнэлгээгээ хэлнэ үү.** Тухайн өрхийн өмчилж авсан газрын үнэлгээг асууж, сая төгрөгөөр нөхнө. Үнэлгээг тухайн хариулагчийн баримжаалан хэлснээр бүртгэж авна.

**51. Газрын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн өрхийн өмчилж авсан захиран зарцуулах эрх бүхий газрын хэмжээг асууж нөхнө. Хэмжээг га-гаар илэрхийлнэ.

Га-д шилжүүлэхдээ дараах итгэлцүүрийг ашиглана:

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000м <sup>2</sup>	=	1 га

**52. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй юу?** Тухайн өрхийг хөдөө аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй эсэхийг асууж машин тоног төхөөрөмжтэй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, машин тоног төхөөрөмжгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг V** руу шилжинэ.

**53. Хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийнхөө талаарх мэдээллийг хэлнэ үү.** Машин тоног, төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн болон түрээсэлсэн ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоо, төрөл тус бүрээр нь нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжид** өөрийн, хамтын эзэмшлийнх болгосон эсвэл зээл болон лизингээр худалдаж авсан машин, тоног төхөөрөмжийг оруулна.

**Түрээсэлсэн машин, тоног төхөөрөмжид** төрийн байгууллагаас болон бусдаас түрээсэлсэн, төлбөртэй болон төлбөргүйгээр зээлж ашигласныг энд оруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанд** тухайн машин, тоног төхөөрөмжийг худалдаж авснаас хойш хэдэн жил болж байгаа хугацааг бүтэн жилээр илэрхийлж, нөхнө. Хэрэв өрх 1-ээс илүү нэгэн төрлийн машин, тоног төхөөрөмжтэй бол ашиглалтанд орсон хугацааг дундажлаж нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг бүртгэхдээ** тухайн өрхийн хэлснээр бүртгэж авна. Хөрөнгийн үнэлгээг **мянган төгрөгөөр** илэрхийлнэ.

Тухайн өрхийн ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийг дараах жагсаалтаас харж, хүснэгтэд тохирох кодыг тавина.

**Машин, тоног төхөөрөмжийн код:**

Сэрээ	01	Пресслэгч машин	09	Дугуйт трактор (139-275 м.х)	17	Саалтуур аппарат	25
Бага оврын тракторын хадуур	02	Нуруулдагч	10	Дугуйт трактор (275-аас дээш м.х)	18	Сүүний машин	26
Морин хадуур	03	Чиргүүл	11	Морин тэрэг	19	Цецгий цохигч машин	27
Бусад хадуур	04	Гинжит трактор	12	Үхэр тэрэг	20	Хөргэгч	28
Бага оврын тракторын тармуур	05	Явган трактор, тоног төхөөрөмжийн иж бүрдлийн хамт (10 м.х-ээс бага)	13	Тэмээн тэрэг	21	Хонины ноос хяргагч машин	29
Морин тармуур	06	Бага оврын дугуйт трактор (10-20 м.х)	14	Суудлын машин	22	Бусад төхөөрөмж	30
Бусад тармуур	07	Дунд оврын дугуйт трактор (25-60 м.х)	15	Ачааны машин	23		
Хаман боогч	08	Зүтгэх хүчний дугуйт трактор (80-130 м.х)	16	Мотоцикл	24		

**V. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ**

**54. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын барилга, байгууламжтай юу?** Тухайн өрхөөс ХАА-н зориулалтын барилга, байгууламжтай эсэхийг тодруулан асууж, байгаа бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, Үгүй бол 2-ыг дугуйлж, **Бүлэг VI** руу шилжинэ.

**55. Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийнхаа талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн өрхийн ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн талаарх мэдээллийг асууж нөхнө. ХАА-н барилга, байгууламжийг тоо, ширхэг, багтаамжаар бүртгэж, эзэмшлийн төрлөөр нь ашиглаж байгаа, бусдад түрээслүүлсэн, ашиглахгүй байгаа гэсэн ангиллаар бүртгэнэ. Мөн бусдаас түрээсэлсэн хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн тоог асууж нөхнө.

ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн ашигласан хугацаа, хөрөнгийн үнэлгээг нэр төрлөөр, асууж бүртгэнэ. Хөрөнгийн үнэлгээг мянган төгрөгөөр илэрхийлнэ. Үнэлгээг бүртгэхдээ өрхийн гишүүний хэлсэн үнэлгээгээр нь нөхнө.

Барилга, байгууламжийн ашигласан хугацааг ижил зориулалтын барилга, байгууламжийн хувьд ашигласан хугацааг дундажлаж нөхнө. Жишээлбэл: 3 зоорьтой бол ашигласан жилийг гаргахдаа зоорь тус бүрийн ашигласан хугацааг нэмж, 3-т хуваан арифметик дунджийг олж, нөхнө.

Тухайн өрхийн ХАА-н зорилгоос бусад зорилгоор ашигласан орон сууцны бус барилга, байгууламжийг энд оруулахгүй.

Дээрх үзүүлэлтүүдийг “Албан газрын зориулалттай барилга”, “Хүлэмж”, “Агуулах”, “Зоорь”, “ХАА-н техник хадгалах байгууламж”, “Малын хашаа”, “Зориулалтын технологийн байр, ферм” гэсэн ангиллаар асууж бүртгэнэ.

Агуулахад өвс болон бусад материалыг хадгалах зориулалтаар мод, чулуу, тоосго, брезент, блок зэргийг ашиглан барьсан ХАА-н үйлдвэрлэлийн барилгыг хамруулна.

Зооринд төмс, хүнсний ногоо, мах хадгалах зориулалтаар газар ухаж гаргасан байрыг оруулна. Мөн төмс, хүнсний ногоог хүлээн авах, ялгах үйл ажиллагааг техникээр

гүйцэтгэдэг, хадгалалтын горимыг автоматаар тохируулах боломжтой механикжсан зоорь, гар аргаар газар ухаж, дулаалга хийсэн энгийн зоорь, гэр, сууцны дотор талд мөн газар ухаж гаргасан нүхэн зоорь, мөн газрыг цооноглон ухаж хадгалах тасалгаа хийсэн нүхэн зоорийг зооринд тус тус хамруулна. Зоорь нь дангаараа төмс, хүнсний ногоо, махны мөн холимог байдлаар төмс, хүнсний ногооных гэсэн хэлбэрээр байж болно.

Дээр нэр дурдсанаас бусад төрлийн ХАА-н зориулалтын барилга, байгууламж байвал 12-14 дүгээр мөрөнд нөхөж бичнэ.

Хонин толгойд шилжүүлэхэд дараах итгэлцүүрийг ашиглана:

1 тэмээ	=	5 хонь	1 хонь	=	1 хонь
1 адуу	=	7 хонь	1 ямаа	=	0.9 хонь
1 үхэр	=	6 хонь			

## VI. ХУДАГ, УСАН САН

**56. Танайх өөрийн эзэмшлийн худаг, усан сантай юу?** Тухайн өрх өөрийн эзэмшлийн худаг, усан сантай эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх нь эзэмшлийн худаг, усан сантай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Өөрийн эзэмшил худаг, усан сангүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг VII руу** шилжинэ.

**57. Худаг, усан сангийнхаа талаарх мэдээллийг хэлнэ үү.** Тухайн өрхийн эзэмшилд байгаа худаг, усан сангийн тоо, усан сангийн багтаамжийг байршил, ашиглалтын хэлбэрээр асууж, нөхнө.

Дундын эзэмшлийн худагтай тохиолдолд худгийн паспорт эзэмшиж буй өрхөд худаг тоологдохыг анхаарна. Худгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

**Өрөмдмөл худаг (гүний)** - Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор өрөмдөж, ханыг нь бэхэлж байгуулсан, босоо цооногийн уст үед байрлуулсан, ус шүүж оруулах яндан шүүртэй, дотор талдаа усны шахуурга, ус дамжуулах хоолойтой инженерийн байгууламжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл харьцангуй голч /150, 200, 250, 300, 350, 400 мм /-той, 30 метрээс доош гүнтэй цооног бүхий цахилгаан буюу дизель хөдөлгүүртэй ус өргүүртэй худгийг өрөмдмөл худаг гэнэ.

**Богино яндант худаг** - Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор том голчоор өрөмдөж ханыг нь 1м голч урттай бетон цагиргийг давхарлан 3м гүнд суулгасан, түүнээс доош 30м хүртэл гүнд бага голчтой цооног өрөмдөж төхөөрөмжилсөн өрөмдмөл худгийн зохион байгуулалттай ижил инженерийн байгууламжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл харьцангуй бага голч /150, 200, 250 мм /-той, 30 метр хүртэл гүнтэй цооног бүхий худгийг богино яндант худаг гэнэ.

**Энгийн уурхайн /гар худаг/** - Хөрс, геологийн тогтолцоог ажиглаж судалсны үндсэн дээр хөрсний өнгөн хэсэгт ус байх магадлал бүхий газарт 8м хүртэл гүн ухаж гаргасан цооногийн ханыг мод, чулуу зэрэг материалаар хашиж бэхэлсэн худгийг хэлнэ.

**Усан сан** гэж улс, орон нутгийн хүчээр баригдсан 4 ба түүнээс дээш куб м багтаамжтай мал услах талбай, онгоцтой усалгааны цэгийг хэлнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нийт худгийн тооноос бэлчээрт байршдаг болон ашигладаггүй худгийн тоо нь сугарч харагдах бөгөөд дүнд барихгүй. (багана1>=багана3), (багана1>=багана4)

- Өрөмдлөгийн, богино, яндант, энгийн уурхайн, бусад төрлийн худгийн дүнгийн нийлбэр нь худгийн бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)

## VII. МАЛЫН ХАШАА

**58. Танайх өөрийн эзэмшлийн малын хашаатай юу?** Тухайн өрх өөрийн эзэмшлийн малын хашаатай эсэхийг, хариултыг нөхнө.

Тухайн өрх эзэмшлийн малын хашаатай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Өөрийн эзэмшлийн малын хашаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг VIII руу** шилжинэ.

**59. Өөрийн эзэмшилд байгаа малын хашааныхаа тоог хэлнэ үү.** Өөрийн эзэмшилд байгаа бүх төрлийн малын хашааныхаа тоог хашааныхаа төрлөөр нөхнө. Өөрийн эзэмшилд байгаа малын хашааны тоо нь асуулт 55-ын 10 дугаарт тавигдсан малын хашааны тоотой тэнцүү байна.

Малын нийт хашаа, үүнээс дулаалгатай, саравчтай, саравчгүй, бодын хашааг нөхөхдөө өвөл, хаврын улиралд бэлчээрийн тохиромжтой газарт баригдсан, удаан хугацаанд ашиглагдах бэлэн хашааг тоолж, нөхнө. Харин баригдаж дуусаагүй, хөрсөнгөөр баригдсан, түр зуурын ашиглалттай буюу нүүдлийн чанартай хашааг оруулахгүй.

**Саравчтай хашаа** - гурван тал буюу тал дугуй ханан хашаанд саравчин дээвэр тавьсан, хана нь завсаргүй дулаалагдсан байхаас гадна саравчны өмнө талд мал нарлуулах буюу тэжээх талбайтай баригдсан хашааг хэлнэ.

**Саравчгүй хашаа** - дээвэргүй дөрвөлжин буюу тал дугуй, бүрэн дугуй маягийн хэлбэртэй хашааг оруулна.

**Бодын хашаа** – бод малын хашааг тусад нь салган харуулна. Багтаамжийг бодын толгойн тоогоор нөхнө.

Багтаамжийг тооцохдоо хашааны багтаамжийг хонин толгойд шилжүүлснээр тооцож нөхнө.

Хонин толгойд шилжүүлэхэд дараах итгэлцүүрийг ашиглана:

1 тэмээ	=	5 хонь	1 хонь	=	1 хонь
1 адуу	=	7 хонь	1 ямаа	=	0.9 хонь
1 үхэр	=	6 хонь			

**Хийгдэх балансын шалгалт:**

- Саравчтай, саравчгүй, бодын хашаа нь нийт хашааны дүнгээс сугарч, дүнд барихгүй.  
(багана1>=багана2), (багана1>=багана3), (багана1>=багана4).

## VIII. ХӨРСНИЙ ДОРЙТОЛ

**Хөрсний доройтол** гэж, хүний буруу үйл ажиллагаа, байгалийн болон бусад зүйлийн нөлөөллөөс хөрсний чанар муудан, органик бодис нь алдагдаж, хөрсний үржил шим буурахыг хэлнэ.

**60. Хадлан, бэлчээрийн талбайн хөрсний доройтлыг тодорхойлно уу.** Тухайн өрхөөс хадлан бэлчээрийнх нь талбайн хөрсний доройтолтой байгаа эсэхийг “Доройтолгүй”, “Өнгөц”, “Дундаж”, “Ноцтой” гэсэн төрлөөр асууж, тохирох хариултыг дугуйлна.

Газрын хөрсний доройтлыг дараах тодорхойлолтын дагуу тайлбарлан, тохирох хариултыг нөхнө. Үүнд:

**Доройтолгүй** - Хөрсний доройтол байхгүй

**Өнгөц** - Газрын үржил шим нь бага зэрэг буурсан бөгөөд нөхөн сэргээлтийг хийх боломжтой бол өнгөц гэж үзнэ.

**Дундаж** - Газрын зарим хэсэг нь нэлээн доройтсон бөгөөд ХАА-д ашиглах боломжийг сэргээхийн тулд тодорхой сайжруулалтыг хийх шаардлагатай бол доройтлыг дундаж гэж үзнэ.

**Ноцтой** - Газрын дийлэнх хэсэг нь дахин сэргэхгүйгээр ихээхэн доройтсон, ХАА-н үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон бол доройтол ноцтой болсон гэж үзнэ. Доройтол ноцтой болсоны нэг илрэл нь “Цөлжилт” байж болно.

## **IX. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭ**

**61. Танайх эрсдлээс хамгаалах зориулалттай дараах төрлийн даатгалд үйлчилгээнд хамрагдсан уу?** Тухайн өрхийг эрсдлээс хамгаалах даатгалын үйлчилгээнд хамрагдсан эсэхийг асууж нөхнө. Эрсдлээс хамгаалах даатгалд малын индексжүүлсэн даатгал, арилжааны бусад даатгал зэрэг хамрагдана. Бусад даатгалд дээрх 2 төрлөөс бусад төрлийг даатгал багтана. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**62. Танайх хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар сүүлийн 5 жилд зээл авсан уу?** Тухайн өрхийг ХАА-н зориулалттай зээл авсан эсэхийг асууж, зээл авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, зээл аваагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, **асуулт 68** руу шилжинэ.

**ХАА-н зориулалттай зээлд** тухайн өрх нь үйл ажиллагаандаа зориулан авсан зээлийг оруулна. Үүнд, газар тариалан болон мал аж ахуйд ашиглагдах материал, орцыг худалдан авах, фермийн барилга, байгууламж барих болон тоног төхөөрөмж худалдан авахад зориулан авсан зээл багтана.

Харин сууц, байшин барих, гэр бүлийн бусад бизнес, хэрэглээний зардал зэрэгт зориулан зээл авсан бол ХАА-н зориулалттай зээлд оруулахгүй. Авсан зээлд сүүлийн 5 жилд буюу 2007 оноос хойш авсан зээлийг хамруулна.

**63. Ямар хугацаагаар хэдэн удаа зээл авсан бэ?** Тухайн өрх нь хэдэн удаа зээл авсныг зээлийн хугацаа, зээлийн тоогоор нөхнө. Зээлийн хугацааг нэг жил хүртэл, нэгээс гурав хүртэл жил, гурав ба түүнээс дээш жил гэж ангилж авсан зээлийн тоог нөхнө.

**64. Танайх зээлээ хаанаас авсан бэ?** Тухайн өрхийг зээлээ ямар эх үүсвэрээс авсныг тодруулан асууж нөхнө. Зээлийн эх үүсвэрийг “Арилжааны банкнаас”, “Банк бус санхүүгийн байгууллагаас”, “Хадгаламж, зээлийн хоршооноос”, “Хувь хүн, иргэдээс”, “Төрийн байгууллагаас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна. Нэгээс дээш сонголтыг хийж болно. Хэрэв тухайн өрх нь арилжааны банкнаас зээл авсан бол **Асуулт 65** руу шилжинэ. Банкнаас бусад газраас зээл авсан бол **Асуулт 66** руу шилжинэ. Төрийн байгууллагаас авсан зээлд Засгийн газрын болон бусад холбогдох яамд, газар, орон нутгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээлийн энд оруулна. Тухайлбал: сум хөгжүүлэх сан, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл орно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**65. Арилжааны банкны нэр код.** Арилжааны банкны нэрийг бичиж, кодыг хүснэгтийн дор хэсэгт байгаа кодоос харж тавина.

Арилжааны банкны нэр код:

Голомт банк	1	ХААН банк	3	Хас банк	5	Бусад банк	7
Капитал банк	2	Хадгаламж банк	4	Худалдаа хөгжлийн банк	6		

**66. Танайх зээл авахдаа хөрөнгө барьцаалсан уу?** Тухайн өрх нь зээл авахдаа хөрөнгө барьцаалсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Хөрөнгө барьцаалсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ, барьцаалаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 68 руу шилжинэ.**

**67. Танайх зээл авахдаа барьцаалсан хөрөнгөө хэлнэ үү.** Тухайн өрхийн авсан зээлийг барьцааг тодруулан асууж нөхнө. Барьцааг мал, газар, машин, тоног төхөөрөмж, бусад гэсэн гурван төрлөөр ангилан асууна. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**68. Танайх ХАА-н салбарын талаар мэдээлэл авдаг эх сурвалжаа хэлнэ үү.** Тухайн өрхийн ХАА-н үйл ажиллагаатайгаа холбоотой, мэдээллийг хүлээн авч байгаа эх сурвалжийг байна. ХАА-н талаарх мэдээлэлд, цаг агаар, тариалалт, ургац хураалт, ХАА-н шинэлэг арга туршлагууд, машин, тоног төхөөрөмж, зээлийн үйлчилгээ, байгалийн гамшиг, гадаад, дотоод зах зээл, ХАА-н эдийн засгийн байдал зэргийн талаарх ХАА-тай холбоотой бүх төрлийн мэдээлэл багтана.

Эх сурвалж нь нэгээс дээш сонголттой байж болно. Мэдээллийг авч байгаа эх сурвалжийг “Радио”, “Телевиз”, “Сонин, сэтгүүл”, “Интернэт”, “Төрийн байгууллага”, “Төрийн бус байгууллага”, “Мэргэжлийн байгууллага”, “Иргэд”, “Гар утас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна. Мэдээллийн бусад эх сурвалж байвал нөхөж бичнэ.

**69. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ ихэвчлэн борлуулдаг зах зээл танайхаас хэр зайтай вэ?** Тухайн өрхөөс бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл хүртэлх зайг асууж, нөхнө. Зах зээл хүртэлх зайг “1-9 хүртэл км”, “10-49 хүртэл км”, “50-99 хүртэл км”, “100 ба түүнээс дээш км” гэсэн ангиллаар асууна. Хариултыг бүхэл оронд шилжүүлж зохих ангилалд оруулна. Жишээ нь: 3,5 км гэж хариулсан бол 4 км гэж “1-9 хүртэл км” гэсэн ангилалд оруулна.

## **Х. ХҮНСНИЙ ХАНГАМЖ**

**Өрхийн хүнсний хангамжийн байдал** нь өрхийн бүх гишүүд бүх цаг үед идэвхтэй, эрүүл амьдрах үүднээс аюулгүй бөгөөд тэжээллэг хоол хүнс хэрэглэх нөхцөл байдлыг харуулна. Хэрвээ өрх хангалттай хэмжээний хоол хүнс авах санхүүгийн боломжгүй, эсвэл худалдан авч чадах ч хоол хүнс нь хангалттай хэмжээний биш байсан бол үүнийг өрхийн хүнс эрсдэлтэй/найдваргүй гэж үзэх ба үүнээс болж хангалттай хэмжээний найдвартай, бөгөөд тэжээллэг хоол хүнс хэрэглэж чадахгүй болно.

**70. Танай өрхийн гишүүд тогтмол хэрэглэдэг хүнсээ 2011 онд хэрэглэх боломжгүй, дутагдах тохиолдол гарсан уу?** Тухайн өрх нь хэрэглэдэг хүнсээ 2011 онд хэрэглэх боломжгүй тохиолдол гарсан гэж хариулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, тохиолдол гараагүй гэж хариулсан бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 75 руу шилжинэ.**

**71. Танайх тогтмол хэрэглэдэг хэрэглэдэг хүнсний дутагдалд орсон сарыг дугуйлна уу.** Тухайн өрх нь хэрэглэдэг хүнсийг хэвийн хэмжээнд хэрэглэж чадахгүй тохиолдолд орж байсан саруудыг тухайн хариулагчийн хэлснээр нөхнө. Энэ мэдээлэл нь

хүнсний хомсдолын улирлын нөлөөллийг үнэлэхэд ашиглагдана. Тухайн өрх нь жилд нэг ба түүнээс олон сараар хүнсний хомсдолд орж болох ба хүнсний хомсдолд орж байсан сарыг сайтар асууж бүртгэнэ.

**72. Танайх тогтмол хэрэглэдэг хүнсний дутагдалд орсон шалтгаанаа хэлнэ үү.** Тухай өрхийн хүнсний дутагдалд орсон шалтгааныг “Мал хорогдсон”, “Малын хулгайд өртсөн”, “Байгалийн гамшигт өртсөн”, “Ургац алдсан”, “Ажлын байр олдоогүй”, “Хөдөлмөрийн чадвараа алдсан/өвдөж, гэмтэж бэртэх, хөгжлийн бэрхшээл зэрэг”, “Орлого буурсан”, “Бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн”, “Олдоц багассан”, “Бусад” гэсэн ангиллаар ялган асууна. Нэгээс дээш сонголт хийж болно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**73. Танайх тогтмол хэрэглэдэг хүнсний дутагдалд орсон үед хүнсний хэрэглээндээ гарсан өөрчлөлтийг хэлнэ үү.** Тухайн өрхийн хүнсний (тогтмол хэрэглэдэг) дутагдалд орсноос хүнсний хэрэглээнд орсон өөрчлөлтийг “Бусдаас хоол, хүнсний дэмжлэг авсан”, “Хямдхан хоол, хүнс хэрэглэсэн”, “Хоол, хүнсний хэмжээгээ багасгасан”, “Бусад ” гэсэн ангиллаар асууж бүртгэнэ. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**74. Дээрх хүндрэлээс гарахын тулд ямар арга хэмжээ авсан бэ?** Тухайн өрх тогтмол хэрэглэдэг хүнсний дутагдлаас гарахын тулд ямар арга хэмжээ авсныг “Мөнгөн хуримтлалаасаа хэрэглэсэн”, “Зээл авсан”, “Мал, газар, хөрөнгөө худалдсан”, “Гэр бүлийн бизнесээ өргөжүүлсэн”, “Гэр бүлийн бизнес шинээр эхлүүлсэн”, “Бусдаас тусламж, дэмжлэг авсан”, “Төрийн байгууллагаас тусламж, дэмжлэг авсан”, “Төрийн бус байгууллагаас тусламж, дэмжлэг авсан”, “Бусад” гэсэн ангиллын дагуу асууж, асуулгад нөхнө. Бусад гэдэгт дээр дурдсан ангилалд ороогүй арга хэмжээг нөхөж бичнэ. Нэгээс дээш сонголт байж болно.

**75. Танай өрх 2011 онд байгалийн бэрхшээлд өртсөн үү?** Тухайн өрхийн 2011 онд байгалийн бэрхшээлд өртсөн эсэхийг тодруулан асууж бүртгэнэ. Тухайн өрх байгалийн бэрхшээлд өртөж байсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, тохиолдол гараагүй гэж хариулсан бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 78 рүү** шилжинэ.

**76. Байгалийн бэрхшээлийн төрлийг нэрлэнэ үү.** Тухайн өрхийн өртсөн байгалийн бэрхшээлийн төрлийг асууж, бүртгэнэ. Байгалийн бэрхшээлийг “Ган”, “Зуд”, “Үер”, “Хүчтэй салхи, шуурга”, “Аянга”, “Бусад” гэсэн ангиллаар ялган, бүртгэнэ. Нэгээс дээш сонголт байж болно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**77. Байгалийн бэрхшээлийн улмаас ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлд учирсан хохирлын түвшинг хэлнэ үү.** Байгалийн бэрхшээлийн улмаас тухайн өрхөд учирсан хохирлыг “Хохиролгүй”, “Бага зэргийн хохиролтой (20 хүртэл хувь)”, “Дунд зэргийн хохиролтой (20-40 хувь)”, “Их хэмжээний хохиролтой (41-ээс дээш хувь)” гэсэн ангиллаар асууж бүртгэнэ. Хохирлын түвшинг тооцохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг хэвийн байсан жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулан асууж гаргана. Хэрэв үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь хэвийн жилийнхтэй ижил түвшинд байвал **хохиролгүй**, 20 хүртэлх хувийг алдсан байвал **бага зэргийн хохиролтой**, 20-40 хувийг алдсан байвал **дунд зэргийн хохиролтой**, 40-өөс дээш хувийг алдсан байвал **их хэмжээний хохиролтой** гэж үзнэ.

**78. Танай өрх дараах нэрийн хүнсний бүтээгдэхүүнээс ямар бүтээгдэхүүнийг ихэвчлэн хэрэглэдэг вэ?** Тухайн өрхийн хүнсний хэрэглээндээ ихэвчлэн хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг сонгон тэмдэглэнэ. Эдгээр 13 нэрийн бүтээгдэхүүн нь монгол хүн эрүүл аж төрөхийн тулд хоногт шаардагдах илчлэг,тэжээлийг хангахад зайлшгүй чухал шаардлагатай гол нэр төрлийн бүтээгдэхүүн юм.

## Хүнсний бүтээгдэхүүний ангилал

Бүтээгдэхүүний бүлэг	Хамрах бүтээгдэхүүн
1.Мах, махан бүтээгдэхүүн	Таван хошуу мал, гэрийн тэжээвэр амьтад, зэрлэг ан амьтдын мах, хиам, гэдэс, дотор, толгой шийр, нөөшилсөн мах, борц
2.Сүү	Шингэн, хуурай сүү, өтгөрүүлсэн сүү, ээдэм, айраг, бяслаг, эзэгий, зөөхий, цагаан өрөм
3. Тараг, аарц	Тараг, аарц, ааруул
4. Гурил	Бүх төрлийн гурил
5. Гурилан бүтээгдэхүүн	Талх, боов, боорцог, гоймон
6. Төрөл бүрийн будаа	Бүх төрлийн будаа
7.Саахар, чихрийн зүйл	Элсэн чихэр, ётон, зөөлөн, хатуу чихэр, шоколад
8. Төмс	Төмс, пүнтүүз
9.Хүнсний ногоо	Байцаа, манжин, лууван, сонгино, улаан лооль, сармис, өргөст хэмх, тарвас, гуатан зэрэг бүх төрлийн ногоо, нөөшилсөн ногоо
10.Буурцагт ургамал	Вандуй, шош
11. Жимс, жимсгэнэ	Чацаргана, үхрийн нүд, хад зэрэг байгалийн зэрлэг жимс, алим, усан үзэм зэрэг бүр төрлийн шинэ жимс, хатаасан жимс, нөөшилсөн жимс, сок
12. Өндөг	Шинэ өндөг, хуурай өндөг
13.Ургамлын тос	Ургамлын тос

## ХИ. ОЙ, АН АГНУУР, ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГА

### ХИ.1 ОЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**79. Танайх 2011 онд мод бэлтгэсэн үү?** Тухайн өрхөөс 2011 онд мод бэлтгэсэн эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх мод бэлтгэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод бэлтгээгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 82 руу** шилжинэ.

**80. Танайх ямар зориулалтаар мод бэлтгэсэн бэ?** Тухайн өрхөөс 2011 онд модыг ямар зориулалтаар бэлтгэснийг асууж, бүртгэнэ. Зориулалтыг дараахь ангиллаар бүртгэнэ. Үүнд:

**Түлээний** - Иргэн өөрийн ахуйн хэрэгцээнд зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу түлээ бэлдэх үйл ажиллагаа

**Хэрэглээний** - сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хэрэглээний мод бэлтгэх, барилгын модон материал (банз, дүнз гэх мэт) бэлтгэх үйл ажиллагаа

**Ойн арчилгаа, цэвэрлэгээний** - Ойг хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлүүдээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацанд нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, үйл ажиллагааг хэлнэ.

**81. Бэлтгэсэн модны хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд бэлтгэсэн модны хэмжээг асууж, хариултыг м3-ээр нөхнө.

**82. Танайх мод, сөөгний үр бэлтгэсэн үү?** Тухайн өрхөөс мод, сөөгний үр бэлтгэсэн эсэхийг асууж нөхнө. Үгүй тохиолдолд 2-ыг дугуйлж, **Асуулт 84 руу** шилжинэ.

**83. Бэлтгэсэн мод, сөөгний нэр, үрийн хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн бэлтгэсэн мод, сөөгний үрийг нэр төрлөөр, хэмжээг нь асууж нөхнө. Үрийн хэмжээг кг-аар нөхнө.

**84. Танайх мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжтэй юу?** Тухайн өрхийг мод үржүүлгийн болон тарьц, суулгацын хүлэмжтэй эсэхийг асууж мод

үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжтэй гэвэл Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжгүй тохиолдолд 2-ыг дугуйлан **Асуулт 86 руу шилжинэ.**

**Тарьц-** Үрслүүлэх зорилгоор модны мөчрөөс тусгайлан авсан хэсэг эсвэл модны үрээр 3 хүртэл жил хөрсөнд суулгаж үрслүүлснийг тарьц гэнэ.

**Суулгац-** 3-аас дээш жил хөрсөнд суулгаж, үндэслүүлэн тарихад бэлэн болгосон тарьцыг суулгац гэнэ.

**85. Мод үржүүлгийн тарьц, суулгацын талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн өрхөөс хүлэмжинд суулгасан модны нэр, төрлөөр тарьц, суулгацын тоог асууж, нөхнө.

**86. Танайх 2011 онд мод тарьсан уу?** Тухайн өрх 2011 онд мод тарьсан эсэхийг асууж нөхнө. Мод тарьсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод тариагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 88 руу шилжинэ.**

**87. Тарьсан мод, суулгацны тоог хэлнэ үү.** Тухайн өрхөөс тарьсан модны тоог асууж нөхнө.

**88. Танайх 2011 онд ойгоос дагалт баялаг ашигласан уу?** Тухайн өрхөөс 2011 онд ойгоос дагалт баялаг ашигласан эсэхийг асууж, нөхнө. Тухайн өрх дагалт баялаг ашигласан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Дагалт баялаг ашиглаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 90 рүү шилжинэ.**

**89. 2011 онд ойгоос ашигласан дагалт баялгийн хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд ойгоос бэлтгэсэн самар, жимс, мөөг, эмийн ургамлын хэмжээг асууж, хариултыг кг-аар тооцож, нөхнө. Нэр дурдагдаагүй бусад баялаг байвал ойгоос ашигласан дагалт бүтээгдэхүүний бусад мөрөнд буюу б-р мөрөнд кг-аар нөхнө.

**90. Танайх ойн гаралтай бүтээгдэхүүн 2011 онд борлуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тарьсан суулгацаа борлуулсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тарьсан суулгацаа борлуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тарьсан суулгацаа борлуулаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 92 руу шилжинэ.**

**91. Танайх ойн гаралтай бүтээгдэхүүнээс олсон нийт орлогоо хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, суулгац борлуулснаас олсон нийт орлогыг асууж, хариултыг мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**92. Бүтээгдэхүүн бэлтгэхэд зарцуулсан зардлыг хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд мод бэлтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, суулгац тарихад зарцуулсан зардлыг асууж, зардлын төрлөөр буюу сэлбэг хэрэгсэл, түлш, шатахуун, түрээс, тээвэр, цалин, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад гэсэн төрлөөр нь задлан мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Зардлын тус бүрийн дүн нь нийт зардлын дүнтэй тэнцүү байна.(мөр1=мөр2:мөр8)

## **XI.2 АН АГНУУРЫН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**93. Танайх 2011 онд ан агнасан уу?** Тухайн өрхөөс 2011 онд ан агнасан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх ан агнасан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн

асуулт руу шилжинэ. Ан агнуур хийгээгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг XI.3 руу** шилжинэ.

**94. Танайх ямар зориулалтаар ан хийсэн бэ?** Тухайн өрхөөс ямар зориулалтаар ан хийсэн эсэхийг асууж, хариултыг нөхнө. Нэгээс дээш сонголт байж болно.

**Ахуйн** - тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан ан агнахаар зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад төрлийн ан амьтныг агнасан бол ахуйн зориулалттай агнасан ан агнуурт хамрагдана.

**Үйлдвэрлэлийн** - тухайн өрх нь үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар зохих зөвшөөрлийн дагуу төлбөрийг төлж, ховор төрлийн амьтнаас бусад төрлийн ан амьтанг агнасан бол үйлдвэрлэлийн зориулалттай гэдэгт хамруулна.

**Тусгай** – судалгаа, шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар, гадаадын болон Монгол Улсын иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр, сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор, спорт-агнуурын чиглэлээр хийсэн анг хамруулна.

**95. 2011 онд агнасан ангийн тоогоо хэлнэ үү.** Тухайн өрхийн 2011 онд агнасан ангийн тоо хэмжээг төрлөөр асууж, нөхнө. Бусад төрлийн нэр дурдагдаагүй ан байвал 11-14 дүгээр мөрөнд нөхөж бичнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр14)

**96. Танайх агнасан ангаа борлуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд агнасан ан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх агнасан ан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Борлуулаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 98 рүү** шилжинэ.

**97. Нийт орлогын дүнгээ хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд агнасан ан болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт борлуулалтын орлогыг асууж, мянган төгрөгөөр илэрхийлэн нөхнө.

**98. Ан агнахтай холбогдон гарсан зардлаа хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд ан агнах, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нийт хэдий хэмжээний зардал гарсныг ангийн сэлбэг хэрэгсэл, сумны зардал, түлш, шатахуун, түрээс, тээвэр, цалин, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад гэсэн төрлөөр нь задалж, мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Зардал тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт зардлын дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр9)

### **XI.3 ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**99. Танай өрх 2011 онд загас барьсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд загас барьсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх загас барьсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Загас бариагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан асуулгыг дуусгана.

**100. Танайх ямар зориулалтаар загас барьсан бэ?** Тухайн өрхөөс ямар зориулалтаар загас барьсан эсэхийг асууж, бүртгэнэ.

**Ахуйн** - тухайн өрх нь өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан загас барихаар зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу ховор загаснаас бусад загасыг барьсан бол ахуйн зориулалттай гэдэгт багтана.

**Үйлдвэрлэлийн** - тухайн өрх нь үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар (загас загасан бүтээгдэхүүн болон тос, консерв, махан таташ гэх мэт) зохих зөвшөөрлийн дагуу төлбөрийг төлж, ховор загаснаас бусад төрлийн загас барьсан бол үйлдвэрлэлийн зориулалттай гэдэгт хамруулна.

**Тусгай** - загасыг судалгаа, шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар, гадаадын болон Монгол Улсын иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр, нутаг дэвсгэрт сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор, спорт-агнуурын чиглэлээр барьсан загас багтана. Нэгээс дээш сонголт байж болно.

**101. Барьсан загасны хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн 2011 онд барьсан загасны хэмжээг асууж, кг-д шилжүүлэн тооцож, нөхнө.

**102. Танайх барьсан загас, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд загас барьсан болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх барьсан загас болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Борлуулаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 104 руу** шилжинэ.

**103. Танайх барьсан загас, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс олсон орлогоо хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд загас барьсан болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулж олсон нийт орлогыг асууж, хариултыг мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**107. Загас барих, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлаа хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд загас барих болон бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нийт хэдий хэмжээний зардал гарсан болон загасны өгөөш, загасны хэрэгсэл, түлш, шатахуун, түрээс, тээвэр, цалин, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад зардал зэрэгт хэдэн төгрөг зарцуулсныг асууж, мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Зардал тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр9)

## БҮЛЭГ IV. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГЭЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР

Асуулга нь ерөнхий болон үндсэн бүлгээс бүрдэх бөгөөд 8 бүлэг асуултаас бүрдэнэ. Үүнд:

- I. Ерөнхий мэдээлэл
- II. Ажиллах хүч
- III. ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт
- IV. Газар, машин, тоног төхөөрөмж
- V. ХАА-н зориулалттай барилга, байгууламж
- VI. Худаг, усан сан
- VII. Малын хашаа
- VIII. Хөрсний доройтол
- IX. ХАА-н үйлдвэрлэлд үзүүлэх зарим үйлчилгээ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дугаарыг бичнэ. Тооллогын комиссын дугаарыг **Хавсралт 1** буюу “*Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код*” –оос харна. Уг дугаар нь хүн ам орон, сууцны тооллогод ашигласан дугаартай ижил байна.

**2. Аймаг, нийслэлийн нэр, код.** Энэ асуултад тухайн аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг **Хавсралт 1** буюу “*Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код*” –оос харж нөхнө.

**3. Сум, дүүргийн нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг **Хавсралт 1** буюу “*Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код*” –оос харж нөхнө.

**4. Баг, хорооны нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг **Хавсралт 1** буюу “*Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код*” –оос харж нөхнө.

**5. Тоологчийн нэр, дугаар.** Тоологч өөрийн нэрийг эцэг/ эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө: **Тоологчийн нэр, дугаар** гэсэн мөрийн 2 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрвээ 1 оронтой дугаар бол “01” гэх мэтчилэн өмнөх оронг “0” тавьж гүйцээнэ. Тоологчийн дугаарыг сум, дүүрэг дотроо 1-ээс эхлэн дугаарлана. **Жишээ нь:** тухайн сум, дүүрэгт 5 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-05 хүртэлх дугаар өгнө, 2 дугаар сум, дүүрэгт 10 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-10 хүртэлх дугаар өгнө.

**6. Тооллогын асуулгын дугаар.** Тооллогын асуулгын дугаарыг тоологч бүр тоолж эхэлсэн эхний өрхөөс эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Хэрэв тухайн тоологч 2 багт ажиллах бол асуулгын хуудсыг баг тус бүрд 1-ээс эхлэн дугаарлана.

Тоологч тооллогын асуулгын дугаарыг давхардуулан олгож болохгүй.

**7. Шалгагч, кодлогчийн нэр, код.** Сумын түвшинд тоологчоос тооллогын материалыг багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч шалган хүлээж авна. Аймгийн түвшинд аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд сумдын тооллогын материалыг хүлээн авч, шалгах, кодлох ажлыг хийнэ.

Шалгагч, кодлогч асуулгын хуудсыг шалгах аас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 1 оронтой дугаар бол “01” гэх ба өмнөх оронг “0” тавьж гүйцээж бичнэ. Шалгагч асуулгын хуудсыг үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон алхамыг зөв хийсэн эсэхийг хянаж, алдааг засварлана. Кодлохдоо аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, тоологч, шалгагч, гудамж, хороолол, бүсчлэл, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн зэрэг кодлолтыг хавсралтыг ашиглаж нөхнө.

**8. Шивэгчийн нэр, дугаар.** Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Шивэлтийг ҮСХ хариуцан хийх учраас шивэгч бүрт тусгайлан код давхардуулахгүйгээр олгоно.

## **1.2 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ**

**9. Аж ахуйн нэгж байгууллагын нэр.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө.

**10. Регистрийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн товчлохгүйгээр үнэн зөв нөхнө.

**11. Статистик нэгжийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын статистикийн регистрийн санд бүртгэгдсэн дугаар бөгөөд дугаарыг ҮСХ-ноос хүргүүлсэн жагсаалтаас харж тавина.

## **1.3 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭН/ДАРГА/ЗАХИРЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт тооллогод хамрагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын талаарх мэдээллийг асууж нөхнө. Хэрэв тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эзэн нь өөр хүн байвал тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг удирдаж байгаа захирлынх нь /гүйцэтгэх захирал/ талаарх мэдээллийг авна.

**12. Эцэг (эх)-ийн нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын, эцэг (эх)-ийн нэрийг асууж, нөхнө.

**13. Нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын өөрийн нэрийг асууж, нөхнө.

**14. Хүйс.** Энэ асуулт ХАА-н үйлдвэрлэл дэх жендерийн байдлыг судлах ялангуяа, ХАА-н үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийг үнэлэх чухал үзүүлэлт болно. Энэ асуултын хариултыг нөхөхдөө аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, өрхийн тэргүүлэгчийн хүйсийг эрэгтэй гэж 1, эмэгтэй гэж 2 гэсний аль тохирох кодыг дугуйлна.

**15. Нас (бүтэн жилээр).** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь тооллого явагдаж байгаа жилээр гүйцэд тооцож тогтооно.

**16. Боловсролын түвшин.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын боловсролын түвшинг асууж, боловсролын түвшинд тохирох кодыг сонгон дугуйлна.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол** - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/** - Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**17. Ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын ажилласан жилд тухайн хүний хөдөлмөр эрхэлж эхэлсэн үеэс судалгаа авч байгаа үе хүртэлх хугацааг оруулна. Дээрх хугацаанд хөдөлмөр эрхлээгүй үе гарвал тус хугацааг ажилласан жилд оруулахгүй. Ажилласан нийт жилийг бүтэн жилээр нөхнө.

**Үүнээс: Мал аж ахуйн салбарт.** Нийт ажилласан хугацаанаас хичнээн жилийг нь Мал аж ахуйн салбарт ажилласныг асууж, нөхнө. Зөвхөн тус салбарт ажилд орсон цагаасаа ажиллаж ирсэн бол “Ажилласан жил” нь “Мал аж ахуйн салбарт ажилласан жил”-тэй тэнцүү байна.

**18. Тухайн байгууллагын удирдлагаар ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын тухайн нэгждээ удирдлагаар ажилласан нийт жилийг асууж нөхнө.

**19. Тухайн байгуулагыг үүсгэн байгуулагчдын тоо.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн байгуулагчдын тоог асууж нөхнө.

#### **I.4 АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**20. Танайх 2011 онд мал аж ахуйгаас бусад ямар чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг асууж нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

Бусад үйл ажиллагааны чиглэлийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн, эсвэл борлуулалтын өндөр орлоготойгоос бага руу нь дараалуулах аргаар тодорхойлно. Тухайлбал: Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь мал аж ахуйгаас гадна газар тариалан, худалдааны үйл ажиллагаа давхар эрхэлдэг бол худалдаа эрхэлснээс олсон орлого нь газар тариалангийн бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогоос их байвал эхлээд худалдаа, дараа нь газар тариалан гэж дараалуулан бичнэ.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC-4.0) хувилбарын дагуу номноос (кодлогч) нөхнө.

**21. Танайх малын тоогоо 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын малын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар, малын төрлөөр асууж нөхнө. Таван төрлийн мал тус бүрийн дүн нь бүгд дүнтэй тэнцүү байна. Малын тоо нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын 2011 онд тоолуулсан малын тоотой тэнцүү байна гэдгийг сайтар анхаарна уу.

**22. Танайх ямар хэлбэрийн мал аж ахуй эрхэлдэг вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас уламжлалт, эрчимжсэн, холимог мал аж ахуйн аль төрлийг эрхэлдгийг асууж, тохирох хариултыг нөхнө.

**Уламжлалт** - Уламжлалт аргаар нүүдлийн мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна.

**Эрчимжсэн** - Ашиг шимт үүлдэр, хэвшлийн мал, тэжээвэр амьтныг суурин болон хагас суурин байдлаар технологийн дагуу маллан үйлдвэрлэл эрхэлж, бүтээгдэхүүнээ төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.

**Холимог** - Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.

## **II. АЖИЛЛАХ ХҮЧ**

**23. Танайх 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан эсэхийг асууж хөлсөлсөн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, хөлслөөгүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлна. Жишээлбэл: туслах малчин, саальчин, ажилчин зэргийг аж ахуйдаа тодорхой хугацаанд хөлслөн ажиллуулсан байж болно. Мөн цалин хөлс авдаг байнгын ажиллагчид орно.

**24. Танайх байнгын ажиллагчидтай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь байнгын ажиллагчидтай эсэхийг асууж, ажиллагчидтай гэж хариулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ажиллагчидгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 31** руу шилжинэ.

**25. Байнгын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Байнгын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**Байнгын ажиллагчид** гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хэлнэ (“Хөдөлмөрийн тухай” хуулийн 3.1.15.).

Ажиллагчдын тоонд өрхийн тэргүүлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, захирал орно. Мөн өрхийн гишүүд аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байвал ажиллагчдын тоонд оруулна. Харин ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй.

**26. Байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр хавар, зун, намар, өвлийн улирлаар асууж нөхнө.

**27. Байнгын ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын тоог хүснэгтэд заасан насны ангиллаар, хүйсээр задлан асууж нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр8)
- Насаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь насаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1>=багана2)

**28. Байнгын ажиллагчдын тоо, гэрлэлтийн байдал, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын тоог гэрлэлтийн байдлаар 4 ангилалд хуваан асууж бүртгэнэ.

**Гэрлэсэн/хамт амьдардаг** – Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг энд хамруулна. Мөн гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч /хугацаа харгалзахгүйгээр/ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хамруулна.

**Огт гэрлэж байгаагүй** – Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

**Тусгаарласан/цуцалсан** – Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүмүүсийг “тусгаарласан” гэнэ. Тусдаа амьдардаг гэдэгт амьжиргааны болон бусад нөхцөлөөр тусдаа амьдардаг /жишээлбэл: эхнэр, нөхрийн аль нэг нь гадаадад амьдардаг, хүүхдүүдээ сургуульд суулгахын тулд сумын төвд хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг гэх мэт/ тохиолдлуудыг оруулахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлээгүй хүмүүсийг “цуцалсан” гэнэ.

**Бэлбэсэн** – Эхнэр юмуу нөхөр нь нас барснаас хойш дахин гэрлээгүй бол “бэлбэсэн” гэж үзнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)

- Гэрлэлтийн байдлаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь гэрлэлтийн байдлаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.

(багана1>=багана2)

**29. Байнгын ажиллагчдын тоо, боловсролын түвшин, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын тоог боловсролын түвшингээр асууж бүртгэнэ. Боловсролын түвшинг хуудас 14-өөс харна. Боловсролын түвшинг ойлголт, тодорхойлолтын дагуу харж нөхнө.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол** - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/** - Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Боловсролын түвшингээр задалсан дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр10)
- Боловсролын түвшингээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь боловсролын түвшингээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.

(багана1>=багана2)

**30. Байнгын ажиллагчдаас мэргэжлийн ажиллагчдын тоо, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын мэргэжлийн ажиллагчдын тоог хүснэгтэд өгөгдсөн ангиллаар асууж, бүртгэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Мэргэжлийн ажиллагч тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)
- Мэргэжлээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь мэргэжлээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.

(багана1)>=багана2

**31. Танайх улирлын ажиллагчидтай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг улирлын ажиллагчидтай эсэхийг асууж, улирлын ажиллагчидтай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ажиллагчгүй Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 34 руу** шилжинэ.

**Улирлын ажиллагчдад** улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хамруулна.

**32. Улирлын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын улирлын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**33. Улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь баримжаалан хэлснээр, хавар, зун, намар, өвлийн улирлаар ангилан нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**34. Танайх түр ажиллагчид 2011 онд авч ажиллуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь 2011 онд түр ажиллагч авч ажиллуулсан эсэхийг асууж, бүртгэнэ. Хэрэв түр ажиллагч авч ажиллуулсан бол Тийм-1"-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, хөлслөөгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 37 руу** шилжинэ.

**Түр ажиллагчид** хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг хамруулна.

**35. Түр ажилласан ажиллагчдын тоог хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын түр ажиллагчдын тоог 2011 оны байдлаар асууж нөхнө.

**36. Түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр, хавар, зун, намар, өвлийн улирлаар асууж нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**37. Танайд ажиллах хүчтэй холбоотой дараах хүндрэл, бэрхшээл тулгарч байна уу?** Энэ асуулт нь ажиллах хүчинтэй холбогдолтойгоор үүссэн хүндрэлийг тодорхойлох зорилготой.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хувьд гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг хүснэгтэд тавигдсан ангиллаар асууж нөхнө. Хэрэв дурдсан хүндрэл, бэрхшээл тулгардаггүй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, тулгардаг бол Үгүй гэж 2 –ыг дугуйлна. Бусдад хүснэгтэд дурдснаас өөр бусад хүндрэл, бэрхшээлийг оруулна.

### III. ХАА-Н ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ

**38. Хөдөө аж ахуйн гаралтай 2011 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг 2011 оны байдлаар хүснэгтэд тавигдсан нэр төрлөөр асууж нөхнө.

Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүний хэрэглээ, зарцуулалтыг (борлуулсан, өөртөө хэрэглэсэн, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн, бусад), хүснэгтэд нэр заан өгсөн мал аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрлөөр асууж бүртгэнэ. Нийт үйлдвэрлэлт нь борлуулсан, өөртөө хэрэглэсэн, ажиллагчдад цалин хөлс, урамшуулалд олгосон, нөөцөлсөн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна.

Бүртгэхдээ хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжийг сайтар анхаарна. Хариулагч хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжээс өөрөөр хэлсэн тохиолдолд хүснэгтэд тавигдсан нэгж рүү шилжүүлэхдээ итгэлцүүрийг ашиглана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тухайн хүнээс сануулан асуух замаар, сайтар ярилцаж бүртгэнэ.

$1 \text{ кг} = 1000 \text{ г}$	$1 \text{ т} = 1000 \text{ кг}$	$1 \text{ л} = 1.03 \text{ кг}$
---------------------------------	---------------------------------	---------------------------------

Хүснэгтэд нэр зааснаас өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бол бусад буюу 39-41-р мөрөнд нэрийг нөхөж бичнэ.

**Дараах балансын шалгалтыг хийнэ.** Үүнд:

- Нийт үйлдвэрлэлт нь үрэнд болон өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлс, урамшуулалд олгосон, нөөцөлсөн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна. (багана1=багана2:багана7)
- Махны төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт үйлдвэрлэсэн махтай тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр9)
- Арьс, ширний төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт үйлдвэрлэсэн арьс, ширтэй тэнцүү байна. (мөр29=мөр30:мөр34)

Айрганд гүүний айраг, үхрийн айраг, ямааны айраг, ингэний айраг буюу ундаа зэргийг, үслэг арьсанд минж, булга, үнэгний арьс зэргийг хамруулна.

**39. Танайх бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж байгааг “Хувь хүн ирж авдаг”, “Мах, сүү, ноос бэлтгэлийн компанид”, “Зах зээлд өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Борлуулалтыг нөхөхдөө хамгийн их борлуулалт хийдэг 3-аас илүүгүй хэлбэрийг дугуйлна.

Бүтээгдэхүүнээ хөдөөд ярьж заншснаар өрх, хувь хүнд борлуулсан бол “Хувь хүн ирж авдаг”, мах, ноос бэлтгэдэг компанийн төлөөлөгчид борлуулсан бол “Мах, ноос, сүү бэлтгэлийн компанид”, сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол “Зах зээлд өөрсдөө борлуулдаг” гэсэн сонголтыг хийнэ. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол “Бусад” гэсэн ангилалд оруулна. Бусад хэлбэр байвал нөхөж бичнэ.

**40. Танай бүтээгдэхүүний борлуулалттай холбогдон гардаг хүндрэлээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад гарч байгаа хүндрэлийг “Борлуулалт удаашралтай”, “Хэрэглэгч цөөн”, “Өрсөлдөгч олон”, “Зах зээлээс алслагдсан”, “Үнэ хямд”, “Бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж нөхнө. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ. Хамгийн их тохиолддог 3-аас илүүгүй хүндрэлийг сонгон нөхнө.

**41. Танайх бүтээгдэхүүнийхээ үнийг хэрхэн тогтоодог вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнээ хэрхэн тогтоож байгааг “Зардал дээр ашгийг нэмэх замаар”, “Хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр”, “Өрсөлдөгчийн үнээс хамаарч”, “Зах зээлийн үнэ, ханшаар”, “Бусад” гэсэн төрлөөр асууж нөхнө. Үнэ тогтоодог бусад арга байвал нөхөж бичнэ. Үнээ тогтоож байгаа 3-аас илүүгүй аргыг сонгоно.

#### **IV. ГАЗАР, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

**42. Танайх өөрийн өмчлөлийн газартай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь газар өмчилж авсан эсэхийг асууж өмчилж авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, өмчилж аваагүй бол бол Үгүй гэж 2 –ыг дугуйлж, **Асуулт 45 руу** шилжинэ.

**43. Газрын үнэлгээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж авсан газрын үнэлгээг асууж, сая төгрөгөөр нөхнө. Үнэлгээг тухайн хариулагчийн хэлснээр бүртгэж авна.

**44. Газрын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж авсан захиран зарцуулах эрх бүхий газрын хэмжээг асууж нөхнө. Хэмжээг га-гаар илэрхийлнэ.

Га-д шилжүүлэхдээ дараах итгэлцүүрийг ашиглана:

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000м <sup>2</sup>	=	1 га

**45. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөө аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй эсэхийг асууж машин, тоног төхөөрөмжтэй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, машин, тоног төхөөрөмжгүй бол Үгүй гэж 2–ийг дугуйлж, **Бүлэг V** руу шилжинэ.

**46. Хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийнхөө талаарх мэдээллийг хэлнэ үү.** Машин, тоног төхөөрөмжийг ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоо, төрөл тус бүрээр нь нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжид** өөрийн, хамтын эзэмшлийнх болгосон эсвэл зээл болон лизингээр худалдаж авсан машин, тоног төхөөрөмжийг оруулна.

**Түрээсэлсэн машин, тоног төхөөрөмжид** төрийн байгууллагаас болон бусдаас түрээсэлсэн, төлбөртэй болон төлбөргүйгээр зээлж ашигласныг энд оруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанд** тухайн машин, тоног төхөөрөмжийг худалдаж авснаас хойш хэдэн жил болж байгаа хугацааг бүтэн жилээр илэрхийлж, нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг бүртгэхдээ** тухайн аж ахуйн нэгж, байгууллагын балансын үнээр бүртгэнэ. Үнийн дүнг **мянган төгрөгөөр** илэрхийлнэ.

Машин, тоног төхөөрөмжийг дараах жагсаалтаас харж, хүснэгтэд тохирох кодыг тавина.

**Машин, тоног төхөөрөмжийн код:**

Сэрээ	01	Пресслэгч машин	09	Дугуйт трактор (139-275 м.х)	17	Саалтуур аппарат	25
Бага оврын тракторын хадуур	02	Нуруулдагч	10	Дугуйт трактор (275-аас дээш м.х)	18	Сүүний машин	26
Морин хадуур	03	Чиргүүл	11	Морин тэрэг	19	Цэцгий цохигч машин	27
Бусад хадуур	04	Гинжит трактор	12	Үхэр тэрэг	20	Хөргөгч	28
Бага оврын тракторын тармуур	05	Явган трактор , тоног төхөөрөмжийн иж бүрдлийн хамт (10 м.х-ээс бага )	13	Тэмээн тэрэг	21	Хонины ноос хяргагч машин	29
Морин тармуур	06	Бага оврын дугуйт трактор (10-20 м.х)	14	Суудлын машин	22	Бусад төхөөрөмж	30
Бусад тармуур	07	Дунд оврын дугуйт трактор (25-60 м.х)	15	Ачааны машин	23		
Хаман боогч	08	Зүтгэх хүчний дугуйт трактор (80-130 м.х)	16	Мотоцикл	24		

**V. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ**

**47. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын барилга, байгууламжтай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас ХАА-н зориулалтын барилга, байгууламжтай эсэхийг тодруулан асууж, байгаа бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, Үгүй бол 2–ыг дугуйлж, **Бүлэг VI** руу шилжинэ.

**48. Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн, нэгж байгууллагын ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн талаарх мэдээллийг асууж нөхнө. ХАА-н барилга, байгууламжийг тоо, ширхэг, багтаамжаар бүртгэж, эзэмшлийн төрлөөр нь ашиглаж байгаа, бусдад түрээслүүлсэн, ашиглахгүй байгаа гэсэн ангиллаар бүртгэнэ. Мөн бусдаас түрээсэлсэн хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн тоог асууж нөхнө.

ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн ашигласан хугацаа, хөрөнгийн үнэлгээг нэр төрлөөр, асууж бүртгэнэ. Хөрөнгийн үнэлгээг мянган төгрөгөөр илэрхийлнэ. Үнэлгээг бүртгэхдээ аж ахуйн нэгж, байгууллагын хувьд балансын үнээр нөхнө.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ХАА-н зорилгоос бусад зорилгоор ашигласан орон сууцны бус барилга, байгууламжийг энд оруулахгүй.

ХАА-н зориулалттай барилга, байгууламжийг “Албан газрын зориулалттай барилга”, “Хүлэмж”, “Агуулах”, “Зоорь”, “ХАА-н техник хадгалах байгууламж”, “Малын хашаа”, “Зориулалтын технологийн байр, ферм” гэсэн төрлөөр ангилж бүртгэнэ.

Агуулахад үр тариа, өвс, бусад материалыг хадгалах зориулалтаар мод, чулуу, тоосго, брезент, блок зэргийг ашиглан барьсан ХАА-н үйлдвэрлэлийн барилгыг оруулна.

Зооринд төмс, хүнсний ногоо, мах хадгалах зориулалтаар газар ухаж гаргасан байрыг оруулна. Мөн төмс, хүнсний ногоог хүлээн авах, ялгах үйл ажиллагааг техникээр гүйцэтгэдэг, хадгалалтын горимыг автоматаар тохируулах боломжтой механикжсан зоорь, гар аргаар газар ухаж, дулаалга хийсэн энгийн зоорь, гэр, сууцны дотор талд мөн

газар ухаж гаргасан нүхэн зорь, мөн газрыг цооноглон ухаж хадгалах тасалгаа хийсэн нүхэн зорийг зоринд тус тус хамруулна. Зорь нь дангаараа төмс, хүнсний ногоо, махны мөн холимог байдлаар төмс, хүнсний ногооных гэсэн хэлбэрээр байж болно.

## VI. ХУДАГ, УСАН САН

**49. Танайх өөрийн эзэмшлийн худаг, усан сантай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн эзэмшлийн худаг, усан сантай эсэхийг асууж, хариултыг нөхнө.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил худаг, усан сантай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Өөрийн эзэмшил худаг, усан сангүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг VII руу** шилжинэ.

**50. Худаг, усан сангийнхаа талаарх мэдээллийг хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа худаг, усан сангийн тоо, усан сангийн багтаамжийг байршил, ашиглалтын хэлбэрээр асууж, нөхнө.

Худаг, усалтын системийг анх барьж байгуулахад гүйцэтгэсэн үйл ажиллагаагаар нь өрөмдмөл (гүний), богино яндант болон энгийн гэж ангилна.

**Өрөмдмөл худаг, (гүний)** - Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор өрөмдөж, ханыг нь бэхэлж байгуулсан, босоо цооногийн уст үед байрлуулсан, ус шүүж оруулах яндан шүүртэй, дотор талдаа усны шахуурга, ус дамжуулах хоолойтой инженерийн байгууламжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл харьцангуй голч /150, 200, 250, 300, 350, 400 мм /-той, 30 метрээс доош гүнтэй цооног бүхий цахилгаан буюу дизель хөдөлгүүртэй ус өргүүртэй худгийг өрөмдмөл худаг гэнэ.

**Богино яндант худаг** - Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор том голчоор өрөмдөж ханыг нь 1м голч урттай бетон цагиргийг давхарлан 3м гүнд суулгасан, түүнээс доош 30м хүртэл гүнд бага голчтой цооног өрөмдөж төхөөрөмжилсөн өрөмдмөл худгийн зохион байгуулалттай ижил инженерийн байгууламжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл харьцангуй бага голч /150, 200, 250 мм /-той, 30 метр хүртэл гүнтэй цооног бүхий худгийг богино яндант худаг гэнэ.

**Энгийн уурхайн /гар худаг/** - Хөрс, геологийн тогтолцоог ажиглаж судалсны үндсэн дээр хөрсний өнгөн хэсэгт ус байх магадлал бүхий газарт 8 м хүртэл гүн ухаж гаргасан цооногийн ханыг мод, чулуу зэрэг материалаар хашиж бэхэлсэн худгийг хэлнэ.

**Усан сан** гэж улс, орон нутгийн хүчээр баригдсан 4 ба түүнээс дээш куб м багтаамжтай мал услах талбай, онгоцтой усалгааны цэгийг хэлнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нийт худгийн тооноос бэлчээрт байршдаг болон ашигладаггүй худгийн тоо нь сугарч харагдах бөгөөд дүнд барихгүй. (багана1>=багана3), (багана1>=багана4)
- Өрөмдлөгийн, богино, яндант, энгийн уурхайн, бусад төрлийн худгийн дүнгийн нийлбэр нь худгийн бүгд дүнд балансруулна. (мөр1=мөр2:мөр5)

## VII. МАЛЫН ХАШАА

**51. Танайх өөрийн эзэмшлийн малын хашаатай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил малын хашаатай эсэхийг асууж, хариултыг нөхнө.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн эзэмшил малын хашаатай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Өөрийн эзэмшлийн малын хашаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг VIII руу** шилжинэ.

**52. Өөрийн эзэмшилд байгаа малын хашааныхаа тоог хэлнэ үү.** Тухайн аж ахуйн, нэгж, байгууллагын өөрийнх нь эзэмшилд байгаа бүх төрлийн малын хашааг хашааны төрлөөр нөхнө. Өөрийн эзэмшилд байгаа малын хашааны тоо нь **48 дугаар асуултын 11 дүгээрт** тавигдсан малын хашааны тоотой тэнцүү байна.

Малын нийт хашаа, үүнээс дулаалгатай, саравчтай, саравчгүй, бодын хашааг нөхөхдөө өвөл, хаврын улиралд бэлчээрийн тохиромжтой газарт баригдсан, удаан хугацаанд ашиглагдах бэлэн хашааг тоолж, нөхнө. Харин баригдаж дуусаагүй, хөрсөнгөөр баригдсан, түр зуурын ашиглалттай буюу нүүдлийн чанартай хашааг оруулахгүй.

**Саравчтай хашаа**- гурван тал буюу тал дугуй ханан хашаанд саравчин дээвэр тавьсан, хана нь завсаргүй дулаалагдсан байхаас гадна саравчны өмнө талд мал нарлуулах буюу тэжээх талбайтай баригдсан хашааг хэлнэ.

**Саравчгүй хашаа**- дээвэргүй дөрвөлжин буюу тал дугуй, бүрэн дугуй маягийн хэлбэртэй хашааг оруулна.

**Бодын хашаа** – бод малын хашааг тусад нь салган харуулна. Багтаамжийг бодын толгойн тоогоор нөхнө.

Багтаамжийг тооцохдоо хашааны багтаамжийг хонин толгойд шилжүүлснээр тооцож нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Саравчтай, саравчгүй, бодын хашаа нь нийт хашааны дүнгээс сугарч, дүнд барихгүй. (багана1>=багана2), (багана1>=багана3), (багана1>=багана4)

## **VIII. ХӨРСНИЙ ДОРЙТОЛ**

**Хөрсний доройтол** гэж, хүний буруу үйл ажиллагаа, байгалийн болон бусад зүйлийн нөлөөллөөс хөрсний чанар муудан, органик бодис алдагдах, хөрсний үржил шим буурахыг хэлнэ.

**53. Хадлан, бэлчээрийн талбайн хөрсний доройтлыг тодорхойлно уу.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас хадлан бэлчээрийн талбай нь хөрсний доройтолтой байгаа эсэхийг “доройтолгүй”, “өнгөц”, “дундаж”, “ноцтой” гэсэн төрлөөр асууж, тохирох хариултыг дугуйлна.

Газрын хөрсний доройтлыг дараах тодорхойлолтын дагуу тайлбарлан, тохирох хариултыг нөхнө. Үүнд:

**Доройтолгүй** - Хөрсний доройтол байхгүй

**Өнгөц** - Газрын үржил шим нь бага зэрэг буурсан бөгөөд нөхөн сэргээлтийг хийх боломжтой бол өнгөц гэж үзнэ.

**Дундаж** - Газрын зарим хэсэг нь нэлээн доройтсон бөгөөд ХАА-д ашиглах боломжийг сэргээхийн тулд тодорхой сайжруулалтыг хийх шаардлагатай бол доройтлыг дундаж гэж үзнэ.

**Ноцтой** - Газрын дийлэнх хэсэг нь дахин сэргэхгүйгээр ихээхэн доройтсон, ХАА-н үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон бол доройтол ноцтой болсон гэж үзнэ. Доройтол ноцтой болсны нэг илрэл нь “Цөлжилт” байж болно.

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭ

**54. Танайх эрсдлээс хамгаалах зориулалттай дараах төрлийн даатгалд үйлчилгээнд хамрагдсан уу?** Тухайн өрхийг эрсдлээс хамгаалах даатгалын үйлчилгээнд хамрагдсан эсэхийг асууж нөхнө. Эрсдлээс хамгаалах даатгалд малын индексжүүлсэн даатгал, арилжааны бусад даатгал, үрийн тариалангийн даатгал зэрэг хамрагдана. Бусад даатгалд дээрх 2 төрлөөс бусад төрлийг даатгал багтана. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**55. Танайх хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар сүүлийн 5 жилд зээл авсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг ХАА-н зориулалттай зээл авсан эсэхийг асууж, зээл авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, зээл аваагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, **Асуулт 61 руу** шилжинэ.

ХАА-н зориулалттай зээлд тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаандаа зориулан авсан зээлийг оруулна. Үүнд, газар тариалан болон мал аж ахуйд ашиглагдах материал, орцыг худалдан авах, фермийн барилга, байгууламж барих болон тоног төхөөрөмж худалдан авахад зориулан авсан зээл хамрагдана.

Харин сууц, байшин барих, гэр бүлийн бусад бизнес, хэрэглээний зардал зэрэгтээ зориулан зээл авсан бол ХАА-н зориулалттай зээлд оруулахгүй. Авсан зээлд сүүлийн 5 жилд буюу 2007 оноос хойш авсан зээлийг хамруулна.

**56. Ямар хугацаагаар хэдэн удаа зээл авсан бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь хэдэн удаа зээл авсныг зээлийн хугацаа, зээлийн тоогоор нөхнө. Зээлийн хугацааг нэг жил хүртэл, нэгээс гурав хүртэл жил, гурав ба түүнээс дээш жил гэж ангилж авсан зээлийн тоог нөхнө.

**57. Танайх зээлээ хаанаас авсан бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг зээлээ ямар эх үүсвэрээс авсныг тодруулан асууж нөхнө. Зээлийн эх үүсвэрийг “Арилжааны банкнаас”, “Банк бус санхүүгийн байгууллагаас”, “Хадгаламж, зээлийн хоршооноос”, “Хувь хүн, иргэдээс”, “Төрийн байгууллагаас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна. Нэгээс дээш сонголтыг хийж болно.

Хэрэв тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь арилжааны банкнаас зээл авсан бол **Асуулт 58 руу** шилжинэ. Банкнаас бусад газраас зээл авсан бол **Асуулт 59 руу** шилжинэ. Төрийн байгууллагаас авсан зээлд Засгийн газрын болон бусад холбогдох яамд, газар, орон нутгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээлийн энд оруулна. Тухайлбал: сум хөгжүүлэх сан, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл орно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**58. Арилжааны банкны нэр код.** Арилжааны банкны нэрийг бичиж, кодыг хүснэгтийн дор хэсэгт байгаа кодоос харж тавина.

Арилжааны банкны код:

Голомт банк	1	ХААН банк	3	Хас банк	5	Бусад банк	7
Капитал банк	2	Хадгаламж банк	4	Худалдаа хөгжлийн банк	6		

**59. Танайх зээл авахдаа хөрөнгө барьцаалсан уу?** Тухайн аж ахуйн нэгж байгууллага нь зээл авахдаа хөрөнгө барьцаалсан эсэхийг асууж, хариултыг нөхнө.

Хөрөнгө барьцаалсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ, барьцаалаагүй бол “Үгүй -2”-ыг дугуйлж, **Асуулт 61 руу** шилжинэ.

**60. Танайх зээл авахдаа барьцаалсан хөрөнгөө хэлнэ үү.** Тухайн аж ахуйн, нэгж, байгууллагын авсан зээлийн барьцааг тодруулан асууж нөхнө. Барьцааг мал, газар, машин, тоног төхөөрөмж, бусад гэсэн төрлөөр ангилан асууна. Нэгээс дээш сонголт байж болно.

**61. Танайх ХАА-н салбарын талаар мэдээлэл авдаг эх сурвалжаа хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ХАА-н үйл ажиллагаатайгаа холбоотой, мэдээллийг хүлээн авч байгаа эх сурвалжийг үүнд хамруулна. ХАА-н талаарх мэдээлэлд, цаг агаар, тариалалт, ургац хураалт, ХАА-н шинэлэг арга туршлагууд, машин, тоног төхөөрөмж, зээлийн үйлчилгээ, байгалийн гамшиг гадаад, дотоод зах зээл, ХАА-н эдийн засгийн байдал зэрэг ХАА-тай холбоотой бүх төрлийн мэдээлэл орно.

Эх сурвалж нь нэгээс дээш сонголттой байж болно. Мэдээллийг авч байгаа эх сурвалжийг “Радио”, “Телевиз”, “Сонин, сэтгүүл”, “Интернэт”, “Төрийн байгууллага”, “Төрийн бус байгууллага”, “Мэргэжлийн байгууллага”, “Иргэд”, “Гар утас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна.

**62. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ ихэвчлэн борлуулдаг зах зээл танайхаас хэр зайтай вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл хүртэлх зайг асууж, нөхнө. Зах зээл хүртэлх зайг 1-9 хүртэл км, 10-49 хүртэл км, 50-99 хүртэл км, 100 ба түүнээс дээш км гэсэн ангиллаар асууна. Хэрэв хариулагч зах зээл хүртэлх зайг 3.5 км гэж хариулсан бол 4 км гэж “1-9 хүртэл км” гэсэн ангилалд оруулна.

## БҮЛЭГ V. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР

Газар тариалангийн тооллогод газар тариалангийн үйл ажиллагааг эрхэлдэг өрхийг хамруулах бөгөөд асуулга нь газар тариалан эрхэлдэг өрхийн асуулга (ХААТ 2а) байна.

Асуулга нь ерөнхий болон үндсэн бүлгээс бүрдэх бөгөөд асуулга нь 11 бүлэг асуултаас бүрдэнэ. Үүнд:

- I. Ерөнхий мэдээлэл
- II. Ажиллах хүч
- III. Газар, түүний ашиглалт
- IV. Газар тариалангийн үйл ажиллагаа
- V. ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт
- VI. Газар, машин, тоног төхөөрөмж
- VII. ХАА-н зориулалттай барилга, байгууламж
- VIII. Худаг, усан сан
- IX. ХАА-н үйлдвэрлэлд үзүүлэх зарим үйлчилгээ
- X. Хүнсний хангамж
- XI. Загас, ан агнуур, ойн аж ахуйн үйл ажиллагаа

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ

Газар тариалан эрхэлдэг нэгжийн хаягийн хэсэг нь тухайн нэгжийг засаг захиргааны аль нэгж эсвэл газар тариалангийн ямар бүсэд байгааг илэрхийлэхээс гадна газар тариалангийн тооллогын үр дүнг нэгтгэх үндсэн үндсэн чухал хэсэг болно. Мөн хаягийн хэсэг нь газарзүйн мэдээллийн системээр тооллогын үр дүнгийн тайланг гаргах болон мэдээллийг бусад эх үүсвэртэй холбоход ашиглагдах юм.

“Газар тариалан эрхэлдэг нэгж” гэдэгт газар тариаланг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй эрхэлдэг болон газар тариалангийн үйлдвэрлэл тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх, ААНБ-ыг хамруулна.

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дугаарыг бичнэ. Тооллогын комиссын дугаарыг хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харна. Уг дугаар нь Хүн ам орон, сууцны тооллогод ашигласан дугаартай ижил байна.

**2. Аймаг, нийслэлийн нэр, код.** Энэ асуултад тухайн аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**3. Сум, дүүргийн нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**4. Баг, хорооны нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**5. Тоологчийн нэр, дугаар.** Тоологч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө: **Тоологчийн нэр, дугаар** гэсэн мөрийн 2 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрвээ 1 оронтой дугаар бол “01” гэх мэтчилэн өмнөх оронг “0” тавьж гүйцээнэ. Тоологчийн дугаарыг өгөхдөө сум, дүүрэг дотроо 01-ээс эхлэн дугаарлана. **Жишээ нь:** тухайн сум, дүүрэгт 5 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-05 хүртэлх дугаар өгнө, 2 дугаар сум, дүүрэгт 10 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-10 хүртэлх дугаар өгнө.

**6. Тооллогын асуулгын дугаар.** Тооллогын асуулгын дугаарыг тоологч бүр тоолж эхэлсэн эхний өрхөөс эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Хэрэв тухайн тоологч 2 багт ажиллах бол асуулгын хуудсыг баг тус бүрд 1-ээс эхлэн дугаарлана.

Тоологч тооллогын асуулгын дугаарыг давхардуулан олгож болохгүй.

**7. Шалгагч, кодлогчийн нэр, код.** Сумын түвшинд тоологчоос тооллогын материалыг багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч шалган хүлээж авна. Аймгийн түвшинд аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд сумдын тооллогын материалыг хүлээн авч, шалгах, кодлох ажлыг хийнэ.

Шалгагч, кодлогч асуулгын хуудсыг шалгах аас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 1 оронтой дугаар бол “01” гэх ба өмнөх оронг “0” тавьж гүйцээж бичнэ. Шалгагч асуулгын хуудсыг үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон алхамыг зөв хийсэн эсэхийг хянаж, алдааг засварлана. Кодлохдоо аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, тоологч, шалгагч, гудамж, хороолол, бүсчлэл, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн зэрэг кодлолтыг хавсралтыг ашиглаж нөхнө.

**8. Шивэгчийн нэр, дугаар.** Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Шивэлтийг ҮСХ хариуцан хийх учраас шивэгч бүрт тусгайлан кодыг давхардуулахгүйгээр олгоно.

**9. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар.** Өрх бүр дээр хөтлөгддөг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр дээр нөхөгдсөн 12 оронтой дугаарыг авч бичнэ. Өөрөөр хэлбэл хүн ам, өрхийн бүртгэлийн дугаар буюу 2011 оны хүн ам, өрхийн бүртгэлийн дугаартай ижил байна.

“Өрх гэдэг” нь (а) өөрийн амьжиргаанд шаардлагатай хоол хүнсний болоод бусад хэрэгцээгээ өөр хүмүүс болон өөр өрхийн гишүүдтэй хамтралгүйгээр хангаж байгаа нэг хүнтэй өрх (б) хоёр, түүнээс дээш эсвэл хэсэг бүлэг хүмүүс хамтран өөрийн амьжиргаанд шаардлагатай хүнсний болоод бусад хэрэгцээгээ хангаж байгаа олон хүнтэй өрхийн аль алинийг хэлнэ. Өрхийн гишүүд нь орлогоо нийлүүлдэг, нэг төсөвтэй, гэхдээ тэд хууль ёсны хамаатнууд ч байж болно, бас биш ч байж болно.

## **1.2 ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт тооллогод хамрагдаж байгаа тухайн өрхийн тэргүүлэгчийн талаарх мэдээллийг асууж нөхнө.

**10. Эцэг (эх)-ийн нэр.** Тухайн өрхийн тэргүүлэгчийн эцэг (эх)-ийн нэрийг асууж, нөхнө.

**11. Өрхийн тэргүүлэгчийн нэр.** Өрхийн тэргүүлэгчийн нэрийг асууж нөхнө.

**12. Өрхийн тэргүүлэгчийн регистрийн дугаар.** Өрхийн тэргүүлэгчээс иргэний үнэмлэхийн регистрийн дугаарыг асууж, нөхнө.

**13. Хүйс.** Энэ асуулт ХАА-н үйлдвэрлэл дэх жендерийн байдлыг судлах ялангуяа, ХАА-н үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийг үнэлэх чухал үзүүлэлт болно. Энэ асуултын хариултыг нөхөхдөө өрхийн тэргүүлэгчийн хүйсийг эрэгтэй гэж 1, эмэгтэй -2 гэсний аль тохирох кодыг дугуйлна.

**14. Нас (бүтэн жилээр).** Өрхийн тэргүүлэгчийн насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь тооллого явагдаж байгаа жилээр гүйцэд тооцож тогтооно.

**15. Боловсролын түвшин.** Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшинг асууж, боловсролын түвшинд тохирох кодыг сонгон дугуйлна.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол** - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/** - Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**16. Ажилласан жил.** Өрхийн тэргүүлэгчийн ажилласан жилд тухайн хүний хөдөлмөр эрхэлж эхэлсэн үеэс судалгаа авч байгаа үе хүртэлх хугацааг оруулна. Дээрх хугацаанд хөдөлмөр эрхлээгүй завсрын хугацааг ажилласан жилд оруулахгүй. Ажилласан нийт жилийг бүтэн жилээр нөхнө.

**Үүнээс: Газар тариалангийн салбарт.** Нийт ажилласан хугацаанаас хичнээн жилийг нь Газар тариалангийн салбарт ажилласныг асууж, бичнэ. Зөвхөн тус салбарт ажилд орсон цагаасаа ажиллаж ирсэн бол “Ажилласан жил” нь “Газар тариалангийн салбарт ажилласан жил”-тэй тэнцүү байна.

**17. Та дараах даатгалд хамрагдсан уу?** Тухайн өрхийн тэргүүлэгчээс эрүүл мэндийн, нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг эсэхийг асууж, тохирох хариултыг нөхнө.

**18. Ам бүлийн тоо.** Тухайн өрхийн ам бүлийн тоог асууж нөхнө.

**19. Үүнээс 16 хүртэлх насны хүүхдийн тоо.** Тухайн өрхийн 16 хүртэлх насны хүүхдийн тоог асууж нөхнө. 16 хүртэлх насны хүүхдийн тоо нь ам бүлийн тооноос бага байна.

**20. Танайх ямар төрлийн сууцанд суудаг вэ?** Тухайн өрх, хүн амын амьдарч байгаа бүх төрлийн орон байр, сууц багтана. Тухайн өрхийн амьдарч байгаа сууцны төрлийг асууж, тохирох хариултыг нөхнө.

**Гэр** – Бүх төрлийн монгол гэр, цаатны урц хамаарагдана.

**Байшин** - Байшинд нэг болон олон өрөөтэй дээвэртэй, гадуураа ханатай, сууринаас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байр багтана. Байшинд орон сууны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин(гэр хорооллын хашаа болон өвөлжөө, хаваржаанд барьсан шавар болон модон ханатай сууцны байшин) нийтийн болон нийтийн бус зориулалтын бусад байр орно.

**Зориулалтын бус сууц** - Анхнаасаа хүн амьдрахад зориулж бариагүй эсвэл хүн амьдрахад засаж тохижуулан өөрчилсөн, хүн амьдарч байгаа сууц багтана. Жишээ вагончик, амбаар, агуулах, дэлгүүр гэх мэт

**Бусад сууц** - Дээрх 3 төрлийн сууцанд хамаарагдаагүй хүн амьдарч байгаа бүх төрлийн сууцыг хамруулна.

**21. Танай сууцны цахилгааны эх үүсвэр юу вэ?** Тухайн өрхийн цахилгааны эх үүсвэрийг төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан эх үүсгүүр, цахилгааны эх үүсвэргүй гэсэн ангиллаар асууж бүртгэнэ.

Тухайн өрх хэд хэдэн цахилгааны эх үүсвэртэй байж болох бөгөөд цахилгааны үндсэн эх үүсвэрийнхээ талаар хариулна.

**Төвлөрсөн систем** - Улсын цахилгаан болон усан станцаас цахилгаан хэрэглэж байвал тухайн сууцыг төвлөрсөн системтэй гэж үзнэ. Төвлөрсөн цахилгаан станцад холбогдсон дэд станцыг төвлөрсөн гэж үзнэ. Говь-Алтай, Завхан аймгаас бусад аймгийн хувьд төвлөрсөн системтэй гэж үзнэ.

**Дизель станц** - Тухайн орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон болон цахилгааны сүлжээтэй холбогдсон орон сууц багтана.

**Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж** - Нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч бий болгодог төхөөрөмжийг хамруулна.

**Бага оврын цахилгаан үүсгүүр**- Тухайн өрх нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг үүнд хамруулна.

**Цахилгааны эх үүсвэргүй** - Тухайн өрх цахилгаан огт хэрэглэдэггүй бол цахилгааны эх үүсвэргүйд хамруулна.

**22. Таны ундны усны эх үүсвэр юу вэ?** Тухайн өрхийн ундны эх үүсвэрийг тодорхойлоход энэ үзүүлэлт чухал юм. Ундны усыг төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, хамгаалагдсан худаг, хамгаалагдсан булаг, шанд, цэвэршүүлэн савласан ус, төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр, зөөврийн ус, гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд гэсэн ангиллаар асууж бүртгэнэ. Хэрэв тухай өрх нь ундны усаа олон эх үүсвэрээс хангадаг бол ихэвчлэн хэрэглэдэг үндсэн гол үүсвэрийг сонгоно.

**Төвлөрсөн систем** - Улсын болон тухайн орон нутгийн усан хангамжийн төвлөрсөн системээс бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, орон сууцны байшин, нийтийн болон нийтийн эзэмшлийн бусад байранд төвлөрсөв байдлаар ус түгээж байгаа усны системийг хэлнэ.

**Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр** - Хот суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон ус түгээх байр багтана.

**Хамгаалагдсан худаг** - зураг төслийн дагуу баригдсан мотор буюу бусад төхөөрөмжөөр усаа шууд авдаг, дээгүүрээ байгууламжтай, эрүүл ахуйн бүс тогтоож хашиж, хамгаалалтанд байдаг, мал амьтан орх боломжгүй худгийг хамруулна. Үүнд өрөмдмөл гүний худаг орно.

**Хамгаалагдсан булаг, шанд** - тусгай хамгаалалтад байдаг, засаж тохижуулсан, хашин хамгаалсан, мал, амьтан орох боломжгүй булаг, шандыг хамгаалагдсан гэж үзнэ.

**Цэвэршүүлэн савласан ус** - Аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн цэвэршүүлэн савласан ундны зориулалтаар бэлтгэгдсэн усыг хэлнэ.

**Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр** - Эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн зориулалтын авто машинаар ус түгээх байрт зөөвөрлөн түгээдэг байр багтана.

**Зөөврийн ус** - Эрх бүхий байгууллага, хувийн аж ахуйн нэгж, иргэд хувиараа машин болон ердийн хөсгөөр айл өрхөд шууд зөөвөрлөн түгээхийг хамруулна.

**Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд** - Иргэд өөрсдөө ухаж гаргасан, хамгаалалтгүй уурхайн худаг, булаг, шанд орно. Мөн Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, бороо, цасны болон тогтоол усыг оруулна.

Хэрэв тухай өрх нь ундны усаа төвлөрсөн системээс авдаг бол **асуулт 25 руу** шилжинэ.

**23. Танайх ундны усаа хэр холоос зөөвөрлөдөг вэ?** Ундны усны эх үүсвэр нь төвлөрсөн системээс бусад эх үүсвэрээр хангагддаг бол ундны усандаа хүрэх зайг өвөл, зун, хавар, намрын улирлаар тухайн өрхийн тооцоолсноор нь нөхөж бичнэ. Зайн хэмжээ нь метр байна.

**24. Танайх ундны болон ахуйн хэрэглээний усаа хэрхэн зөөвөрлөдөг вэ?** Тухайн өрхийн ундны усаа зөөвөрлөж байгаа байдлыг “Явганаар”, “Ердийн хөсгөөр”, “Өөрийн машин, мотоциклоор”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Голлон зөөвөрлөдөг хэлбэрээ сонгоно.

**Явганаар** - ундны усаа ойролцоох худаг, гол, нуур зэргээс бидон, хувин, саваар зөөвөрлөхийг;

**Ердийн хөсгөөр** - Тэмээ, морь, үхэр тэрэг ашиглан ундны усаа зөөвөрлөхийг;

**Өөрийн машин, мотоциклоор** – Өөрийн эзэмшлийн машин, мотоциклоор зөөвөрлөхийг;

**Бусад** - Ундны усаа зөөвөрлөх дээрх гурван ангилалд багтаагүй хэлбэрээр ус зөөвөрлөхийг хэлнэ.

### **I.3 ӨРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**25. Танайх 2011 онд газар тариалангаас бусад ямар чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн бэ?** Тухайн өрхийн үйл ажиллагааны чиглэлийг асууж нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

Бусад үйл ажиллагааны чиглэлийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн, эсвэл борлуулалтын өндөр орлоготойгоос бага руу нь дараалуулах аргаар тодорхойлно. Тухайлбал: Тухайн өрх газар тариалангаас гадна мал аж ахуй, худалдааны үйл ажиллагаа давхар эрхэлдэг бол худалдаа эрхэлснээс олсон орлого нь мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогоос их байвал эхлээд худалдаа, дараа нь мал аж ахуй гэж дараалуулан бичнэ.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC-4.0) хувилбарын дагуу номноос (кодлогч) нөхнө.

## **II. АЖИЛЛАХ ХҮЧ**

**26. Танайх 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан эсэхийг асууж хөлсөлсөн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, хөлслөөгүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлна..

**27. Танайх байнгын ажиллагчидтай юу?** Тухайн өрх байнгын ажиллагчидтай эсэхийг асууж нөхнө. Тариаланч өрхийн ядаж 1 гишүүн нь байнгын ажиллагч байна.

**28. Байнгын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Байнгын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**Байнгын ажиллагчид** гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хэлнэ (“Хөдөлмөрийн тухай” хуулийн 3.1.15.).

Ажиллагчдын тоонд өрхийн тэргүүлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, захирал орно. Мөн өрхийн гишүүд аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байвал ажиллагчдын тоонд оруулна. Харин ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй.

Мөн ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй.

**29. Байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь баримжаалан хэлснээр тариалалт, ургац хураалтын үеэр асууж нөхнө. Тариалалтын үед **5-6 сар**, ургац хураалтын үед **9-11 сарыг** хамруулна.

**30. Байнгын ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын тоог хүснэгтэд заасан насны ангиллаар, хүйсээр задлан асууж нөхнө.

#### **Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр8)
- Насаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь насаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1>=багана2)

**31. Байнгын ажиллагчдын тоо, гэрлэлтийн байдал, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын тоог гэрлэлтийн байдлаар 5 ангилалд хуваан асууж бүртгэнэ.

**Гэрлэсэн/хамт амьдардаг** – Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг энд хамруулна. Мөн гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч /хугацаа харгалзахгүйгээр/ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хамруулна.

**Огт гэрлэж байгаагүй** – Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

**Тусгаарласан/цуцалсан** – Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүмүүсийг “тусгаарласан” гэнэ. Тусдаа амьдардаг гэдэгт амьжиргааны болон бусад нөхцөлөөр тусдаа амьдардаг /жишээлбэл: эхнэр, нөхрийн аль нэг нь гадаадад амьдардаг, хүүхдүүдээ сургуульд суулгахын тулд сумын төвд хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг гэх мэт/ тохиолдлуудыг оруулахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлээгүй хүмүүсийг “цуцалсан” гэнэ.

**Бэлбэсэн**–Эхнэр юмуу нөхөр нь нас барснаас хойш дахин гэрлээгүй бол “бэлбэсэн” гэж үзнэ.

#### **Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)
- Гэрлэлтийн байдлаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь гэрлэлтийн байдлаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1>=багана2)

**32. Байнгын ажиллагчдын тоо, боловсролын түвшин, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн байнгын ажиллагчдын тоог боловсролын түвшингээр асууж бүртгэнэ. Боловсролын түвшинг ойлголт, тодорхойлолтын дагуу харж нөхнө.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги /1975 он хүртэл мөн 1997 оноос хойш/, 3 дугаар ангийг /1975-1996 онд/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-4 ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги (1975 оныг хүртэл хуучин системээр)1975-1996 оныг дуустал 3-р анги, 1997 оноос хойш 4-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10 (11)-р ангийг өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол** - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/** - Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Боловсролын түвшингээр задалсан дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр10)
- Боловсролын түвшингээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь боловсролын түвшингээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.  
(багана1)>=багана2

**33. Байнгын ажиллагчдаас мэргэжлийн ажиллагчдын тоо, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн өрхийн мэргэжлийн ажиллагчдын тоог хүснэгтэд өгөгдсөн ангиллаар асууж, бүртгэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Мэргэжлийн ажиллагч тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр8)
- Мэргэжлээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь мэргэжлээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.  
(багана1)>=багана2)

**34. Танайх улирлын ажиллагчидтай юу?** Тухайн өрхийг улирлын ажиллагчидтай эсэхийг асууж, улирлын ажиллагчидтай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ажиллагчидгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 37 руу** шилжинэ.

**Улирлын ажиллагчид** улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хамруулна.

**35. Улирлын ажиллагчдыг тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Тухайн өрхийн улирлын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**36. Улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн өрхийн улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр, тариалалт, ургац хураалтыг үеэр, асууж нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**37. Танайх түр ажиллагчид 2011 онд авч ажиллуулсан уу?** Тухайн өрх нь 2011 онд түр ажиллагч авч ажиллуулсан эсэхийг асууж, бүртгэнэ. Хэрэв түр ажиллагч авч ажиллуулсан бол Тийм-1"-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, хөлслөөгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 40 руу** шилжинэ.

**Түр ажиллагчид** хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг хамруулна.

**38. Түр ажилласан ажиллагчдын тоог хэлнэ үү.** Тухайн өрхийн түр ажиллагчдын тоог 2011 оны байдлаар асууж нөхнө.

**39. Түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн өрхийн түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр, тариалалт, ургац хураалтын үеэр асууж нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**40. Танайд ажиллах хүчтэй холбоотой дараах хүндрэл, бэрхшээл тулгарч байна уу?** Энэ асуулт нь ажиллах хүчинтэй холбогдолтойгоор үүссэн хүндрэлийг тодорхойлох зорилготой.

Тухайн өрхийн хувьд гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг хүснэгтэд тавигдсан ангиллаар асууж нөхнө. Хэрэв дурдсан хүндрэл, бэрхшээл тулгардаггүй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, тулгардаг бол Үгүй гэж 2-ыг дугуйлна. Бусдад хүснэгтэд дурдснаас өөр бусад хүндрэл, бэрхшээлийг оруулна.

### **III. ГАЗАР, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ**

#### **III.1. ГАЗРЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**Газар ашиглах** гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчийн хооронд байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж ашиглахыг хэлнэ.

Тухайн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмшлийн байдлыг нь газрын нийт талбай, ХАА-н эдэлбэр газар гэсэн хоёр хэлбэрээр, хүснэгтэд заагдсан ангиллын дагуу асууж нөхнө.

**41. Та өрхийнхөө газар ашиглалтын талаар дараах мэдээллийг хэлнэ үү.**

**Өөрийн эзэмшилд байгаа газар.** Өөрийн эзэмшилд байгаа газрын нийт хэмжээ нь газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийн эзэмшдэг нийт газрын хэмжээ юм. Эзэмшилд байгаа газарт дараах төрлийн газрыг хамруулна. Үүнд:

- ХАА-н газар, нэг наст болон, олон наст ургамал тариалдаг газар, хадлан, бэлчээрийн талбай болон уриншийн талбай;
- Цэцэрлэг, ногооны талбай;

- Ой, модот бусад газар;
- Эзэмшлийн худаг, ус эсвэл тухайн нэгжийн хэрэглээг үл харгалзан тухайн аж ахуйн хяналтанд байдаг худаг, усны талбай;
- Фермийн бусад газар болон фермийн барилга, байгууламж байрладаг газар;

Дараах онцлог тохиолдол байвал сайтар нягталж үзээд доор дурьдсаны дагуу ангилна. Үүнд:

- Хэрвээ өрх ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг бол түүний эзэмшилд байдаг газарт тухайн өрхийн гэр, байшин байрладаг газар мөн орно.
- Тооллогын жилд газар тариалангийн боловсруулалт хийгдсэн байгаа газар болон тариалалтанд бэлдэж боловсруулалт хийгдсэн боловч тооллогын үед тариалалт хийгээгүй байсан газрыг эзэмшилд байгаа газрын хэмжээнд оруулна. Тооллогын өмнөх жилд ашиглахгүй орхисон газрыг харин оруулахгүй.
- Нийтийн эзэмшлийн бэлчээрийн талбай зэрэг бэлчээрийн газрыг тухайн нэгжийн эзэмшлийн газар гэж үзэхгүй. Тухайн нэгж тухайн нийтийн эзэмшлийн талбайд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тухайн нэгжид тусгайлан хашаагаар хүрээлүүлэн ногдуулсанаас бусад газрыг тухайн нэгжийн эзэмшлийн газарт оруулахгүй.
- Эзэмшлийн худаг, ус эсвэл тухайн аж ахуйн хяналтанд байдаг худаг, усыг нэгжийн эзэмшил газрын хэмжээнд оруулах боловч харин ХАА-н биш зорилгоор ашиглахаар бусдаас түрээсэлдэг худаг, усны талбай эзэмшил бүхий газрын хэмжээнд нь оруулахгүй.

**41.2 Бусдад түрээслүүлсэн болон ашиглуулж буй газарт** тухайн өрх бусад аж ахуйн нэгж, иргэнд түрээслүүлж эсвэл ашиглуулж байгаа газрыг оруулна. Түрээслүүлсэн газрыг иргэдэд, аж ахуйн нэгж байгууллагад гэсэн хоёр төрлөөр асууж нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Бусдад түрээслүүлсэн болон ашиглуулж буй газрын хэмжээ нь иргэд, аж ахуйн нэгжид түрээслүүлсэн газрын хэмжээний нийлбэртэй тэнцүү байна. (мөр2=мөр3+мөр4)

**41.5 Бусдаас түрээсэлсэн газарт** тухайн өрх нь газар тариалангийн болон бусад зорилгоор ашиглахаар бусдаас түрээсэлсэн газрын хэмжээг оруулна. Бусдаас түрээсэлсэн газрыг иргэдээс, төрийн болон орон нутгийн өмчит газраас, аж ахуйн нэгж байгууллагаас гэсэн төрлөөр асууж бүртгэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Бусдаас түрээсэлсэн газрын хэмжээ нь иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон орон нутгийн өмчийн газраас түрээсэлсэн газрын хэмжээний нийлбэртэй тэнцүү байна. (мөр5=мөр6:мөр8)

**41.9 Өөрийн эзэмшилд ашиглаж буй газрын хэмжээ.** Өөрийн эзэмшлийн газраас түрээслүүлсэн болон ашиглуулж буй газрын хэмжээг хассантай тэнцүү байна.

**Хийгдэх балансын шалгалт:**

- (мөр9=мөр1-мөр2)

**41.10 ХАА-н эдэлбэр газар.** ХАА-н эдэлбэр газар нь бэлчээр, хадлан, тариалангийн талбай, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн доорх дэвсгэр газар, ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газрын нийлбэртэй тэнцүү байна.

ХАА-н эдэлбэр газрыг газар ашиглалтын хэлбэрээр дараах ангиллаар задлаж, бүртгэнэ. Үүнд:

**41.11 Тариалангийн талбай** буюу эргэлтийн талбай. Тариалсан, уриншилсан, өнжөөсөн талбайг тариалангийн талбай гэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

Тариалангийн талбай нь тариалсан талбай, уриншилсан талбай, өнжөөсөн талбайн нийлбэртэй тэнцүү байна. (Мөр11=мөр12:мөр14)

**41.12 Тариалсан талбай.** Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Тариалсан газарт хүний үйл ажиллагаагаар тарьж ургуулсан ургамал бүхий талбайг хамаарна. Дор дурдсан таримал ургамал бүхий талбайг тариалсан газарт хамаарахгүй.

- байгалийн хадлан, бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор нэг ба олон наст ургамлын үр цацах, услах, бордох зэргээр сайжруулж тордсон бэлчээр, хадлангийн талбай;
- хот, суурингийн дотор тарьж ургуулсан мод болон зүлэгжүүлсэн талбай, хот орчмын ногоон бүс;
- элсний нүүдэл зогсоох зорилгоор тарьсан мод, бут, сөөг.

**41.13 Уриншилсан талбайд** дараа жил ургамал тариалах зорилгоор боловсруулж өнжөөсөн тариалангийн талбайг хамруулна.

**41.14 Өнжөөсөн талбайд** хөрсний үржил шимийг нөхөн сэргээх буюу сайжруулах арга хэмжээ авах болон тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид тариалах үр дутагдах, тухайн жилд ган болох магадлал ихтэй нь тогтоогдсон зэрэг хүндэтгэх шалтгааны улмаас 2 жил хүртэл хугацаанд тариалалт болон уринш хийгээгүй тариалангийн талбайг хамруулна.

**41.15 Хадлангийн талбайд** газрын тухай хуулиар газрын нэгдмэл санд бүртгэгдсэн хадлангийн газар болон холбогдох шатны төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрсөн өвс бэлтгэж болох ургац бүхий бэлчээрийн талбайн хэсгийг хамруулна.

**41.16 Бэлчээрийн талбайд** мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн зориулалттай газар багтна.

**41.17 Атаршсан талбайд** тариалангийн газрын санд бүртгэлтэй боловч хоёроос дээш жил тариалалт, уринш хийгээгүй тариалангийн талбайг хамруулна.

**41.18 Бусад газарт** тухайн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн барилга, байгууламжийн доорх газар буюу ХАА-н барилга, байгууламжийн доорх дэвсгэр газар, хөдөө аж ахуй эрхлэх боломжгүй газрыг хамруулна.

ХАА-н эдэлбэр газар нь тариалангийн, хадлан, бэлчээрийн, атаршсан болон бусад газрын нийлбэртэй тэнцүү байна.

**Хийгдэх балансын шалгалт:**

- $Мөр10 = мөр11 + (мөр15 : мөр18)$
- Газрын нийт талбайгаас ХАА-н эдэлбэр газар сугарна. ХАА-н эдэлбэр газрын хэмжээ нь нийт газрын нийт талбайгаас бага буюу тэнцүү байна. (багана1 >= багана2)

**41.19 ХАА-н эдэлбэр газраас ашиглаж буй газар.** Үүнд ХАА-н эдэлбэр газраас зориулалтын үйл ажиллагаанд ашиглаж буй газрыг салгаж бүртгэнэ.

**41.20 Нийт газраас усалгаатай талбай.** Тухайн өрхийн усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө.

**Усжуулалт** - бэлчээр, хадлангийн болон газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготойгоор хүний оролцоотойгоор газрыг чийгшүүлэн (борооны усаар биш) устай болгох үйл явцыг хэлнэ.

**41.21 2011 онд усалсан талбай.** Тухайн өрхийн ХАА-н зориулалтаар ашиглах зорилгоор 2011 онд усалсан талбайг, га-гаар асууж нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Усалсан талбай нь усалгаатай талбайгаас бага буюу тэнцүү байна. ( $мөр21 = < мөр20$ )

**42. Танайх талбайгаа хамгаалах зорилгоор мод тарьж, ойн зурвас байгуулсан уу?** Тухайн өрх нь хамгаалалтын зорилгоор ойн зурвас байгуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ. Зурвас байгуулаагүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг сонгож, **Асуулт 44** рүү шилжинэ.

- **Ойн зурвас** - мал, амьтан, элс, шорооны нүүдэл, хуурайшил, салхинаас хамгаалах зорилгоор тариалангийн талбайг тойруулан тарьсан мод, бутыг хэлнэ.

**43. Ойн зурвасаар хүрээлэгдсэн нийт талбайн хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн ойн зурвасаар хүрээлэгдсэн нийт талбайн хэмжээг асууж, бүртгэнэ. Талбайн хэмжээг га-гаар бүртгэнэ.

**Асуулт 41.5-д** түрээсэлсэн газар нөхөгдөөгүй бол **Асуулт 44-ийг** алгасч, **асуулт 45 руу** шилжинэ.

**44. Түрээсэлсэн газрын түрээсийн төлбөрийн хэлбэрээ хэлнэ үү.** Тухайн өрхийн бусдаас түрээсэлсэн газрын түрээсийн төлбөрийг дараах 4 төрлөөр асууж бүртгэнэ. Үүнд:

**Мөнгөн төлбөрөөр** - Газрын эзэн болон тухайн газрыг түрээслэн ашиглах өрх хоёрын хооронд шууд бэлэн мөнгөөр төлбөр хийгдэхийг хэлнэ.

**Бүтээгдэхүүний тодорхой хувийг өгөхөөр** - Төлбөрт бүтээгдэхүүний тодорхой хувийг өгөхөөр газрын эзэн, газар түрээслэгч харилцан тохирсон байхыг хэлнэ.

**Нэмэлт үйлчилгээг үнэ төлбөргүй нийлүүлэхээр** - газар түрээслэгч нь үйлчилгээ үзүүлнэ хэмээн баталгаа гаргаж газар ашиглахыг хэлнэ.

**Бусад** - үнэгүй түрээс, эсвэл тодорхой зарим нэг ургамал ургуулж өгөх мэтийн тогтсон нөхцлийн дагуу хийх түрээсийг хамруулна.

**Асуулт 41.17-д** атаршсан талбай нөхөгдөөгүй бол **Асуулт 45-ыг** алгасч, **Бүлэг III.2** руу шилжинэ.

**45. Талбайг атаршсанаас хойших хугацааг хэлнэ үү.** Тариалангийн газрын санд бүртгэлтэй боловч хоёроос дээш жил тариалалт, уринш хийгээгүй тариалангийн талбайг атаршсан газарт хамааруулах бөгөөд тухайн өрхийн талбайд атаршуулалт хийснээс хойш өнгөрсөн хугацааг "Нэг хүртэл жил", "Нэгээс дөрөв хүртэл жил", "Дөрөв ба түүнээс дээш жил" гэсэн ангиллаар бүртгэнэ.

### **III.2 ХӨРСНИЙ ДОРойТОЛ**

**Хөрсний доройтол** гэж, хүний буруутай үйл ажиллагаа, байгалийн болон бусад зүйлийн нөлөөллөөс хөрсний чанар муудаж, органик бодис алдагдах, хөрсний үржил шим буурахыг хэлнэ. Газрын хөрсний доройтлыг дараах тодорхойлолтын дагуу тайлбарлан, тохирох хариултыг нөхнө. Үүнд:

**Доройтолгүй** - Хөрсний доройтол байхгүй

**Өнгөц** - Газрын үржил шим нь бага зэрэг буурсан бөгөөд нөхөн сэргээлтийг хийх боломжтой бол өнгөц гэж үзнэ.

**Дундаж** - Газрын зарим хэсэг нь нэлээн доройтсон бөгөөд ХАА-д ашиглах боломжийг сэргээхийн тулд тодорхой сайжруулалтыг хийх шаардлагатай бол доройтлыг дундаж гэж үзнэ.

**Ноцтой** - Газрын дийлэнх хэсэг нь дахин сэргэхгүйгээр ихээхэн доройтсон, ХАА-н үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон бол доройтол ноцтой болсон гэж үзнэ. Доройтол ноцтой болсоны нэг илрэл нь "Цөлжилт" байж болно.

**46. Тариалангийн талбайн хөрсний доройтлыг тодорхойлно уу.** Тариалангийн талбайн хөрсний доройтлыг "Доройтолгүй", "Өнгөц", "Дундаж", "Ноцтой" гэсэн 4 төрлөөр асууж, тохирох хариултыг дугуйлна.

**47. Хадлан, бэлчээрийн талбайн хөрсний доройтлыг тодорхойлно уу?** Тухайн өрхөөс хадлан бэлчээрийнх нь талбай нь хөрсний доройтолтой байгаа эсэхийг "Доройтолгүй", "Өнгөц", "Дундаж", "Ноцтой" гэсэн 4 төрлөөр асууж, тохирох хариултыг дугуйлна.

**48. Танайх агрохимийн шинжилгээ хийлгэсэн үү?** Тухайн өрхөөс агрохимийн шинжилгээ хийлгэсэн эсэхийг асууж, шинжилгээ хийлгэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ. Хийлгээгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан усалгаатай тариалангийн хэсэг рүү буюу **Бүлэг III.3** руу шилжинэ.

Тариалангийн газрын хөрсний чанар, үржил шимт байдлыг агрохимийн шинжилгээгээр тодорхойлно. Агрохимийн шинжилгээг "Монгол улсын газрын тухай хууль"-нд заасанчлан 5 жил тутамд нэг удаа заавал хийлгэх учраас 2007 оноос хойшхи хугацааг хамруулна.

**49. Агрохимийн сүүлийн шинжилгээ хийлгэсэн огноог хэлнэ үү.** Тухайн өрхөөс агрохимийн шинжилгээ хийлгэсэн эсэхийг асууж, шинжилгээ хийлгэсэн гэж хариулсан тохиолдолд хамгийн сүүлд хийлгэсэн огноог асууж, асуулгад нөхнө.

**50. Агрохимийн сүүлийн шинжилгээгээр тариалангийн талбайн доройтол ямар түвшинд байсан бэ?** Хөрсний доройтлыг хамгийн сүүлд хийлгэсэн агрохимийн шинжилгээний дүнгээр, дараах 6 ангиллын дагуу асууж нөхнө. Үүнд: "Хөрсний 0-40 см гүний ялзмаг" "Хөрсний нитратын азот", "Хөрсний хөдөлгөөнт фосфор", "Хөрсний

хөдөлгөөнт кали”, “Хөрсний бүхэлшил”, “Усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт” орно.

Хөрсний доройтлын 3 төрлийн бүтцийн өөрчлөлтийн зэрэглэл байдаг. Үүнд:

1. Ус, хүчтэй бороо, салхи болон бусад хүчин зүйлүүдээс болон хагалбар газрын үе давхарга буурснаас **хөрсний бүтцийн өөрчлөлт** гарахыг “хөрсний 0-40 см гүний ялзмаг” -аар илэрхийлнэ.
2. Тэжээл болон органик бодис, давслаг, ислэг, шүлтлэгээ алдсанаас болоод хөрсний **химийн чанар буурах буюу бохирдохыг** хөрсний нитратын азот, хөрсний хөдөлгөөнт фосфор, хөрсний хөдөлгөөнт кали”–гаар илэрхийлнэ.
3. Нягтаршил, давхарга болон хөрсний суулт зэрэг хөрсний **биет доройтлыг** “хөрсний бүхэлшил, усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт” харуулна.

### III.3 УСАЛГААТАЙ ТАЛБАЙ

**51. Танайх усалгаатай тариалан эрхэлдэг үү?** Тухайн өрхөөс усалгаатай тариалан эрхэлдэг эсэхийг асууж эрхэлдэг бол Тийм гэж 1-ийг дугуйлж, **асуулт 53 рүү** шилжинэ. Усалгаатай тариалан эрхэлдэггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, эрхлэхгүй байгаа шалтгааныг асууж нөхнө.

**52. Танайх усалгаатай тариалан эрхлэхгүй байгаа шалтгаанаа хэлнэ үү.** Тухайн өрхөөс усалгаатай тариалан эрхлэхгүй байгаа шалтгааныг “Усны эх үүсвэр дутмаг”, “Санхүүгийн боломж муу”, Ажиллах хүч дутмаг”, “Техник эвдэрсэн”, “Услах шаардлагагүй”, “Бусад ” гэсэн 5 хэлбэрээр асууж нөхнө. Шалтгааныг асууж нөхсний дараа **Бүлэг IV рүү** шилжинэ.

**54. Усалгаатай талбайнхаа талаарх дараах мэдээллийг хэлнэ үү.** Тухайн өрхөөс усалгаатай талбайг бүгд дүн, талбайн болон ургамлын төрлөөр нь ангилан асууж нөхнө.

Усалгаатай талбайн бүгд дүн нь **Бүлэг 41-ын 20-д тавигдсан дүнтэй** тэнцүү байна.

**Талбайн төрлөөр асуух усалгаатай талбайг** “Нэг наст ургамлын талбай”, “Олон наст ургамлын талбай” гэсэн ангиллаар задлан асууна.

**Нэг наст ургамлын талбай** гэж нэг жил хүртэлх хугацаанд ургац хурааж авах боломжтой ургамлыг тарихад ашигласан газрыг хэлнэ. Талбайдаа нэг жилээс дээш хугацаагаар өнждөг зарим ургамлыг нэг наст ургамалд тооцно.

**Олон наст ургамлын талбай** тодорхой нэг жилд тариалаад, үр жимсээ өгтөл нь ахин тариалалт хийхгүй олон наст ургамлыг тариалсан газрыг хэлнэ. Үүнд жимс, жимсгэний талбай орно. Олон наст хадлан, бэлчээрийн газар нь уг газарт хамаарагдахгүй.

**Усалгаатай талбай, ургамлын төрлөөр.** Усалсан талбайг дараах ургамлын төрлөөр задалж тодорхойлон нөхнө. Үүнд:

+ <u>Үр тариа</u>	+ <u>Төмс</u>
- буудай	+ <u>Хүнсний ногоо</u>
- арвай	+ <u>Тэжээлийн ургамал</u>

- овъёос	+ <u>Техникийн ургамал</u>
- хөх тариа	+ <u>Эмийн ургамал</u>
- бог будаа	+ <u>Хадлангийнх</u>
- бусад	+ <u>Жимс, жимсгэнийх</u>

**Хийгдэх балансын шалгалт:**

- Усалгаатай нэг наст болон олон наст ургамлын талбайн нийлбэр нь усалгаатай талбайн бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2+мөр3)
- Усалгаатай үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн болон техникийн ургамал, эмийн ургамал, хадлан, жимс, жимсгэний, бусад ургамлын талбайн нийлбэр нь нийт усалгаатай талбайн дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр4+мөр11:мөр18)
- Усалгаатай үр тарианы талбайн хэмжээ нь буудай, арвай, овъёос, хөх тариа, бог будаа, бусад төрлийн үр тарианы усалгаатай талбайтай тэнцүү байна. (мөр4=мөр5:мөр10)

**53. Усжуулалтын системийнхээ төрлөө хэлнэ үү.** Тухайн өрхийн ашиглаж байгаа усжуулалтын системийн төрлийг “инженерийн хийцтэй”, “энгийн уурхайн”, “бусад” гэсэн ангиллаар задлан асууна.

**Усжуулалтын систем** гэж бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорх усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолборыг хэлнэ. Инженерийн хийцтэй усжуулалтын системд дараах төрлийн худаг, усан санг хамруулна. Үүнд:

**55. Усжуулалтын систем ажиллуулахад төрөөс дэмжлэг авсан уу?** Тухайн өрх усжуулалтын системийг үйл ажиллагаандаа ашиглахдаа төрөөс дэмжлэг авсан эсэхийг асууж төрөөс дэмжлэг авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дэмжлэг аваагүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг сонгоно.

**56. Танайх ямар аргаар усалгаа хийсэн бэ?** Тухайн өрх нь ямар аргыг ашиглаж усалгаагаа хийснийг “Гадаргуугаар урсгах”, “Бороожуулах”, “Мананжуулах”, “Дуслын системний аргаар”, “Хөрсөн дотроос нэвчүүлэх” гэсэн ангиллын дагуу асууж, асуулгыг нөхнө.

**Газрын гадаргын ус ашиглан усалсан** - Усжуулах зорилгоор устай газрыг бүрэн болон хэсэгчлэн хамруулах систем юм. Газар хагалах, талбайг зааглах болон сав газрын усжуулалт зэрэг олон төрөлтэй.

**Бороожуулах** - Шүршигч цоргоор усыг тодорхой даралтаар тариалан руу дамжуулах сүлжээг харуулна. Энэ систем нь аадар бороотой төстэй усыг дээрээс цацах систем юм. Шүршигч системийг заримдаа дээрээс усжуулах систем гэж ойлгож болно.

**Дуслын системийн аргаар** - Бага даралтаар хоолойгоор дамжуулан усыг түгээх систем юм. Үүний хэд хэдэн төрөл бий: дусал усалгаа (хөрсний гадаргуу руу ус аажуухнаар дусах), шүрших эсвэл жижиг шүршүүрэн усалгаа (ус хөрс болон ойролцоох ургамал, мод рүү цацагдах) болон хөөсөн усалгаа (усны жижиг урсгал үерийн жижиг сав газар эсвэл мод бүрийн хөрс рүү шингэх). Тогтоосон усжуулалтын түгээмэл хэрэглэгддэг бусад төрөлд микро усжуулалт, годгодох усалгаа, өдөр тутмын усалгаа, дусал усалгаа, шимэх усалгаа зэрэг болно.

**57. Усжуулалтын эх үүсвэрээ хэлнэ үү.** Тухайн өрх нь усжуулалт хийхдээ усалгааны ямар эх үүсвэрийг ашиглаж байгааг асуулгад тусгагдсан “Газрын доорхи усаар (өрмийн худгаар)”, “Газрын доорхи усаар (энгийн уурхайн худгаар)”, “Газрын дээрх усаар (гол, нуур, цөөрөм, булаг, шандны усаар)”, “Газрын дээрх усаар (ус хуримтлуулах усан сан бүхий боомтын усаар)”, “Газрын дээрх усаар (ус нөөцлөх саванд хадгалсан усаар)”, “Цэвэршүүлсэн хаягдал усаар”, “Бороо, цасны ус хуримтлуулж усалдаг”, “Үерийн, эргээс хальсан усыг ашиглаж усалдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө.

**58. Танайх усны төлбөр төлдөг үү?** Тухайн өрх нь усны төлбөр төлдөг эсэхийг асууж, төлбөр төлдөг бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ, төлдөггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг сонгоно.

**59. Усны төлбөрийн нөхцлөө хэлнэ үү.** ХАА-н нэгжийн усалсан талбайн усны төлбөр хийгдсэн эсэхийг харуулна. Төлбөрийг “Ахуйн хэрэглээнд үндэслэж”, “Үйлдвэрлэлийн хэрэглээнд үндэслэж”, “Бусад” гэсэн ангиллаар асууж, бүртгэн нөхнө.

#### IV. ГАЗАР, ТАРИАЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**60. Тариалсан болон хураасан талбайн хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн өрхийн тариалсан нийт талбай болон хураасан нийт талбайн хэмжээг ургамлын төрлөөр га-гаар нөхнө. Хэрэв өрхийн хувьд тариалсан талбайг м<sup>2</sup>, сот-оор хэмжиж байвал доорх итгэлцүүрийг ашиглан га-д шилжүүлэн тавина.

##### Хэмжих нэгжид шилжүүлэх итгэлцүүр

1 га	=	10000	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000 м <sup>2</sup>	=	1 га

**Тариалсан талбай** - тариалангийн үйлдвэрлэл эрхлэх зориулалттай иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаахөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Тариалсан газарт хүний үйл ажиллагаагаар тарьж ургуулсан ургамал бүхий тариалангийн талбайг хамруулна. Дор дурдсан таримал ургамал бүхий талбайг тариалсан газарт хамруулахгүй.

- байгалийн хадлан, бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор нэг ба олон наст ургамлын үр цацах, услах, бордох зэргээр сайжруулж тордсон бэлчээр, хадлангийн талбай;
- хот, суурингийн дотор тарьж ургуулсан мод болон зүлэгжүүлсэн талбай, хот орчмын ногоон бүс;
- элсний нүүдэл зогсоох зорилгоор тарьсан мод, бут, сөөг.

**Ургац хураасан талбай** гэж тариалсан нийт талбайгаас ургацыг хураасан нийт талбайг хэлнэ. Тиймээс, ган гачиг, үер ус, хортон шавьжны болон бусад шалтгааны улмаас сүйтгэгдсэн талбайг оруулахгүй.

**Үр** гэж тухайн сортын нөхөн үржлийг хангах чадвартай, дахин сэргээх, үржүүлэх болон аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа амьд үр, суулгац, тарьцыг хэлнэ.

**Шилмэл сортын үр** гэж тухайн бүс нутагт биологи, аж ахуйн нийтлэг болон тодорхой шинжээр шалгарч, үндэсний стандартыг хангасан, сорт сорилтын зөвлөлөөр батлагдан, тариалах сортын нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэн сортын үрийг хэлнэ. Буудайн Орхон, Дархан-34, Дархан-74, Бурятская-34, Бурятская-79, Халхгол-1, Цагаан

дэглий, төмсний голландын Импала, Санте, германы Витара зэрэг нь шилмэл сортын үрэнд орно.

Дээр тодорхойлсон тариалсан талбай, шилмэл сортын үрээр тариалсан талбай, ургац хураасан талбай нь таримлын дараах төрөл тус бүр дээр нөхөгдөнө. Үүнд:

<b>+ <u>Үр тариа</u></b>	<b>+ <u>Төмс</u> <b>+ <u>Хүнсний ногоо</u></b></b>	<b>+ <u>Тэжээлийн ургамал</u></b>	<b>+ <u>Техникийн ургамал</u></b>
<ul style="list-style-type: none"> <li>- буудай</li> <li>- арвай</li> <li>- овъёос</li> <li>- хөх тариа</li> <li>- бог будаа</li> <li>- бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- байцаа</li> <li>- шар манжин</li> <li>- улаан манжин</li> <li>- лууван</li> <li>- сонгино</li> <li>- сармис</li> <li>- өргөст хэмх</li> <li>- улаан лооль</li> <li>- тарвас, гуатан</li> <li>- бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ногоон тэжээл</li> <li>- олон наст</li> <li>- даршны ургамал</li> <li>- бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Наранцэцэг</li> <li>- Эрдэнэшиш</li> <li>- чихрийн манжин</li> <li>- тосны ургамал</li> <li>- бусад</li> </ul> <p><b>+ <u>Эмийн ургамал</u></b> <b>+ <u>Жимс, жимсгэнэ</u></b></p>

**Хийгдэх балансын шалгалт:**

- Шилмэл сортын үрээр тариалсан болон ургац хураасан талбайн дүн нь нийт тариалсан талбайгаас сугарч гарна. (багана1>=багана2), (багана1>=багана3)
- Нийт тариалсан талбай, шилмэл сортын үрээр тариалсан талбай, ургац хураасан талбай нь ургамал тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.  
(мөр1=мөр2+мөр9+мөр10+мөр22+мөр28+мөр35:мөр38)
- Хүнсний ногооны хувьд: нийт тариалсан, шилмэл сортын үрээр тариалсан, ургац хураасан талбай тус бүр нь хүнсний ногооны төрөл тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.  
(мөр10=мөр11:мөр21)
- Тэжээлийн ургамлын хувьд: нийт тариалсан, шилмэл сортын үрээр тариалсан ургац хураасан талбай тус бүр нь тэжээлийн ургамлын төрөл тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.  
(мөр22=мөр23:мөр27)
- Техникийн ургамлын хувьд: нийт тариалсан, шилмэл сортын үрээр тариалсан, ургац хураасан талбай тус бүрийн дүн нь техникийн ургамлын төрөл тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.  
мөр28=(мөр29:мөр34)

**61. Танайх хүлэмжийн тариалалт хийдэг үү?** Тухайн өрхөөс хүлэмжийн тариалалт хийсэн эсэхийг асууж Тийм гэж 1-ийг дугуйлж, **Асуулт 64 рүү** шилжинэ. Усалгаатай тариалан эрхэлдэггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, эрхлэхгүй байгаа шалтгааныг асууж нөхнө.

**62. Хүлэмжийнхээ нийт талбайн хэмжээгээ хэлнэ үү.** Энд тухайн өрхийн хүлэмжинд тариалсан нийт талбай болон хураасан нийт талбайн хэмжээг ургамлын төрлөөр, м<sup>2</sup>-аар асууж нөхнө.

**63. Хүлэмжийн суулгац суулгасан нийт талбай, ургац хураасан талбай, ургацын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн өрх, аж ахуйн нэгж, иргэний хүлэмжинд тариалсан нийт талбай, шилмэл сортын үрээр тариалсан талбай, хураасан нийт талбай, ургацын хэмжээг асууж, ургамлын төрлөөр задлан нөхнө.

Хүлэмжинд тариалсан ургамлыг дараах төрлөөр нь асууна. Үүнд:

<p>+ <b><u>Хүнсний ногоо</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- өргөст хэмх</li> <li>- улаан лооль</li> <li>- салат</li> <li>- перец</li> <li>- хаш</li> <li>- чинжүү</li> <li>- навчит ногоо</li> <li>- бусад</li> </ul>	<p>+ <b><u>Гүзээлзгэнэ</u></b></p> <p>+ <b><u>Хүнсний ногооны үрслэг</u></b></p> <p>+ <b><u>Цэцэгний суулгац</u></b></p> <p>+ <b><u>Цэцэг</u></b></p> <p>+ <b><u>Мөөг</u></b></p> <p>+ <b><u>Бусад</u></b></p>
---	--

Дээрх хүлэмжинд тариалсан ургамлын төрлөөс өөр төрлийн ургамал хүлэмжинд тариалсан бол бусад гэсэн хэсэгт нэрийг нь бичиж нөхнө.

Шилмэл сортын үрээр тариалсан болон ургац хураасан талбайн хэмжээ нь нийт талбайгаас сугарч гарах бөгөөд нийлбэр нь нийт дүнтэй барихгүй.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Шилмэл сортын үрээр тариалсан болон ургац хураасан талбай хэмжээ нь талбай тус бүрээр нийт дүнгээс бага буюу тэнцүү байж болно. (Багана1>=багана2), (багана1>=багана3)
- Хүлэмжийн суулгасан бүгд талбай нь хүнсний ногоо, гүзээлзгэнэ, хүнсний ногооны үрслэг, цэцэгний үрслэг, цэцэг, мөөг, бусад төрлийн ургамлын суулгасан талбайн нийлбэртэй тэнцүү байна. (мөр1=мөр4+мөр13+мөр20)
- Хүнсний ногооны суулгасан талбай нь ургамал тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр4=мөр5:мөр12)

**64. Танайх жимс, жимсгэнэ тариалсан уу?** Тухайн өрх жимс, жимсгэний тариалдаг бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, тариалдаггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, **Асуулт 66 руу** шилжинэ.

**65. Жимс, жимсгэнэ тариалсан нийт талбай, мод, бутны тоогоо хэлнэ үү.** Тухайн өрхийн жимс, жимсгэний талбай, суулгасан мод, бутны тариалсан тоо хэмжээг жимс жимсгэний төрлөөр асууж нөхнө. Мөн үр жимсээ өгөх тариалсан талбай, суулгасан мод, бутны тоог ургамлын төрлөөр ангилан асуулгад нөхнө.

Жимс, жимсгэний тариалсан талбайг нийт, үүнээс үр жимсээ өгөх, суулгасан мод бутны тоог нийт, үүнээс үр жимсээ өгөх гэж ангилан, хүснэгтэд тавигдсан жимс, жимсгэний төрлөөр бүртгэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нийт тариалсан талбайгаас үр жимсээ өгөх талбайг сугалж харуулах бөгөөд үр жимсээ өгөх талбай нь нийт талбайтай тэнцүү эсвэл бага байна. (багана1>=багана2),
- Суулгасан мод, бутны нийт дүнгээс үр жимсээ өгөх мод, бутны тоог салгаж харуулах бөгөөд үр жимсээ өгөх мод, бутны тоо нь суулгасан нийт мод, бутны дүнтэй тэнцүү буюу бага байна. (багана3>=багана4)
- Тариалсан талбайн бүгд дүн нь жимс, жимсгэнэ тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр14)
- Жимс, жимсгэний мод, бутны суулгацын бүгд дүн нь жимс, жимсгэнэ тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр16=мөр16:мөр21)

**66. Танайх ургамал хамгаалах болон хөрс сайжруулах зорилгоор бордоо, бодис ашигласан уу?** Тухайн өрхийг бордоо, бодис хэрэглэсэн эсэхийг асууж, хэрэглэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлна, хэрэглээгүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, **Бүлэг V руу** шилжинэ.

**67. Танайх ашигласан бордооныхоо талаар дараах мэдээллийг өгнө үү.** Тухайн өрх ургамал хамгаалалт, хөрс сайжруулахдаа ашигласан бордоо, бодис, бордсон талбай, хортон шавж устгасан талбайг бордоо, бодисны нэр төрлөөр асууж, асуулгад нөхнө. Хэрэглэсэн бордоо, бодис нь тонноор, бордсон талбай, хортон шавжны устгал хийсэн талбай м<sup>2</sup>-аар илэрхийлнэ.

**Бордоо** гэж эрдэс болон органик бодисыг хэлэх бөгөөд бордоог тэжээллэг ургац авах болон ургацын өсөлтийг нэмэгдүүлэхэд хэрэглэдэг. “Бордоо”-ны нөхцөл нь дор хаяж 5 хувийн N, P2O5 болон K2O гэсэн 3 анхдагч тэжээллэгийн бүрдлийг агуулсан ургацын тэжээллэгийн эх үүсвэр болно. Дээрхи 3-ын 5 хувиас доош тэжээллэг агуулсан бүтээгдэхүүнийг ургамлын өсөлтийг нэмэгдүүлдэг бусад органик бодист оруулна. ХАА-н үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд бордооны нэг болон түүнээс дээш хэлбэрийг ашиглаж болно.

**Бодис нь** тариалангийн газарт хортон шавж устгах зорилгоор ашигласан бодис юм.

**Бордоо, бодисыг** дараах байдлаар ангилна. Үүнд:

**Байгалийн гаралтай органик бордоо.** Боловсруулалт хийсэн ургамал болон амьтны биеэс эсвэл боловсруулалт хийгдээгүй дор хаяж 5 хувийн ургамлын тэжээлийг эрдэс бордоотой (тос, фосфор гэх мэт) нийлүүлэн гаргаж авсан бордоо юм. Органик бордоо нь яс, хоол, загасны хоол, арьс болон цус зэрэг амьтнаас гаргаж авсан зарим нэгэн органик бодисыг агуулна. Гүмины бордоо, биоалзмагийн бордоо, био бордоо, бактерийн бордоо зэрэг орно.

**Ургацын өсөлтийг нэмэгдүүлдэг бусад органик бордоо** - Хөрсний дутуу байгаа тэжээлийн агууламжийг болон бусад дутагдлыг нь нөхөхөд зориулагдсан. Өтөг бууц, шавар, холимог бордоо болон сангас гэх мэтийн бусад органик бодисууд нь шаардлагатай тэжээллэгээс бага тэжээл агуулдаг ба үүнийг “ургацын өсөлтийн нэмэгдүүлдэг бусад органик бордоо” гэж үздэг. Үүнд өтөг бууц, малын баас, холимог бордоо, шавар, зэрлэг жимс, үртэс, ургамлын үлдэгдэл, нийлэг хөрсний ангижруулагч гэх мэт багтана. **“Өтөг бууц”** нь малын үлдэц, баас, шивтэр, малын хэвтэр, бууц зэргээр хийсэн бордоо юм. **“Шавар”** нь усаар шингэлсэн эсвэл шингэлээгүй амьтны хатсан ялгадсыг шингэнтэй хольсон бордоо юм. **“Холимог бордоо”** нь ургамал, амьтны органик бодисын нэрмэлээс бүрдэнэ. **“Сангас”** нь бохирос гаргасан органик бодисын үлдэгдэл юм.

**Эрдэс бордоо** - органик биш бодисоос үйлдвэрийн аргаар гаргаж авсан бордоо юм. Эрдэс бордоог “химийн бордоо”, “байгалийн биш бордоо” болон “органик бус

бордоо” гэх зэргээр нэрлэдэг. Азот, фосфор, кали, нийлмэл бордоо энэ хэсэгт орно.

**Пестицид** гэж мал, амьтан, ургамлыг аливаа өвчнөөс сэргийлэх, хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах зориулалттай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.

**Гербицид** таримал ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх зориулалттай.

**Инсектицид** хортон шавж устгах, ургамлыг өвчнөөс сэргийлэх, ялзрахаас хамгаалах зориулалттай.

**Фунгицид** үр тариа, төмс, хүнсний ногооны үр, агуулах, зоорь ариутгах зориулалттай.

**Родентицид** таримал ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх зориулалттайгаар тус тус хэрэглэгдэнэ.

**Биологийн бэлдмэл** бэлчээрийн хөнөөлт шавж, мэрэгчтэй тэмцэх зориулалттай.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Эрдэс бордооны бүгд дүн нь бордооны төрөл тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр3=мөр4:мөр7)
- Пестицидийн нийт дүн нь пестицидийн төрөл тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр8=мөр9:мөр13)

## V. ХАА-Н ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ

**68. ХАА-н гаралтай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хураасан ургацын хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хураасан ургацын хэмжээг асууж нөхнө. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хураасан ургацын хэмжээг сануулах замаар ярилцаж, нөхнө.

Нийт үйлдвэрлэсэн, хураасан бүтээгдэхүүн, түүний хэрэглээ, зарцуулалтыг (үрэнд хэрэглэсэн, өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн) хүснэгтэд нэр заан өгсөн нэр төрлөөр асууж бүртгэнэ. Бүртгэхдээ хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжийг сайтар анхаарна.

Хариулагч хэмжих нэгжийг хүснэгтэд тавигдснаас өөрөөр хэлсэн тохиолдолд хүснэгтэд тавигдсан хэмжих нэгж рүү шилжүүлэхдээ доорх итгэлцүүрийг ашиглана.

### Хэмжих нэгж рүү шилжүүлэх итгэлцүүр

1 кг	=	1000 гр
1 т	=	1000 кг
1 л	=	1.03 кг

Хүснэгтэд нэр зааснаас өөр бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бол “Бусад” мөрөнд нэрийг бичиж бүртгэнэ.

Дараах балансын шалгалтыг хийнэ. Үүнд:

- Нийт үйлдвэрлэлт нь үрэнд болон өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлс, урамшуулалд олгосон, нөөцөлсөн болон бусад

хэлбэрээр хэрэглэсэн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна. (багана1=багана2:багана8)

- Үр тарианы төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт үйлдвэрлэсэн үр тариатай тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр6)

**69. Танайх бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг вэ?** Тухайн өрх үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ, хэнд, хаана ихэвчлэн борлуулж байгааг “Хувь хүн ирж авдаг”, “Аж ахуйн нэгж, байгууллагад”, “Зах зээлд өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Борлуулалтыг нөхөхдөө хамгийн их борлуулалт хийдэг 3-аас илүүгүй хэлбэрийг дугуйлна.

Бүтээгдэхүүнээ хөдөөд ярьж заншснаар мах, ноос, ноолуур, төмс, хүнсний ногоо зэргийг өөрсдөө ирж авдаг түүхий эдийн ченжүүд болон хувь хүнд борлуулсан бол “Хувь хүн ирж авдаг”, мах, ноос, төмс, хүнсний ногоо бэлтгэдэг компанийн төлөөлөгч өрх, хувь хүн, хоршоо зэрэгт борлуулсан бол “Аж ахуйн нэгж, байгууллагад”, сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол “Зах зээлд өөрсдөө борлуулдаг” гэсэн сонголтыг хийнэ. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол “бусад” гэсэн ангилалд оруулна.

**70. Танай бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой гардаг хүндрэлээ хэлнэ үү.** Тухайн өрх үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад гарч байгаа хүндрэлийг “Борлуулалт удаашралтай”, “Хэрэглэгч цөөн”, “Өрсөлдөгч олон”, “Үнэ хямд”, “Бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай”, “Зах зээлээс алслагдсан”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж нөхнө. Хүндрэлийг нөхөхдөө хамгийн их тохиолддог 3-аас илүүгүй хүндрэлийг сонгоно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**71. Танайх бүтээгдэхүүнийхээ үнийг хэрхэн тогтоодог вэ?** Тухайн өрхийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнээ хэрхэн тогтоож байгааг “Зардал дээр ашгийг нэмэх замаар”, “Хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр”, “Өрсөлдөгчийн үнээс хамаарч”, “Зах зээлийн үнэ, ханшаар”, “Бусад” гэсэн төрлөөр асууж нөхнө. Үнээ тогтоодог 3-аас илүүгүй аргыг сонгоно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**72. Танайх 2011 онд ургац алдсан уу?** Тухайн өрхийн алдсан ургацын хэмжээг асууж нөхнө. Ургац алдсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ургац алдаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, **Бүлэг VI руу** шилжинэ.

**73. Ургац алдсан шалтгаанаа нэрлэнэ үү.** Тухайн өрхийн ургацаа алдсан шалтгааныг “Үерт автагдсан”, “Ган болсон”, “Мөндөрт цохиулсан”, “Цочир хүйтэрсэн”, “Цасанд даруулсан”, “Хүчтэй салхи, шуурганд цохигдсон”, “Зэрлэг ургамал, хортон шавж идсэн”, “Мал талхалсан”, “Тариалалтын горим алдагдсан”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж, бүртгэнэ.

## **VI. ГАЗАР, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

**74. Танайх өөрийн өмчийн газартай юу?** Тухайн өрх өөрийн өмчийн газартай эсэхийг асууж газартай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, газаргүй бол Үгүй гэж 2 –ыг дугуйлж, **Асуулт 77 руу** шилжинэ.

**75. Газрын үнэлгээгээ хэлнэ үү.** Тухайн өрхийн газрын үнэлгээг асууж, сая төгрөгөөр нөхнө. Газрын үнэлгээг тухайн хариулагчийн өөрийн хэлснээр бүртгэнэ.

**76. Газрын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн өрхийн захиран зарцуулах эрх бүхий газрын хэмжээг асууж бүртгэнэ. Газрын хэмжээ нь га-гаар байна.

Га-д шилжүүлэхдээ дараах итгэлцүүрийг ашиглана:

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000м <sup>2</sup>	=	1 га

**77. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй юу?**  
Тухайн өрх машин, тоног төхөөрөмжтэй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, машин, тоног төхөөрөмжгүй бол Үгүй гэж 2 –ыг дугуйлж, **Бүлэг VII руу** шилжинэ.

**78. Хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийнхөө талаарх мэдээллийг хэлнэ үү.** Машин, тоног төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн машин болон түрээслэн ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоо, төрөл тус бүрээр нь нөхнө.

Машин, тоног төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн тоо, түрээслэн ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоог төрөл тус бүрээр нь нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжид** өөрийн, хамтын эзэмшлийнх болгосон эсвэл зээл болон лизингээр худалдаж авсан машин, тоног төхөөрөмжийг оруулна.

**Түрээсэлсэн машин, тоног төхөөрөмжид** төрийн байгууллагаас болон бусдаас түрээсэлсэн, төлбөртэй болон төлбөргүйгээр зээлж ашигласныг энд хамруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанд** тухайн машин, тоног төхөөрөмжийг худалдаж авсан үеэс судалгааны үе хүртэлх хугацааг оруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг бүртгэхдээ** тухайн өрхийн тэргүүлэгчийн өөрийн хэлснээр үнэлгээг бүртгэж авна.

Хөрөнгийн үнэлгээг **мянган төгрөгөөр** илэрхийлнэ. Тухайн өрхийн ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийг дараах жагсаалтаас харж, хүснэгтэд тохирох кодыг тавина.

**Машин, тоног төхөөрөмжийн код:**

Анжис	01	Дуслын услалтын төхөөрөмж	17	Будаа цэвэрлэгч	33	Явган трактор , тоног төхөөрөмжийн иж бүрдлийн хамт (10 м.х-ээс бага)	49
Эргэдэг борной	02	Бороожуулагч төхөөрөмж (1 га хүртэл талбай услах)	18	Будаа ачигч	34	Бага оврын дугуйт трактор (10-20 м.х)	50
Бусад борной	03	Бороожуулагч төхөөрөмж (1-10 га талбай услах)	19	Механикжсан үтрэм	35	Дунд оврын дугуйт трактор (25-60 м.х)	51
Бул	04	Бороожуулагч төхөөрөмж (10 га-аас дээш талбай услах)	20	Хор цацагч	36	Зүтгэх хүчний дугуйт трактор (80-130 м.х)	52
Өргөн холбоо	05	Цайруулагч	21	Сэрээ	37	Дугуйт трактор (139-275 м.х)	53
Газар хагалагч	06	Үр тарианы комбайн	22	Бага оврын тракторын хадуур	38	Дугуйт трактор (275-аас дээш м.х)	54
Сийрүүлэгч, зээтүү, культиватор	07	Төмсний комбайн	23	Морин хадуур	39	Морин тэрэг	55
Сэндэчлүүр	08	Даршны өөрөө явагч комбайн	24	Бусад хадуур	40	Үхэр тэрэг	56
Үр тарианы үрлүүр	09	Даршны чиргүүлийн комбайн	25	Бага оврын тракторын тармуур	41	Тэмээн тэрэг	57
Тэжээлийн болон техникийн таримлын үрлүүр	10	Ногоон тэжээл хэрчигч комбайн	26	Морин тармуур	42	Суудлын машин	58

Төмсний үрлүүр	11	Өөрөө явагч жатка	27	Бусад тармуур	43	Ачааны машин	59
Хүнсний ногооны үрлүүр	12	Чиргүүлийн жатка	28	Хаман боогч	44	Мотоцикл	60
Хуурай эрдэс бордоо цацагч	13	Дүүжин жатка	29	Пресслэгч машин	45	Хөргөгч	61
Бууц цацагч	14	Төмс сортлогч	30	Нуруулдагч	46	Бусад төхөөрөмж	62
Нэвчүүлэх усжуулах төхөөрөмж	15	Нэг эгнээний төмс ухагч	31	Чиргүүл	47		
Мананжуулах услалтын төхөөрөмж	16	Хос эгнээний төмс ухагч	32	Гинжит трактор	48		

## VII. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

**79. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын барилга, байгууламжтай юу?** Тухайн өрхөөс зориулалтын барилга, байгууламжтай эсэхийг тодруулан асууж, барилга, байгууламжтай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, барилга, байгууламжгүй бол Үгүй гэж 2–ыг дугуйлж, **Бүлэг VIII руу** шилжинэ.

**80. Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн өрхийн ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн талаарх мэдээллийг асууж нөхнө. ХАА-н барилга, байгууламжийг тоо, ширхэг, багтаамжаар бүртгэж, эзэмшлийн төрлөөр нь ашиглаж байгаа, бусдад түрээслүүлсэн, ашиглахгүй байгаа гэсэн ангиллаар бүртгэнэ. Мөн бусдаас түрээсэлсэн хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн тоог асууж нөхнө.

ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн ашигласан хугацаа, хөрөнгийн үнэлгээг нэр төрлөөр, асууж бүртгэнэ. Хөрөнгийн үнэлгээг мянган төгрөгөөр илэрхийлнэ. Үнэлгээг бүртгэхдээ хариулагчийн өөрийн хэлсэн үнэлгээгээр нөхнө.

Тухайн өрхийн ХАА-н зорилгоос бусад зорилгоор ашигласан орон сууцны бус барилга, байгууламжийг энд оруулахгүй.

Дээрх үзүүлэлтүүдийг “Албан газрын зориулалттай барилга”, “Хүлэмж”, “Агуулах”, “Зоорь”, “Үр тарианы элеватор”, “Үтрэм”, “ХАА-н техник хадгалах байгууламжбуюу гарааш”, “ХАА-н техникийн засварын газар”, “Бусад ” гэсэн ангиллаар асууж бүртгэнэ.

“ХАА-н техникийн засварын газар”-т машины гарааш болон бусад тоног төхөөрөмж хадгалах байр багтана.

Агуулахад үр тариа, өвс, бусад материалыг хадгалах зориулалтаар мод, чулуу, тоосго, брезент, блок зэргийг ашиглан барьсан ХАА-н үйлдвэрлэлийн барилгыг хамруулна.

Зооринд төмс, хүнсний ногоо, мах хадгалах зориулалтаар газар ухаж гаргасан байрыг оруулна. Мөн төмс, хүнсний ногоог хүлээн авах, ялгах үйл ажиллагааг техникээр гүйцэтгэдэг, хадгалалтын горимыг автоматаар тохируулах боломжтой механикжсан зоорь, гар аргаар газар ухаж, дулаалга хийсэн энгийн зоорь, гэр, сууцны дотор талд мөн газар ухаж гаргасан нүхэн зоорь, мөн газрыг цооноглон ухаж хадгалах тасалгаа хийсэн нүхэн зоорийг зооринд тус тус хамруулна. Зоорь нь дангаараа төмс, хүнсний ногоо, махны мөн холимог байдлаар төмс, хүнсний ногооных гэсэн хэлбэрээр байж болно.

Дээр нэр дурдсанаас бусад төрлийн ХАА-н зориулалтын барилга, байгууламж байвал 16-18 дугаар мөрөнд нөхөж бичнэ.

## VIII. ХУДАГ, УСАН САН

**81. Танайх өөрийн эзэмшлийн худаг, усан сантай юу?** Тухайн өрх өөрийн эзэмшил худаг, усан сантай эсэхийг асууж, хариултыг нөхнө.

Тухайн өрх өөрийн эзэмшил худаг, усан сантай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Өөрийн эзэмшил худаг, усан сангүй бол Үгүй - 2-ыг дугуйлж, **Бүлэг IX руу** шилжинэ.

**82. Худаг, усан сангийнхаа талаарх мэдээллийг хэлнэ үү.** Тухайн өрхийн эзэмшилд байгаа худаг, усан сангийн тоо, усан сангийн багтаамжийг байршил, ашиглалтын хэлбэрээр асууж, нөхнө.

Худаг, усалалтын системийг анх барьж байгуулахад гүйцэтгэсэн үйл ажиллагаагаар нь өрөмдмөл(гүний), богино яндант болон энгийн гэж ялгана.

**Өрөмдмөл худаг, (гүний)** - Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор өрөмдөж, ханыг нь бэхэлж байгуулсан, босоо цооногийн уст үед байрлуулсан, ус шүүж оруулах яндан шүүртэй, дотор талдаа усны шахуурга, ус дамжуулах хоолойтой инженерийн байгууламжийг хэлнэ.Өөрөөр хэлбэл харьцангуй голч /150, 200, 250, 300, 350, 400 мм /-той, 30 метрээс доош гүнтэй цооног бүхий цахилгаан буюу дизель хөдөлгүүртэй ус өргүүртэй худгийг өрөмдмөл худаг гэнэ.

**Богино яндант худаг** - Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор том голчоор өрөмдөж ханыг нь 1м голч урттай бетон цагиргийг давхарлан 3м гүнд суулгасан, түүнээс доош 30м хүртэл гүнд бага голчтой цооног өрөмдөж төхөөрөмжилсэн өрөмдмөл худгийн зохион байгуулалттай ижил инженерийн байгууламжийг хэлнэ.Өөрөөр хэлбэл харьцангуй бага голч /150, 200, 250 мм /-той, 30 метр хүртэл гүнтэй цооног бүхий худгийг богино яндант худаг гэнэ.

**Энгийн уурхайн /гар худаг/** - Хөрс, геологийн тогтолцоог ажиглаж судалсны үндсэн дээр хөрсний өнгөн хэсэгт ус байх магадлал бүхий газарт 8м хүртэл гүн ухаж гаргасан цооногийн ханыг мод, чулуу зэрэг материалаар хашиж бэхэлсэн худгийг хэлнэ.

**Усан сан** гэж улс, орон нутгийн хүчээр баригдсан 4 ба түүнээс дээш куб м багтаамжтай мал услах талбай, онгоцтой усалгааны цэгийг хэлнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нийт худгийн тооноос бэлчээрт байршдаг болон ашигладаггүй худгийн тоо нь сугарч харагдах бөгөөд дүнд барихгүй.(багана1>=багана3), (багана1>=багана4)
- Өрөмдлөгийн, богино, яндант, энгийн уурхайн, бусад төрлийн худгийн дүнгийн нийлбэр нь худгийн бүгд дүнтэй тэнцүү байна.(мөр1=мөр2:мөр5)

## **IX. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭ**

**83. Танайх эрсдлээс хамгаалах зориулалттай дараах төрлийн даатгалд үйлчилгээнд хамрагдсан уу?** Тухайн өрхийг эрсдлээс хамгаалах даатгалын үйлчилгээнд хамрагдсан эсэхийг асууж нөхнө. Эрсдлээс хамгаалах даатгалд үрийн тариалангийн даатгал, арилжааны бусад даатгал зэрэг хамрагдана. Бусад даатгалд дээрх 2 төрлөөс бусад төрлийг даатгал багтана.

**84. Танайх хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар сүүлийн 5 жилд зээл авсан уу.** Тухайн өрхийг ХАА-н зориулалттай зээл авсан эсэхийг асууж, зээл авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, зээл аваагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, **Асуулт 90 руу** шилжинэ.

**ХАА-н зориулалттай зээлд** тухайн өрх нь үйл ажиллагаандаа зориулан авсан зээлийг оруулна. Үүнд, газар тариалан болон мал аж ахуйд ашиглагдах материал, орцыг худалдан авах, фермийн барилга, байгууламж барих болон тоног төхөөрөмж худалдан авахад зориулан авсан зээл хамрагдана.

Харин сууц, байшин барих, гэр бүлийн бусад бизнес, хэрэглээний зардал зэрэгтээ зориулан зээл авсан бол ХАА-н зориулалттай зээлд оруулахгүй. Авсан зээлд сүүлийн 5 жилд буюу 2007 оноос хойш авсан зээлийг хамруулна.

**85. Ямар хугацаагаар хэдэн удаа зээл авсан бэ?** Тухайн өрх нь хэдэн удаа зээл авсныг “Нэг удаа”, “Хоёр удаа”, “Гурав ба түүнээс дээш” гэсэн ангиллаар асууж, авсан зээлийн тоог хүснэгтэд нөхнө.

**86. Танайх зээлээ хаанаас авсан бэ?** Тухайн өрхийг зээлээ ямар эх үүсвэрээс авсныг тодруулан асууж нөхнө. Зээлийн эх үүсвэрийг “Арилжааны банкнаас”, “Банк бус санхүүгийн байгууллагаас”, “Хадгаламж, зээлийн хоршооноос”, “Хувь хүн, иргэдээс”, “Төрийн байгууллагаас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна. Нэгээс дээш сонголтыг хийж болно. Хэрэв тухайн өрх нь арилжааны банкнаас зээл авсан бол **Асуулт 87 руу** шилжинэ. Банкнаас бусад газраас зээл авсан бол **Асуулт 88 руу** шилжинэ.

Төрийн байгууллагаас авсан зээлд Засгийн газрын болон бусад холбогдох яамд, газар, орон нутгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээлийн энд оруулна. Тухайлбал: сум хөгжүүлэх сан, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл орно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**87. Арилжааны банкны нэр код.** Арилжааны банкны нэрийг бичиж, кодыг хүснэгтийн дор хэсэгт байгаа кодоос харж тавина.

Голомт банк	1	ХААН банк	3	Хас банк	5	Бусад банк	7
Капитал банк	2	Хадгаламж банк	4	Худалдаа хөгжлийн банк	6		

**88. Танайх зээл авахдаа хөрөнгө барьцаалсан уу?** Тухайн өрх нь зээл авахдаа хөрөнгө барьцаалсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Хөрөнгө барьцаалсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ, барьцаалаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 90 руу** шилжинэ.

**89. Танайх зээл авахдаа барьцаалсан хөрөнгөө хэлнэ үү.** Тухайн өрхийн авсан зээлийн барьцааг тодруулан асууж нөхнө. Барьцааг мал, газар, машин, тоног төхөөрөмж, бусад гэсэн төрлөөр ангилан асууна. Нэгээс дээш сонголт байж болно.

**90. Танайх ХАА-н салбарын талаар мэдээлэл авдаг эх сурвалжаа хэлнэ үү.** Тухайн өрхийн ХАА-н үйл ажиллагаатайгаа холбоотой, мэдээллийг хүлээн авч байгаа эх сурвалжийг үүнд хамруулна. ХАА-н талаарх мэдээлэлд, цаг агаар, тариалалт, ургац хураалт, ХАА-н шинэлэг арга туршлагауд, машин, тоног төхөөрөмж, зээлийн үйлчилгээ, байгалийн гамшиг, гадаад, дотоод зах зээл, ХАА-н эдийн засгийн байдал зэргийн талаарх ХАА-тай холбоотой бүх төрлийн мэдээлэл орно.

Эх сурвалж нь нэгээс дээш сонголттой байж болно. Мэдээллийг авч байгаа эх сурвалжийг “Радио”, “Телевиз”, “Сонин, сэтгүүл”, “Интернэт”, “Төрийн байгууллага”, “Төрийн бус байгууллага”, “Мэргэжлийн байгууллага”, “Иргэд”, “Гар утас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна.

**91. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ ихэвчлэн борлуулдаг зах зээл танайхаас хэр зайтай вэ?** Тухайн өрхөөс бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл хүртэлх зайг асууж, нөхнө. Зах зээл хүртэлх зайг 1-9 хүртэл км, 10-49 хүртэл км, 50-99 хүртэл км, 100 ба

түүнээс дээш км гэсэн ангиллаар асууна. Зах зээл хүртэлх зайг 3,5 км гэж хариулсан бол 4 км гэж бүхэлд шилжүүлэн “1-9 хүртэл км” гэсэн ангилалд оруулна.

## **Х. ХҮНСНИЙ ХАНГАМЖ**

**Өрхийн хүнсний хангамжийн байдал** нь өрхийн бүх гишүүд бүх цаг үед идэвхтэй, эрүүл амьдрах үүднээс аюулгүй бөгөөд тэжээллэг хоол хүнс хэрэглэх нөхцөл байдлыг харуулна. Хэрвээ өрх хангалттай хэмжээний хоол хүнс авах санхүүгийн боломжгүй, эсвэл худалдан авч чадах ч хоол хүнс нь хангалттай хэмжээний биш байсан бол үүнийг өрхийн хүнс эрсдэлтэй/найдваргүй гэж үзэх ба үүнээс болж найдвартай, тэжээллэг хангалттай хэмжээний хоол хүнс хэрэглэж чадахгүй болно.

**92. Танай өрхийн гишүүд тогмтол хэрэглэдэг хүнсээ 2011 онд хэрэглэх боломжгүй, дутагдах тохиолдол гарсан уу?** Тухайн өрх нь хэрэглэдэг хүнсээ 2011 онд хэрэглэх боломжгүй тохиолдол гарсан гэж хариулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, тохиолдол гараагүй гэж хариулсан бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, **асуулт 97 руу шилжинэ.**

Энэ үзүүлэлт нь тайлант хугацааны аль ч үед өрхийн хүнсний байнгын хэрэглээгээ хангаж чадаагүй нөхцөл байдлыг хэлэх бөгөөд энэ нь хоол хүнс тасалдах, хоол хүнсний хэмжээ буурах эсвэл хямдхан хоол хүнс болон тэжээллэг муутай хүнс хэрэглэсэн зэргээс үүсэлтэй.

**93. Хүнсний (тогтмол хэрэглэдэг) дутагдалд орсон сарыг дугуйлна уу.** Тухайн өрх нь хэрэглэдэг хүнсийг хэвийн хэмжээнд хэрэглэж чадахгүй тохиолдолд орж байсан бол аль саруудад уг тохиолдол гарсныг тодруулан асууж бүртгэнэ. Энэ мэдээлэл нь хүнсний хомсдолын улирлын нөлөөллийг үнэлэхэд ашиглагдана. Тухайн өрх нь жилд нэг ба түүнээс олон сараар хүнсний хомсдолд орж болох ба хүнсний хомсдолд орж байсан сарыг сайтар асууж бүртгэнэ.

**94. Танайх хүнсний (тогтмол хэрэглэдэг) дутагдалд орсон шалтгаанаа хэлнэ үү.** Тухайн өрхийн хүнсний дутагдалд орсон шалтгааныг “Мал хорогдсон”, “Малын хулгайд өртсөн”, “Байгалийн гамшигт өртсөн”, “Ургац алдсан”, “Ажлын байр олдоогүй”, “Хөдөлмөрийн чадвар буурсан /өвдөж, гэмтэж бэртэх, хөгжлийн бэрхшээл зэрэг/”, “Орлого буурсан”, “Үнэ нэмэгдсэн”, “Олдоц багассан”, “Бусад” гэсэн ангиллаар ялган асууна. Нэгээс дээш сонголт хийж болно.

**95. Хүнсний (тогтмол хэрэглэдэг) дутагдалд орсон үед хүнсний хэрэглээндээ гарсан өөрчлөлтийг хэлнэ үү.** Тухайн өрхийн хүнсний (тогтмол хэрэглэдэг) дутагдалд орсноос хүнсний хэрэглээнд орсон өөрчлөлтийг “Бусдаас хоол хүнс авч хэрэглэсэн”, “Хямдхан хоол, хүнс хэрэглэсэн”, “Хоол хүнсний хэмжээгээ багасгасан”, “Бусад ” гэсэн ангиллаар асууж бүртгэнэ. Нэгээс дээш сонголт хийж болно.

**96. Дээрх хүндрэлээс гарахын тулд ямар арга хэмжээ авсан бэ?** Тухайн өрхийн хүнсний (тогтмол хэрэглэдэг) дутагдлаас гарахын тулд ямар арга хэмжээ авсаныг “Мөнгөн хуримтлалаасаа хэрэглэсэн”, “Зээл авсан”, “Мал, газар, хөрөнгөө худалдсан”, “Гэр бүлийн бизнесээ өргөжүүлсэн”, “Гэр бүлийн бизнес эхлүүлсэн”, “Бусдаас тусламж, дэмжлэг авсан”, “Төрийн байгууллагаас тусламж, дэмжлэг авсан”, “Төрийн бус байгууллагаас тусламж, дэмжлэг авсан”, “Бусад” гэсэн ангиллын дагуу асууж, асуулгад нөхнө. Бусад гэдэгт дээр дурдсан ангилалд ороогүй арга хэмжээг хамруулна. Нэгээс дээш сонголт байж болно.

**97. Танай өрх 2011 онд байгалийн бэрхшээлд өртсөн үү?** Тухайн өрхийн 2011 онд байгалийн бэрхшээлд өртсөн эсэхийг тодруулан асууж бүртгэнэ. Тухайн өрх байгалийн бэрхшээлд өртөж байсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын

дагуу үргэлжлүүлнэ, тохиолдол гараагүй гэж хариулсан бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 100 руу** шилжинэ.

**98. Байгалийн бэрхшээлийн төрлийг нэрлэнэ үү.** Тухайн өрхийн өртсөн байгалийн бэрхшээлийн төрлийг асууж, бүртгэнэ. Байгалийн бэрхшээлийг “Ган”, “Зуд”, “Үер”, “Хүчтэй салхи, шуурга”, “Аянга”, “Хяруу цохисон”, “Бусад” гэсэн ангиллаар ялган, бүртгэнэ. Нэгээс дээш сонголт байж болно.

**99. Байгалийн бэрхшээлийн улмаас ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлд учирсан хохирлын түвшинг хэлнэ үү.** Байгалийн бэрхшээлийн улмаас тухайн өрхөд учирсан хохирлыг “Хохиролгүй”, “Бага зэргийн хохиролтой”, “Дунд зэргийн хохиролтой”, “Их хэмжээний хохиролтой” гэсэн ангиллаар асууж, ярилцан бүртгэнэ. Хохирлын түвшинг тооцоходоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг хэвийн байсан жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулан гаргана. Хэрэв үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь хэвийн жилийнхтэй ижил түвшинд байвал **хохиролгүй**, 20 хүртэлх хувийг алдсан байвал **бага зэргийн хохиролтой**, 20-40 хувийг алдсан байвал **дунд зэргийн хохиролтой**, 40-өөс дээш хувийг алдсан байвал **их хэмжээний хохиролтой** гэж үзнэ.

**100. Танай өрх дараах нэрийн хүнсний бүтээгдэхүүнээс ямар бүтээгдэхүүнийг ихэвчлэн хэрэглэдэг вэ?** Тухайн өрхийн хүнсний хэрэглээндээ ихэвчлэн хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг сонгон тэмдэглэнэ. Эдгээр 13 нэрийн бүтээгдэхүүн нь монгол хүн эрүүл аж төрөхийн тулд хоногт шаардагдах илчлэг, тэжээлийг хангахад зайлшгүй чухал шаардлагатай гол нэр төрлийн бүтээгдэхүүн юм.

#### Хүнсний бүтээгдэхүүний ангилал

Бүтээгдэхүүний бүлэг	Хамрах бүтээгдэхүүн
1.Мах, махан бүтээгдэхүүн	Таван хошуу мал, гэрийн тэжээвэр амьтад, зэрлэг ан амьтдын мах, хиам, гэдэс, дотор, толгой шийр, нөөшилсөн мах, борц
2.Сүү	Шингэн, хуурай сүү, өтгөрүүлсэн сүү, ээдэм, айраг, бяслаг, эээгий, зөөхий, цагаан өрөм
3.Тараг, аарц	Тараг, аарц, ааруул
4. Гурил	Бүх төрлийн гурил
5. Гурилан бүтээгдэхүүн	Талх, боов, боорцог, гоймон
6. Төрөл бүрийн будаа	Бүх төрлийн будаа
7.Саахар, чихрийн зүйл	Элсэн чихэр, ёотон, зөөлөн, хатуу чихэр, шоколад
8. Төмс	Төмс, пүнтүүз
9.Хүнсний ногоо	Байцаа, манжин, лууван, сонгино, улаан лооль, сармис, өргөст хэмх, тарвас, гуатан зэрэг бүх төрлийн ногоо, нөөшилсөн ногоо
10.Буурцагт ургамал	Вандуй, шош
11. Жимс, жимсгэнэ	Чацаргана, үхрийн нүд, хад зэрэг байгалийн зэрлэг жимс, алим, усан үзэм зэрэг бүр төрлийн шинэ жимс, хатаасан  жимс, нөөшилсөн жимс, сок
12. Өндөг	Шинэ өндөг, хуурай өндөг
13.Ургамлын тос	Ургамлын тос

## ХИ. ОЙ, АН АГНУУР, ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ХИ.1 ОЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**101. Танайх 2011 онд мод бэлтгэсэн үү?** Тухайн өрхөөс 2011 онд мод бэлтгэсэн эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх мод бэлтгэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод бэлтгээгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 104 руу** шилжинэ.

**102. Танайх ямар зориулалтаар мод бэлтгэсэн бэ?** Тухайн өрхөөс 2011 онд модыг ямар зориулалтаар бэлтгэснийг асууж, бүртгэнэ. Зориулалтыг дараахь ангиллаар бүртгэнэ. Үүнд:

**Түлээний** - Иргэн өөрийн ахуйн хэрэгцээнд зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу түлээ бэлдэх үйл ажиллагаа

**Хэрэглээний** - сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хэрэглээний мод бэлтгэх үйл ажиллагаа

**Ойн арчилгаа, цэвэрлэгээний** - Ойг хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлүүдээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацанд нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, үйл ажиллагааг хэлнэ.

**103. Бэлтгэсэн модны хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд бэлтгэсэн модны хэмжээг асууж, хариултыг м3-ээр нөхнө.

**104. Танайх мод, сөөгний үр бэлтгэсэн үү?** Тухайн өрхөөс мод, сөөгний үр бэлтгэсэн эсэхийг асууж нөхнө. Мод, сөөгний үр бэлтгээгүй гэвэл Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 106 руу** шилжинэ

**105. Бэлтгэсэн мод, сөөгний нэр, үрийн хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн бэлтгэсэн мод, сөөгний үрийг нэр төрлөөр, хэмжээг нь асууж нөхнө. Үрийн хэмжээг кг-аар нөхнө.

**106. Танайх мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжтэй юу?** Тухайн өрхийг мод үржүүлгийн болон тарьц, суулгацын хүлэмжтэй эсэхийг асууж мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжтэй гэвэл Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжгүй гэвэл Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 108 руу** шилжинэ.

**Тарьц**- Үрслүүлэх зорилгоор модны мөчрөөс тусгайлан авсан хэсэг эсвэл модны үрээр 3 хүртэл жил хөрсөнд суулгаж үрслүүлснийг тарьц гэнэ.

**Суулгац**- 3-аас дээш жил хөрсөнд суулгаж, үндэслүүлэн тарихад бэлэн болгосон тарьцыг суулгац гэнэ.

**107. Мод үржүүлгийн тарьц, суулгацын талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн өрхөөс хүлэмжинд суулгасан модны нэр, тарьц, суулгацны тоог асууж, нөхнө.

**108. Танайх 2011 онд мод тарьсан уу?** Тухайн өрх 2011 онд мод тарьсан эсэхийг асууж нөхнө. Мод тарьсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод тариагүй гэвэл гэвэл Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 110 руу** шилжинэ.

**109. Тарьсан мод, суулгацны тоог хэлнэ үү.** Тухайн өрхөөс тарьсан модны тоог асууж нөхнө.

**110. Танайх 2011 онд ойгоос дагалт баялаг ашигласан уу?** Тухайн өрхөөс 2011 онд ойгоос дагалт баялаг ашигласан эсэхийг асууж, нөхнө. Тухайн өрх дагалт баялаг ашигласан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Дагалт баялаг ашиглаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 112 руу** шилжинэ.

**111. 2011 онд ойгоос ашигласан дагалт баялгийн хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд ойгоос бэлтгэсэн самар, жимс, мөөг, эмийн ургамлын хэмжээг асууж,

хариултыг кг-аар тооцож, нөхнө. Нэр дурдагдаагүй бусад баялаг байвал ойгоос ашигласан дагалт бүтээгдэхүүний бусад мөрөнд буюу 6-р мөрөнд кг-аар нөхнө.

**112. Танайх ойн гаралтай бүтээгдэхүүн 2011 онд борлуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тарьсан суулгацаа борлуулсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тарьсан суулгацаа борлуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тарьсан суулгацаа борлуулаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 114 руу** шилжинэ.

**113. Танайх ойн гаралтай бүтээгдэхүүнээс олсон нийт орлогоо хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд бэлтгэсэн мод, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, суулгац борлуулснаас олсон нийт орлогыг асууж, хариултыг мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**114. Бүтээгдэхүүнд бэлтгэхэд зарцуулсан зардлыг хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд мод бэлтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, суулгац тарихад зарцуулсан зардлыг асууж, зардлын төрлөөр буюу сэлбэг хэрэгсэл, түлш, шатахуун, түрээс, тээвэр, цалин, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад гэсэн төрлөөр нь задлан мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Зардлын тус бүрийн дүн нь нийт зардлын дүнтэй тэнцүү байна.(мөр1=мөр2:мөр8)

## **ХI.2 АН АГНУУРЫН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**115. Танайх 2011 онд ан агнасан уу?** Тухайн өрхөөс 2011 онд ан агнасан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх ан агнасан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Ан агнуур хийгээгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг ХI.3 руу** шилжинэ.

**116. Танайх ямар зориулалтаар ан хийсэн бэ?** Тухайн өрхөөс ямар зориулалтаар ан хийсэн эсэхийг асууж, хариултыг нөхнө. Нэгээс дээш сонголт байж болно.

**Ахуйн** - тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан ан агнахаар зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад төрлийн ан амьтныг агнасан бол ахуйн зориулалттай агнасан ан агнуурт хамрагдана.

**Үйлдвэрлэлийн** - тухайн өрх нь үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар зохих зөвшөөрлийн дагуу төлбөрийг төлж, ховор төрлийн амьтнаас бусад төрлийн ан амьтанг агнасан бол үйлдвэрлэлийн зориулалттай гэдэгт хамруулна.

**Тусгай** - судалгаа, шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар, гадаадын болон Монгол Улсын иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр, сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор, спорт-агнуурын чиглэлээр хийсэн анг хамруулна.

**117. 2011 онд агнасан ангийн тоогоо хэлнэ үү.** Тухайн өрхийн 2011 онд агнасан ангийн тоо хэмжээ, төрлөөр асууж, нөхнө.

- Төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр14)

**118. Танайх агнасан ангаа зарж борлуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд агнасан ан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх агнасан ан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Борлуулаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 120 руу** шилжинэ.

**119. Нийт орлогын дүнгээ хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд агнасан ан болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт борлуулалтын орлогыг асууж, мянган төгрөгөөр илэрхийлэн нөхнө.

**120. Ан агнахтай холбогдон гарсан зардлаа хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд ан агнах, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нийт хэдий хэмжээний зардал гарсныг ангийн сэлбэг, хэрэгсэл, сумны зардал, түлш, шатахуун, түрээс, тээвэр, цалин, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад гэсэн төрлөөр нь задалж, мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Зардал тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт зардлын дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр9)

### **ХІ.3 ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**121. Танай өрх 2011 онд загас барьсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд загас барьсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх загас барьсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Загас бариагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан асуулгыг дуусгана.

**122. Танайх ямар зориулалтаар загас барьсан бэ?** Тухайн өрхөөс ямар зориулалтаар загас барьсан эсэхийг асууж, бүртгэнэ.

**Ахуйн** - тухайн өрх нь өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан загас барихаар зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу ховор загаснаас бусад загасыг барьсан бол ахуйн зориулалттайд багтана.

**Үйлдвэрлэлийн** - тухайн өрх нь үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар (загас загасан бүтээгдэхүүн болон тос, консерв, махан таташ гэх мэт) зохих зөвшөөрлийн дагуу төлбөрийг төлж, ховор загаснаас бусад төрлийн загас барьсан бол үйлдвэрлэлийн зориулалттай гэдэгт хамруулна.

**Тусгай** - загасыг судалгаа шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар, гадаадын болон Монгол Улсын иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр, нутаг дэвсгэрт сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор, спорт-агнуурын чиглэлээр барьсан загасыг хамруулна. Загас барих зорилгоор загасчин хүлээн авсан тохиолдолд тусгай зориулалтад орно. Нэгээс дээш сонголт байж болно.

**123. Барьсан загасны хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн 2011 онд барьсан загасны хэмжээг асууж, кг-д шилжүүлэн тооцож, нөхнө.

**124. Танайх барьсан загас болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан уу?** Тухайн өрхөөс 2011 онд загас барьсан болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Тухайн өрх барьсан загас болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Борлуулаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 126 руу** шилжинэ.

**125. Танайх барьсан загас, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс олсон орлогоо хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд загас барьсан болон түүнээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулж олсон нийт орлогыг асууж, хариултыг мянган төгрөгөөр тооцож нөхнө.

**126. Загас барих, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлаа хэлнэ үү.** Тухайн өрхөөс 2011 онд загас барих болон бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нийт хэдий хэмжээний зардал гарсан болон загасны өгөөш, түлш, шатахуун, түрээс, тээвэр, цалин, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад зардалд хэдий хэмжээний төгрөг зарцуулсныг асууж, мянган төгрөгөөр тооцож нөхнө. Зардал тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт дүнтэй тэнцүү байна.

## **БҮЛЭГ VI. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР**

Газар тариалангийн тооллогод газар тариалангийн үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулах бөгөөд асуулга нь газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын асуулга (ХААТ 2Б) байна.

Асуулга нь ерөнхий болон үндсэн бүлгээс бүрдэх бөгөөд асуулга нь 12 бүлэг асуултаас бүрдэнэ. Үүнд:

- I. Ерөнхий мэдээлэл
- II. Ажиллах хүч
- III. Эзэмшил газар, түүний ашиглалт
- IV. Газар тариалангийн үйл ажиллагаа
- V. ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт
- VI. Газар, машин, тоног төхөөрөмж
- VII. ХАА-н зориулалттай барилга, байгууламж
- VIII. Худаг, усан сан
- X. ХАА-н үйлдвэрлэлд үзүүлэх зарим үйлчилгээ

### **I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

#### **I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ**

Газар тариалан эрхэлдэг нэгжийн хаягийн хэсэг нь тухайн нэгжийг засаг захиргааны аль нэгж эсвэл газар тариалангийн ямар бүсэд байгааг илэрхийлэхээс гадна газар тариалангийн тооллогын үр дүнг нэгтгэх үндсэн үндсэн чухал хэсэг болно. Мөн хаягийн хэсэг нь газарзүйн мэдээллийн системээр тооллогын үр дүнгийн тайланг гаргах болон мэдээллийг бусад эх үүсвэртэй холбоход ашиглагдах юм.

“Газар тариалан эрхэлдэг нэгж” гэдэгт газар тариаланг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй эрхэлдэг болон газар тариалангийн үйлдвэрлэл тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх, ААНБ-ыг хамруулна.

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дугаарыг бичнэ. Тооллогын комиссын дугаарыг хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харна. Уг дугаар нь ХАА-н ам орон, сууцны тооллогод ашигласан дугаартай ижил байна.

**2. Аймаг, нийслэлийн нэр, код.** Энэ асуултад тухайн аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**3. Сум, дүүргийн нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**4. Баг, хорооны нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**5. Тоологчийн нэр, дугаар.** Тоологч өөрийн нэрийг эцэг/ эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг нөхнө. Тоологч

дугаараа нөхөхдөө: **Тоологчийн нэр, дугаар** гэсэн мөрийн 2 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрвээ 1 оронтой дугаар бол “01” гэх мэтчилэн өмнөх оронг “0” тавьж гүйцээнэ. Тоологчийн дугаарыг өгөхдөө сум, дүүрэг дотроо 01-ээс эхлэн дугаарлана. **Жишээ нь:** тухайн сум, дүүрэгт 5 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-05 хүртэлх дугаар өгнө, 2 дугаар сум, дүүрэгт 10 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-10 хүртэлх дугаар өгнө.

**6. Тооллогын асуулгын дугаар.** Тооллогын асуулгын дугаарыг тоологч бүр тоолж эхэлсэн эхний өрхөөс эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Хэрэв тухайн тоологч 2 багт ажиллах бол асуулгын хуудсыг баг тус бүрд 1-ээс эхлэн дугаарлана.

Тоологч тооллогын асуулгын дугаарыг давхардуулан олгож болохгүй.

**7. Шалгагч, кодлогчийн нэр, код:** Сумын түвшинд тоологчоос тооллогын материалыг багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч шалган хүлээж авна. Аймгийн түвшинд аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд сумдын тооллогын материалыг хүлээн авч, шалгах, кодлох ажлыг хийнэ.

Шалгагч, кодлогч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 1 оронтой дугаар бол “01” гэх ба өмнөх оронг “0” тавьж гүйцээж бичнэ. Шалгагч асуулгын хуудсыг үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон алхамыг зөв хийсэн эсэхийг хянаж, алдааг засварлана. Кодлохдоо аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, тоологч, шалгагч, гудамж, хороолол, бүсчлэл, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн зэрэг кодлолтыг хавсралтыг ашиглаж нөхнө.

**8. Шивэгчийн нэр, дугаар:** Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Шивэлтийг ҮСХ хариуцан хийх учраас шивэгч бүрт тусгайлан код олгоно.

## **I.2 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ**

**9. Аж ахуйн нэгж байгууллагын нэр.** Тухайн аж ахуйн нэгжийн нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө.

**10. Регистрийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн товчлохгүйгээр үнэн зөв нөхнө.

**11. Статистик нэгжийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын статистикийн регистрийн санд бүртгэгдсэн дугаар бөгөөд дугаарыг ҮСХ-ноос хүргүүлсэн жагсаалтаас харж тавина.

## **I.3 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭН/ДАРГА/ЗАХИРЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт тооллогод хамрагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын талаарх мэдээллийг асууж нөхнө. Хэрэв тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эзэн нь өөр хүн байвал тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг удирдаж байгаа захирлынх нь /гүйцэтгэх захирал/ талаарх мэдээллийг авна.

**12. Эцэг (эх)-ийн нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага(эзэн, дарга, захирал)-ын, эцэг (эх)-ийн нэрийг асууж, нөхнө.

**13. Нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын өөрийн нэрийг асууж, нөхнө.

**14. Хүйс.** Энэ асуулт ХАА-н үйлдвэрлэл дэх жендерийн байдлыг судлах ялангуяа, ХАА-н үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийг үнэлэх чухал үзүүлэлт болно. Энэ асуултын хариултыг нөхөхдөө аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, өрхийн тэргүүлэгчийн хүйсийг эрэгтэй гэж 1, эмэгтэй -2 гэсний аль тохирох кодыг дугуйлна.

**15. Нас (бүтэн жилээр).** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, өрхийн тэргүүлэгчийн насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь тооллого явагдаж байгаа жилээр гүйцэд тооцож тогтооно.

**16. Боловсролын түвшин.** Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшинг асууж, боловсролын түвшинд тохирох кодыг сонгон дугуйлна.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол**- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/-** Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**17. Ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын ажилласан жилд тухайн хүний хөдөлмөр эрхэлж эхэлсэн үеэс судалгаа авч байгаа үе /2011 он/ хүртэлх хугацааг оруулна. Дээрх хугацаанд хөдөлмөр эрхлээгүй үе

гарвал тус хугацааг ажилласан жилд оруулахгүй. Ажилласан нийт жилийг бүтэн жилээр тавина.

Үүнээс: Газар тариалангийн салбарт. Нийт ажилласан хугацаанаас хичнээн жилийг нь газар тариалангийн салбарт ажилласныг асууж, бичнэ.

Зөвхөн тус салбарт ажилд орсон цагаасаа ажиллаж ирсэн бол ажилласан жил нь “Газар тариалангийн салбарт ажилласан жил”-тэй тэнцүү байна.

**18. Тухайн байгууллагын удирдлагаар ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын тухайн нэгждээ удирдлагаар ажилласан нийт жилийг асууж нөхнө.

**19. Тухайн байгууллагыг үүсгэн байгуулагчдын тоо.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн байгуулагчдын тоог асууж нөхнө.

#### **I.4 АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**20. Танайх 2011 онд газар тариалангаас бусад ямар чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг асууж нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

Бусад үйл ажиллагааны чиглэлийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн, эсвэл борлуулалтын өндөр орлоготой нэгжийн үйлдвэрлэлээс бага руу нь дараалуулах аргаар тодорхойлно. Тухайлбал: Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь газар тариалангаас гадна мал аж ахуй, худалдааны үйл ажиллагаа давхар эрхэлдэг бол худалдаа эрхэлснээс олсон орлого нь мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогоос их байвал эхлээд худалдаа, дараа нь мал аж ахуй гэж дараалуулан бичнэ.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC-4.0) хувилбарын дагуу номноос (кодлогч) нөхнө.

## **II. АЖИЛЛАХ ХҮЧ**

**21. Танайх 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас 2011 онд хүн хөлсөлж ажиллуулсан эсэхийг асууж нөхнө.

**22. Танайх байнгын ажиллагчидтай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас байнгын ажиллагчидтай эсэхийг асууж, байнгын ажиллагчидтай гэж хариулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ажиллагчидгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 29** рүү шилжинэ.

**23. Байнгын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Байнгын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**Байнгын ажиллагчид** гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хэлнэ (“Хөдөлмөрийн тухай” хуулийн 3.1.15.).

Ажиллагчдын тоонд өрхийн тэргүүлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, захирал орно. Мөн өрхийн гишүүд аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байвал ажиллагчдын тоонд оруулна. Харин ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй.

**24. Байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь баримжаалан хэлснээр тариалалт, ургац хураалтын үеэр асууж нөхнө. Тариалалтын үед 5-6 сар, ургац хураалтын үед 9-11 сар багтана.

**25. Байнгын ажиллагчдын тоо насны бүлэг, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын тоог хүснэгтэд заасан насны ангиллаар, хүйсээр задлан асууж нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр8)
- Насаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь насаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1)>=багана2

**26. Байнгын ажиллагчдын тоо, гэрлэлтийн байдал, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас байнгын ажиллагчдын тоог гэрлэлтийн байдлаар 4 ангилалд хуваан асууж бүртгэнэ.

**Гэрлэсэн/хамт амьдардаг** – Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг энд хамруулна. Мөн гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч /хугацаа харгалзахгүйгээр/ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хамруулна.

**Огт гэрлэж байгаагүй** – Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

**Тусгаарласан/цуцалсан** – Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүмүүсийг “тусгаарласан” гэнэ. Тусдаа амьдардаг гэдэгт амьжиргааны болон бусад нөхцөлөөр тусдаа амьдардаг /жишээлбэл: эхнэр, нөхрийн аль нэг нь гадаадад амьдардаг, хүүхдүүдээ сургуульд суулгахын тулд сумын төвд хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг гэх мэт/ тохиолдлуудыг оруулахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлээгүй хүмүүсийг “цуцалсан” гэнэ.

**Бэлбэсэн** – Эхнэр юмуу нөхөр нь нас барснаас хойш дахин гэрлээгүй бол “бэлбэсэн” гэж үзнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нас тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)
- Гэрлэлтийн байдлаар задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь гэрлэлтийн байдлаар задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1)>=багана2)

**27. Байнгын ажиллагчдын тоо, боловсролын түвшин, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын тоог боловсролын түвшингээр асууж бүртгэнэ. Боловсролын түвшинг ойлголт, тодорхойлолтын дагуу харж нөхнө.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол** - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/** - Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Боловсролын түвшингээр задалсан дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр10)
- Боловсролын түвшингээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь боловсролын түвшингээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна. (багана1>=багана2)

**28. Байнгын ажиллагчдаас мэргэжлийн ажиллагчдын тоо, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын мэргэжлийн ажиллагчдын тоог хүснэгтэд өгөгдсөн ангиллаар асууж, бүртгэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Мэргэжлийн ажиллагч тус бүрийн дүнгийн нийлбэр нь бүгд дүнтэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр5)
- Мэргэжлээр задалсан эмэгтэй байнгын ажиллагчдын тоо нь мэргэжлээр задалсан бүгд дүнгээс бага буюу тэнцүү байна.  
(багана1>=багана2)

**29. Танайх улирлын ажиллагчидтай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага улирлын ажиллагчидтай эсэхийг асууж, улирлын ажиллагчидтай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ажиллагчидгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 32 руу** шилжинэ.

**Улирлын ажиллагчид** улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хамруулна.

**30. Улирлын ажиллагчдыг тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын улирлын ажиллагчдын тоог асууж нөхнө.

**31. Улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын улирлын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр, тариалалт, ургац хураалтыг үеэр, асууж нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**32. Танайх түр ажиллагчид 2011 онд авч ажиллуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь 2011 онд түр ажиллагч авч ажиллуулсан эсэхийг асууж, бүртгэнэ. Хэрэв түр ажиллагч авч ажиллуулсан бол Тийм-1"-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, хөлслөөгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 35 руу** шилжинэ.

**Түр ажиллагчид** хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг хамруулна.

**33. Түр ажилласан ажиллагчдын тоог хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын түр ажиллагчдын тоог асууж нөхнө.

**34. Түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг цагаар хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацааг хариулагчийн өөрийнх нь хэлснээр, тариалалт, ургац хураалтын үеэр асууж нөхнө. Ажлын өдрийн үргэлжлэх хугацааг цагаар илэрхийлнэ.

**35. Танайд ажиллах хүчтэй холбоотой дараах хүндрэл, бэрхшээл тулгарч байна уу?** Энэ асуулт нь ажиллах хүчинтэй холбогдолтойгоор үүссэн хүндрэлийг тодорхойлох зорилготой.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хувьд гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг хүснэгтэд тавигдсан ангиллаар асууж нөхнө. Хэрэв дурдсан хүндрэл, бэрхшээл тулгардаггүй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, тулгардаг бол Үгүй гэж 2-ийг дугуйлна. Бусдад хүснэгтэд дурдснаас өөр бусад хүндрэл, бэрхшээлийг оруулна.

### III. ГАЗАР, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ

#### III.1 ГАЗРЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**Газар ашиглах** гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчийн хооронд байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж ашиглахыг хэлнэ.

Тухайн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмшлийн байдлыг нь газрын нийт талбай, ХАА-н эдэлбэр газар гэсэн хоёр хэлбэрээр, хүснэгтэд заагдсан ангиллын дагуу асууж нөхнө.

**36. Та аж ахуйн нэгж, байгууллагынхаа газар ашиглалтын талаар дараах мэдээллийг хэлнэ үү.**

**Өөрийн эзэмшилд байгаа газар.** Өөрийн эзэмшилд байгаа газрын нийт хэмжээ нь газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийн эзэмшдэг нийт газрын хэмжээ юм. Эзэмшилд байгаа газарт дараах төрлийн газрыг хамруулна. Үүнд:

- ХАА-н газар, нэг наст болон, олон наст ургамал тариалдаг газар, хадлан, бэлчээрийн талбай болон уриншийн талбай;
- Цэцэрлэг, ногооны талбай;
- Ой, модот бусад газар;
- Эзэмшлийн худаг, ус эсвэл тухайн нэгжийн хэрэглээг үл харгалзан тухайн аж ахуйн хяналтанд байдаг худаг, усны талбай;
- Фермийн бусад газар болон фермийн барилга, байгууламж байрладаг газар;

Дараах онцлог тохиолдол байвал сайтар нягталж үзээд доор дурьдсаны дагуу ангилна. Үүнд:

- Хэрвээ өрх ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг бол түүний эзэмшилд байдаг газарт тухайн өрхийн гэр, байшин байрладаг газар мөн орно
- Тооллогын жилд газар тариалангийн боловсруулалт хийгдсэн байгаа газар болон тариалалтанд бэлдэж боловсруулалт хийгдсэн боловч тооллогын үед тариалалт хийгээгүй газрыг эзэмшилд байгаа газрын хэмжээнд оруулна. Тооллогын өмнөх жилд ашиглахгүй орхисон газрыг харин оруулахгүй.
- Нийтийн эзэмшлийн бэлчээрийн талбай зэрэг бэлчээрийн газрыг тухайн нэгжийн эзэмшлийн газар гэж үзэхгүй. Тухайн нэгж тухайн нийтийн эзэмшлийн талбайд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тухайн нэгжид тусгайлан хашаагаар хүрээлүүлэн ногдуулсанаас бусад газрыг тухайн нэгжийн эзэмшлийн газарт хамааруулахгүй.
- Эзэмшлийн худаг, ус эсвэл тухайн аж ахуйн хяналтанд байдаг худаг, усыг нэгжийн эзэмшил газрын хэмжээнд оруулах боловч харин ХАА-н биш зорилгоор ашиглахаар бусдаас түрээсэлдэг худаг, усны талбай эзэмшил бүхий газрын хэмжээнд нь хамруулахгүй.

**36.1 Бусдад түрээслүүлсэн болон ашиглуулж буй газарт** тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь бусад аж ахуйн нэгж, иргэнд түрээслүүлж эсвэл ашиглуулж байгаа газрыг

оруулна. Түрээслүүлсэн газрыг иргэдэд, аж ахуйн нэгж, байгууллагад гэсэн хоёр төрлөөр асууж нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Бусдад түрээслүүлсэн болон ашиглуулж буй газрын хэмжээ нь иргэд, аж ахуйн нэгжид түрээслүүлсэн газрын хэмжээний нийлбэртэй тэнцүү байна. ( $мөр2=мөр3+мөр4$ )

**36.5 Бусдаас түрээсэлсэн газарт** тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь газар тариалангийн болон бусад зорилгоор ашиглахаар бусдаас түрээсэлсэн газрын хэмжээг оруулна. Бусдаас түрээсэлсэн газрыг иргэдээс, төрийн болон орон нутгийн өмчит газраас, аж ахуйн нэгж, байгууллагаас гэсэн төрлөөр асууж бүртгэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Бусдаас түрээсэлсэн газрын хэмжээ нь иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон орон нутгийн өмчийн газраас түрээсэлсэн газрын хэмжээний нийлбэртэй тэнцүү байна. ( $мөр5=мөр6:мөр8$ )

**36.9 Өөрийн эзэмшилд ашиглаж буй газрын хэмжээ.** Өөрийн эзэмшлийн газраас түрээслүүлсэн болон ашиглуулж буй газрын хэмжээг хассантай тэнцүү байна.

**Хийгдэх балансын шалгалт:**

- ( $Мөр9=мөр1-мөр2$ )

**36.10 ХАА-н эдэлбэр газар.** ХАА-н эдэлбэр газар нь бэлчээр, хадлан, тариалангийн талбай, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн доорх дэвсгэр газар, ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газрын нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

ХАА-н эдэлбэр газрыг газар ашиглалтын хэлбэрээр дараах ангиллаар задлаж, бүртгэнэ.Үүнд:

**36.11 Тариалангийн талбай буюу эргэлтийн талбай.** Тариалсан талбай, уриншилсан талбай, өнжөөсөн талбайг тариалангийн талбай гэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Тариалангийн талбай нь тариалсан талбай, уриншилсан талбай, өнжөөсөн талбайн нийлбэртэй тэнцүү байна. ( $Мөр11=мөр12:мөр14$ )

**36.12 Тариалсан талбай.** Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаахөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Тариалсан газарт хүний үйл ажиллагаагаар тарьж ургуулсан ургамал бүхий талбайг хамруулна. Дор дурдсан таримал ургамал бүхий талбайг тариалсан газарт хамааруулахгүй.

- байгалийн хадлан, бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор нэг ба олон наст ургамлын үр цацах, услах, бордох зэргээр сайжруулж тордсон бэлчээр, хадлангийн талбай;
- хот, суурингийн дотор тарьж ургуулсан мод болон зүлэгжүүлсэн талбай, хот орчмын ногоон бүс;

- элсний нүүдэл зогсоох зорилгоор тарьсан мод, бут, сөөг.

**36.13 Уриншилсан талбайд** дараа жил ургамал тариалах зорилгоор боловсруулж өнжөөсөн тариалангийн талбайг хамруулна.

**36.14 Өнжөөсөн талбайд** хөрсний үржил шимийг нөхөн сэргээх буюу сайжруулах арга хэмжээ авах болон тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид тариалах үр дутагдах, тухайн жилд ган болох магадлал ихтэй нь тогтоогдсон зэрэг хүндэтгэх шалтгааны улмаас 2 жил хүртэл хугацаанд тариалалт болон уринш хийгээгүй тариалангийн талбайг хамруулна.

**36.15 Хадлангийн талбайд** газрын тухай хуулиар газрын нэгдмэл санд бүртгэгдсэн хадлангийн газар болон холбогдох шатны төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрсөн өвс бэлтгэж болох ургац бүхий бэлчээрийн талбайн хэсгийг хамруулна.

**36.16 Бэлчээрийн талбайд** мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт хамааруулсан газар багтана.

**36.17 Атаршсан талбайд** тариалангийн газрын санд бүртгэлтэй боловч хоёроос дээш жил тариалалт, уринш хийгээгүй тариалангийн талбайг хамруулна.

**36.18 Бусад газарт** тухайн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн барилга, байгууламжийн доорх газар буюу ХАА-н барилга, байгууламжийн доорх дэвсгэр газар, хөдөө аж ахуй эрхлэх боломжгүй газрыг оруулна.

ХАА-н эдэлбэр газар нь тариалангийн, хадлан, бэлчээрийн, атаршсан болон бусад газрын нийлбэртэй тэнцүү байна.

**Хийгдэх балансын шалгалт:**

- $Мөр10 = мөр11 + (мөр15 : мөр18)$
- Газрын нийт талбайгаас ХАА-н эдэлбэр газар сугалж харуулна. ХАА-н эдэлбэр газрын хэмжээ нь нийт газрын нийт талбайгаас бага буюу тэнцүү байна. (багана1 >= багана2)

**36.19 ХАА-н эдэлбэр газраас ашиглаж буй газар.** Үүнд ХАА-н эдэлбэр газраас зориулалтын үйл ажиллагаанд ашиглаж буй газрыг салгаж бүртгэнэ.

**36.20 Нийт газраас усалгаатай талбай.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө.

**Усжуулалт** - бэлчээр, хадлангийн болон газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготойгоор хүний оролцоотойгоор газрыг чийгшүүлэн (борооны усаар биш) устай болгох үйл явцыг хэлнэ.

**36.21 2011 онд усалсан талбай.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ХАА-н зориулалтаар ашиглах зорилгоор 2011 онд усалсан талбайг, га-гаар асууж нөхнө.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Усалсан талбай нь усалгаатай талбайгаас бага буюу тэнцүү байна. ( $мөр21 = < мөр20$ )

**37. Танайх талбайгаа хамгаалах зорилгоор мод тарьж ойн зурвас байгуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь хамгаалалтын зорилгоор ойн зурвас байгуулсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ. Зурвас байгуулаагүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг сонгож, **Асуулт 39 рүү** шилжинэ.

**Ойн зурвас**- мал, амьтан, элс, шорооны нүүдэл, хуурайшил, салхинаас хамгаалах зорилгоор тариалангийн талбайг тойруулан тарьсан мод, бутыг хэлнэ.

**38. Ойн зурвасаар хүрээлэгдсэн нийт талбайн хэмжээг хэлнэ үү.** Тухайн өрхийн ойн зурвасаар хүрээлэгдсэн нийт талбайн хэмжээг асууж, бүртгэнэ. Талбайн хэмжээг га-гаар бүртгэнэ.

**Асуулт 36.5-д** түрээсэлсэн газар нөхөгдөөгүй бол **Асуулт 39-ийг** алгасч, **асуулт 40 рүү** шилжинэ.

**39. Түрээсэлсэн газрын түрээсийн төлбөрийн хэлбэрээ хэлнэ үү.** Тухайн өрхийн бусдаас түрээсэлсэн газрын түрээсийн төлбөрийг дараах 4 төрлөөр асууж бүртгэнэ. Үүнд:

**Мөнгөн төлбөрөөр** - Газрын эзэн болон тухайн газрыг түрээслэн ашиглахерх хоёрын хооронд шууд бэлэн мөнгөөр төлбөр хийгдэхийг хэлнэ.

**Бүтээгдэхүүний тодорхой хувийг өгөхөөр** - Төлбөрт бүтээгдэхүүний тодорхой хувийг өгөхөөр газрын эзэн, газар түрээслэгч харилцан тохирсон байхыг хэлнэ.

**Нэмэлт үйлчилгээг үнэ төлбөргүй нийлүүлэхээр** - газар түрээслэгч нь үйлчилгээ үзүүлнэ хэмээн баталгаа гаргаж газар ашиглахыг хэлнэ.

**Бусад** - үнэгүй түрээс, эсвэл тодорхой зарим нэг ургамал ургуулж өгөх мэтийн тогтсон нөхцлийн дагуу хийх түрээсийг хамруулна.

**Асуулт 36.17-д** атаршсан талбай нөхөгдөөгүй бол **Асуулт 40-ийг** алгасч, **Бүлэг III.2** руу шилжинэ.

**40. Талбайг атаршуулснаас хойших хугацааг хэлнэ үү.** Тариалангийн газрын санд бүртгэлтэй боловч хоёроос дээш жил тариалалт, уринш хийгээгүй тариалангийн талбайг атаршсан газарт хамааруулах бөгөөд тухайн өрхийн талбайд атаршуулалт хийснээс хойш өнгөрсөн хугацааг "Нэг хүртэл жил", "Нэгээс дөрөв хүртэл жил", "Дөрөв ба түүнээс дээш жил" гэсэн ангиллаар бүртгэнэ.

### **III.2 ХӨРСНИЙ ДОРОЙТОЛ**

**Хөрсний доройтол** гэж хүний буруутай үйл ажиллагаа, байгалийн болон бусад зүйлийн нөлөөллөөс хөрсний чанар муудаж, органик бодис алдагдах, хөрсний үржил шим буурахыг хэлнэ. Газрын хөрсний доройтлыг дараах тодорхойлолтын дагуу тайлбарлан, тохирох хариултыг нөхнө. Үүнд:

**Доройтолгүй** - Хөрсний доройтол байхгүй

**Өнгөц** - Газрын үржил шим нь бага зэрэг буурсан бөгөөд нөхөн сэргээлтийг хийх боломжтой бол өнгөц гэж үзнэ.

**Дундаж** - Газрын зарим хэсэг нь нэлээн доройтсон бөгөөд ХАА-д ашиглах боломжийг сэргээхийн тулд тодорхой сайжруулалтыг хийх шаардлагатай бол доройтлыг дундаж гэж үзнэ.

**Ноцтой** - Газрын дийлэнх хэсэг нь дахин сэргэхгүйгээр ихээхэн доройтсон, ХАА-н үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон бол доройтол ноцтой болсон гэж үзнэ. Доройтол ноцтой болсны нэг илрэл нь "Цөлжилт" байж болно.

**41. Тариалангийн талбайн хөрсний доройтлыг тодорхойлно уу.** Тариалангийн талбайн хөрсний доройтлыг "доройтолгүй", " өнгөц", "дундаж", "ноцтой" гэсэн 4 төрлөөр асууж, тохирох хариултыг дугуйлна.

**42. Хадлан, бэлчээрийн талбайн хөрсний доройтлыг тодорхойлно уу.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь хадлан бэлчээрийнх нь талбай нь хөрсний доройтолтой

байгаа эсэхийг “доройтолгүй”, “өнгөц”, “дундаж”, “ноцтой” гэсэн 4 төрлөөр асууж, тохирох хариултыг дугуйлна.

**43. Танайх агрохимийн шинжилгээ хийлгэсэн үү?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь агрохимийн шинжилгээ хийлгэсэн эсэхийг асууж, шинжилгээ хийлгэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ. Хийлгээгүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, усалгаатай тариалангийн хэсэг рүү буюу **Бүлэг III.3 руу** шилжинэ.

Тариалангийн газрын хөрсний чанар, үржил шимт байдлыг агрохимийн шинжилгээгээр тодорхойлно. Агрохимийн шинжилгээг “Монгол улсын газрын тухай хууль”-нд заасанчлан 5 жил тутамд нэг удаа заавал хийлгэх учраас 2007 оноос хойшхи хугацааг хамруулна.

**44. Агрохимийн сүүлийн шинжилгээ хийлгэсэн огноог хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь агрохимийн шинжилгээ хийлгэсэн эсэхийг асууж, шинжилгээ хийлгэсэн гэж хариулсан тохиолдолд хамгийн сүүлд хийлгэсэн огноог асууж, асуулгад нөхнө.

**45. Агрохимийн шинжилгээгээр тариалангийн талбайн доройтол ямар түвшинд байсан бэ?** Хөрсний доройтлыг хамгийн сүүлд хийлгэсэн агрохимийн шинжилгээний дүнгээр, дараах 6 ангиллын дагуу асууж нөхнө. Үүнд: “Хөрсний 0-40 см гүний ялзмаг” “Хөрсний нитратын азот”, “Хөрсний хөдөлгөөнт фосфор”, “Хөрсний хөдөлгөөнт кали”, “Хөрсний бүхэлшил”, “Усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт”,

Хөрсний доройтлын 3 төрлийн бүтцийн өөрчлөлтийн 7 зэрэглэл байдаг. Үүнд:

- I. Ус, хүчтэй бороо, салхи болон бусад хүчин зүйлүүдээс болон хагалбар газрын үе давхарга буурснаас **хөрсний бүтцийн өөрчлөлт** гарахыг “хөрсний 0-40 см гүний ялзмаг” -аар илэрхийлнэ.
- II. Тэжээл болон органик бодис, давслаг, ислэг, шүлтлэгээ алдсанаас болоод хөрсний **химийн чанар буурах буюу бохирдохыг** хөрсний нитратын азот, хөрсний хөдөлгөөнт фосфор, хөрсний хөдөлгөөнт кали” –гаар илэрхийлнэ.
- III. Нягтаршил, давхарга болон хөрсний суулт зэрэг хөрсний **биет доройтлыг** “хөрсний бүхэлшил, усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт” харуулна.

### III.3 УСАЛГААТАЙ ТАЛБАЙ

**46. Танайх усалгаатай тариалан эрхэлдэг үү?** Тухайн аж ахуйн, нэгж, байгууллагаас усалгаатай тариалан эрхэлдэг эсэхийг асууж эрхэлдэг бол Тийм гэж 1-ийг дугуйлж, **Асуулт 48 рүү** шилжинэ. Усалгаатай тариалан эрхэлдэггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, эрхлэхгүй байгаа шалтгааныг асууж нөхнө.

**47. Танайх усалгаатай тариалан эрхлэхгүй байгаа шалтгаанаа хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас усалгаатай тариалан эрхлэхгүй байгаа шалтгааныг “Усны эх үүсвэр дутмаг”, “Санхүүгийн боломж муу”, Ажиллах хүч дутмаг”, “Техник эвдэрсэн”, “ Услах шаардлагагүй”, “Бусад ” гэсэн 5 хэлбэрээр асууж нөхнө. Шалтгааныг асууж нөхсний дараа **Бүлэг IV рүү** шилжинэ.

**48. Танайх усалгаатай талбайнхаа талаарх дараах мэдээллийг хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас усалгаатай талбайг бүгд дүн, талбайн болон ургамлын төрлөөр нь ангилан асууж нөхнө.

Усалгаатай талбайн бүгд дүн нь **Бүлэг 36-ын 20-д тавигдсан дүнтэй** тэнцүү байна.

**Талбайн төрлөөр асуух усалгаатай талбайг** “Нэг наст ургамлын талбай”, “Олон наст ургамлын талбай” гэсэн ангиллаар задлан асууна.

**Нэг наст ургамлын талбай** гэж нэг жил хүртэлх хугацаанд ургац хурааж авах боломжтой ургамалыг тарихад ашигласан газрыг хэлнэ. Талбайдаа нэг жилээс дээш хугацаагаар өнждөг зарим ургамлыг нэг наст ургамалд тооцно.

**Олон наст ургамлын талбай** тодорхой нэг жилд тариалаад, үр жимсээ өгтөл нь дахин тариалалт хийхгүй олон наст ургамлыг тариалсан газрыг хэлнэ. Үүнд жимс, жимсгэний талбай орно. Олон наст хадлангийн бэлчээрийн газар нь уг газарт хамаарагдахгүй.

**Усалгаатай талбай, ургамлын төрлөөр.** Усалсан талбайг дараах ургамлын төрлөөр задалж тодорхойлон нөхнө.Үүнд:

<b>+ <u>Үр тариа</u></b>  - буудай - арвай - овъёос - хөх тариа - бог будаа - бусад	<b>+ <u>Төмс</u></b> <b>+ <u>Хүнсний ногоо</u></b>  <b>+ <u>Тэжээлийн ургамал</u></b> <b>+ <u>Техникийн ургамал</u></b> <b>+ <u>Эмийн ургамал</u></b> <b>+ <u>Хадлангийнх</u></b> <b>+ <u>Жимс, жимсгэнийх</u></b>
--	---

**Хийгдэх балансын шалгалт:**

- Усалгаатай нэг наст болон олон наст ургамлын талбайн нийлбэрнь усалгаатай талбайн бүгд дүнтэй тэнцүү байна.(мөр1=мөр2+мөр3)
- Усалгаатай үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн болон техникийн ургамал, эмийн ургамал, хадлан, жимс, жимсгэний, бусад ургамлын талбайн нийлбэр нь нийт усалгаатай талбайн дүнтэй тэнцүү байна.(мөр1=мөр4+мөр11+мөр18)
- Усалгаатай үр тарианы талбайн хэмжээ нь буудай, арвай, овъёос, хөх тариа, бог будаа, бусад төрлийн үр тарианы усалгаатай талбайтай тэнцүү байна. (мөр4=мөр5:мөр10)

**49. Усжуулалтын системийнхээ төрлөө хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас ашиглаж байгаа усжуулалтын системийн төрлийг “инженерийн хийцтэй”, “энгийн уурхайн”, “бусад” гэсэн ангиллаар задлан асууна.

**Усжуулалтын систем** гэж бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорх усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолборыг хэлнэ. Инженерийн хийцтэй усжуулалтын системд дараах төрлийн худаг, усан санг хамруулна. Үүнд:

**50. Усжуулалтын систем ажиллуулахад төрөөс дэмжлэг авсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас усжуулалтын системийг үйл ажиллагаандаа ашиглахдаа төрөөс дэмжлэг авсан эсэхийг асууж төрөөс дэмжлэг авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дэмжлэг аваагүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг сонгоно.

**51. Танайх ямар аргаар усалгаа хийсэн бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь ямар аргыг ашиглаж усалгаагаа хийснийг “Гадаргуугаар урсгах”, “Бороожуулах”,

“Мананжуулах”, “Дуслын системний аргаар”, “Хөрсөн дотроос нэвчүүлэх” гэсэн ангиллын дагуу асууж, асуулгыг нөхнө.

**Газрын гадаргын ус ашиглан усалсан** - Усжуулах зорилгоор устай газрыг бүрэн болон хэсэгчлэн хамруулах систем юм. Газар хагалах, талбайг зааглах болон сав газрын усжуулалт зэрэг олон төрөлтэй.

**Бороожуулах** - Шүршигч цоргоор усыг тодорхой даралтаар тариалан руу дамжуулах сүлжээг харуулна. Энэ систем нь аадар бороотой төстэй усыг дээрээс цацах систем юм. Шүршигч системийг заримдаа дээрээс усжуулах систем гэж ойлгож болно.

**Дуслын системийн аргаар** - Бага даралтаар хоолойгоор дамжуулан усыг түгээх систем юм. Үүний хэд хэдэн төрөл бий: дусал усалгаа (хөрсний гадаргуу руу ус аажуухнаар дусах), шүрших эсвэл жижиг шүршүүрэн усалгаа (ус хөрс болон ойролцоох ургамал, мод рүү цацагдах) болон хөөсөн усалгаа (усны жижиг урсгал үерийн жижиг сав газар эсвэл мод бүрийн хөрс рүү шингэх). Тогтоосон усжуулалтын түгээмэл хэрэглэгддэг бусад төрөлд микро усжуулалт, годгодох усалгаа, өдөр тутмын усалгаа, дусал усалгаа, шимэх усалгаа зэрэг болно.

**52. Усжуулалтын эх үүсвэрээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь усжуулалт хийхдээ усалгааны ямар эх үүсвэрийг ашиглаж байгааг асуулгад тусгагдсан “Газрын доорхи усаар (өрмийн худгаар)”, “Газрын доорхи усаар (энгийн уурхайн худгаар)”, “Газрын дээрх усаар (гол, нуур, цөөрөм, булаг, шандны усаар)”, “Газрын дээрх усаар (ус хуримтлуулах усан сан бүхий боомтын усаар)”, “Газрын дээрх усаар (ус нөөцлөх саванд хадгалсан усаар)”, “Цэвэршүүлсэн хаягдал усаар”, “Бороо, цасны ус хуримтлуулж усалдаг”, “Үерийн, эргээс хальсан усыг ашиглаж усалдаг”, “Бусад “ гэсэн ангиллаар асууж нөхнө.

**53. Танайх усны төлбөр төлдөг үү?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь усны төлбөр төлдөг эсэхийг асууж, төлбөр төлдөг бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ, төлдөггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг сонгож **Бүлэг IV руу** шилжинэ.

**54. Усны төлбөрийн нөхцлөө хэлнэ үү.** Усалсан талбайн усны төлбөр хийгдсэн эсэхийг харуулна. Төлбөрийг “Ахуйн хэрэглээнд үндэслэж”, “Үйлдвэрлэлийн хэрэглээнд үндэслэж”, “Бусад” гэсэн ангиллаар асууж, бүртгэн нөхнө.

#### **IV. ГАЗАР, ТАРИАЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**55. Тариалсан болон хураасан талбайн хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн өрхийн тариалсан нийт талбай болон хураасан нийт талбайн хэмжээг ургамлын төрлөөр га-гаар нөхнө. Хэрэв өрхийн хувьд тариалсан талбайг м<sup>2</sup>, сот-оор хэмжиж байвал доорх итгэлцүүрийг ашиглан га-д шилжүүлэн тавина.

##### **Хэмжих нэгжид шилжүүлэх итгэлцүүр**

1 га	=	10000 м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000 м <sup>2</sup>	=	1 га

**Тариалсан талбай** - тариалангийн үйлдвэрлэл эрхлэх зориулалттай иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаахөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Тариалсан газарт хүний үйл ажиллагаагаар тарьж ургуулсан ургамал бүхий тариалангийн талбайг хамруулна. Дор дурдсан таримал ургамал бүхий талбайг тариалсан газарт хамааруулахгүй.

- байгалийн хадлан, бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор нэг ба олон наст ургамлын үр цацах, услах, бордох зэргээр сайжруулж тордсон бэлчээр, хадлангийн талбай;
- хот, суурингийн дотор тарьж ургуулсан мод болон зүлэгжүүлсэн талбай, хот орчмын ногоон бүс;
- элсний нүүдэл зогсоох зорилгоор тарьсан мод, бут, сөөг.

**Ургац хураасан талбай** гэж тариалсан нийт талбайгаас ургацыг хураасан нийт талбайг хэлнэ. Тиймээс, ган гачиг, үер ус, хортон шавьжны болон бусад шалтгааны улмаас сүйтгэгдсэн талбайг оруулахгүй.

**Үр** гэж тухайн сортын нөхөн үржлийг хангах чадвартай, дахин сэргээх, үржүүлэх болон аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа амьд үр, суулгац, тарьцыг хэлнэ.

**Шилмэл сортын үр** гэж тухайн бүс нутагт биологи, аж ахуйн нийтлэг болон тодорхой шинжээр шалгарч, үндэсний стандартыг хангасан, сорт сорилтын зөвлөлөөр батлагдан, тариалах сортын нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэн сортын үрийг хэлнэ. Буудайн Орхон, Дархан-34, Дархан-74, Бурятская-34, Бурятская-79, Халхгол-1, Цагаандэглий, төмсний голландын Импала, Санте, германы Витара зэрэг нь шилмэл сортын үрэнд орно.

Дээр тодорхойлсон тариалсан талбай, шилмэл сортын үрээр тариалсан талбай, ургац хураасан талбай нь таримлын дараах төрөл тус бүр дээр нөхөгдөнө. Үүнд:

<b>+ <u>Үр тариа</u></b>	<b>+ <u>Төмс</u> <b>+ <u>Хүнсний ногоо</u></b></b>	<b>+ <u>Тэжээлийн ургамал</u></b>	<b>+ <u>Техникийн ургамал</u></b>
<ul style="list-style-type: none"> <li>- буудай</li> <li>- арвай</li> <li>- овъёос</li> <li>- хөх тариа</li> <li>- бог будаа</li> <li>- бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- байцаа</li> <li>- шар манжин</li> <li>- улаан манжин</li> <li>- лууван</li> <li>- сонгино</li> <li>- сармис</li> <li>- өргөст хэмх</li> <li>- улаан лооль</li> <li>- тарвас, гуатан</li> <li>- бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ногоон тэжээл</li> <li>- олон наст</li> <li>- даршны ургамал</li> <li>- бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Наранцэцэг</li> <li>- Эрдэнэшиш</li> <li>- чихрийн манжин</li> <li>- тосны ургамал</li> <li>- бусад</li> </ul>
			<b>+ <u>Эмийн ургамал</u></b> <b>+ <u>Жимс, жимсгэнэ</u></b>

**Хийгдэх балансын шалгалт:**

- Шилмэл сортын үрээр тариалсан болон ургац хураасан талбай нь дүн нь нийт тариалсан талбайгаас сугарч гарна. (багана1>=багана2), (багана1>=багана3)
- Нийт тариалсан талбай, шилмэл сортын үрээр тариалсан талбай, ургац хураасан талбай нь ургамал тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

$$(мөр1=мөр2+мөр9+мөр10+мөр22+мөр28+мөр35:мөр38)$$

- Хүнсний ногооны хувьд: нийт тариалсан, шилмэл сортын үрээр тариалсан, ургац хураасан талбай тус бүр нь хүнсний ногооны төрөл тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

(мөр10=мөр11:мөр21)

- Тэжээлийн ургамлын хувьд: нийт тариалсан, шилмэл сортын үрээр тариалсан ургац хураасан талбай тус бүр нь тэжээлийн ургамлын төрөл тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

(мөр22=мөр23:мөр27)

- Техникийн ургамлын хувьд: нийт тариалсан, шилмэл сортын үрээр тариалсан, ургац хураасан талбай тус бүрийн дүн нь техникийн ургамлын төрөл тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

мөр28=(мөр29:мөр34)

**56. Танайх хүлэмжийн тариалалт хийдэг үү?** Тухайн өрхөөс хүлэмжийн тариалалт хийсэн эсэхийг асууж Тийм гэж 1-ийг дугуйлж, **Асуулт 59 рүү** шилжинэ. Усалгаатай тариалан эрхэлдэггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, эрхлэхгүй байгаа шалтгааныг асууж нөхнө.

**57. Хүлэмжийнхээ нийт талбайн хэмжээгээ хэлнэ үү.** Энд тухайн өрхийн хүлэмжинд тариалсан нийт талбай болон хураасан нийт талбайн хэмжээг ургамлын төрлөөр, м<sup>2</sup>-аар асууж нөхнө.

**58. Хүлэмжийн суулгац суулгасан нийт талбай, ургац хураасан талбай, ургацын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн өрх, аж ахуйн нэгж, иргэний хүлэмжинд тариалсан нийт талбай, шилмэл сортын үрээр тариалсан талбай, хураасан нийт талбай, ургацын хэмжээг асууж, ургамлын төрлөөр задлан нөхнө.

Хүлэмжинд тариалсан ургамлыг дараах төрлөөр нь асууна. Үүнд:

<ul style="list-style-type: none"> <li>+ <b><u>Хүнсний ногоо</u></b></li> <li>- өргөст хэмх</li> <li>- улаан лооль</li> <li>- салат</li> <li>- перец</li> <li>- хаш</li> <li>- чинжүү</li> <li>- навчит ногоо</li> <li>- бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>+ <b><u>Гүзээлзгэнэ</u></b></li> <li>+ <b><u>Хүнсний ногооны суулгац</u></b></li> <li>+ <b><u>Цэцэгний суулгац</u></b></li> <li>+ <b><u>Цэцэг</u></b></li> <li>+ <b><u>Мөөг</u></b></li> <li>+ <b><u>Бусад</u></b></li> </ul>
---	--

Дээрх хүлэмжинд тариалсан ургамлын төрлөөс өөр төрлийн ургамал хүлэмжинд тариалсан бол бусад гэсэн хэсэгт нэрийг нь бичиж нөхнө. Энэ бусад хэсэгт зөвхөн 3 төрлийн ургамлыг нөхөх боломжтой учраас талбайг хэмжээгээр нь эрэмбэлж: бусад1-д хамгийн чухал нь бусад 2-д дараагийнх бусад 3-д үлдсэн ургамлын төрлүүдийг нэгтгэж нөхнө.

Шилмэл сортын үрээр тариалсан болон ургац хураасан талбайн хэмжээ нь нийт талбайгаас сугарч гарах бөгөөд нийлбэр нь нийт дүнтэй барихгүй.

#### **Хийгдэх балансын шалгалт:**

- Шилмэл сортын үрээр тариалсан болон ургац хураасан талбай хэмжээ нь талбай тус бүрээр нийт дүнгээс бага буюу тэнцүү байж болно. (багана1>=багана2), (багана1>=багана3)
- Хүлэмжийн суулгасан бүгд талбай нь хүнсний ногоо, гүзээлзгэнэ, хүнсний ногооны үрслэг, цэцэгний үрслэг, цэцэг, мөөг, бусад төрлийн ургамлын суулгасан талбайн нийлбэртэй тэнцүү байна. (мөр1=мөр4+мөр13+мөр20)
- Хүнсний ногооны суулгасан талбай нь ургамал тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр4=мөр5:мөр12)

**59. Танайх жимс, жимсгэнэ тариалдаг уу?** Тухайн өрх жимс, жимсгэний тариалдаг бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, тариалдаггүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, **Асуулт 61 руу** шилжинэ.

**60. Жимс, жимсгэнэ тариалсан нийт талбай, мод, бутны тоогоо хэлнэ үү.** Тухайн өрхийн жимс, жимсгэний талбай, суулгасан мод, бутны тариалсан тоо хэмжээг жимс жимсгэний төрлөөр асууж нөхнө. Мөн үр жимсээ өгөх тариалсан талбай, суулгасан мод, бутны тоог ургамлын төрлөөр ангилан асуулгад нөхнө.

Жимс, жимсгэний тариалсан талбайг нийт, үүнээс үр жимсээ өгөх, суулгасан мод бутны тоог нийт, үүнээс үр жимсээ өгөх гэж ангилан, хүснэгтэд тавигдсан жимс, жимсгэний төрлөөр бүртгэнэ.

#### **Хийгдэх балансын шалгалт:**

- Нийт тариалсан талбайгаас үр жимсээ өгөх талбайг сугалж харуулах бөгөөд үр жимсээ өгөх талбай нь нийт талбайтай тэнцүү эсвэл бага байна. (багана1>=багана2),
- Суулгасан мод, бутны нийт дүнгээс үр жимсээ өгөх мод, бутны тоог салгаж харуулах бөгөөд үр жимсээ өгөх мод, бутны тоо нь суулгасан нийт мод, бутны дүнтэй тэнцүү буюу бага байна. (багана3>=багана4)
- Тариалсан талбайн бүгд дүн нь жимс, жимсгэнэ тус бүрийн тариалсан талбайн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр14)
- Жимс, жимсгэний мод, бутны суулгацын бүгд дүн нь жимс, жимсгэнэ тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр16=мөр16:мөр21)

**61. Танайх ургамал хамгаалах болон хөрс сайжруулах зорилгоор бордоо, бодис ашигласан уу?** Тухайн өрхийг бордоо, бодис хэрэглэсэн эсэхийг асууж, хэрэглэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлга хэрэглээгүй бол Үгүй гэж 2 гэсэн хариултыг дугуйлж, **Бүлэг V руу** шилжинэ.

**62. Танайх ашигласан бордооныхоо талаар дараах мэдээллийг өгнө үү.** Тухайн өрх ургамал хамгаалалт, хөрс сайжруулахдаа ашигласан бордоо, бодис, бордсон талбай, хортон шавж устгасан талбайг бордоо, бодисны нэр төрлөөр асууж, асуулгад нөхнө. Хэрэглэсэн бордоо, бодис нь тонноор, бордсон талбай, хортон шавжны устгал хийсэн талбай м<sup>2</sup>-аар илэрхийлнэ.

**Бордоо** гэж эрдэс болон органик бодисыг хэлэх бөгөөд бордоог тэжээллэг ургац авах болон ургацын өсөлтийг нэмэгдүүлэхэд хэрэглэдэг. “Бордоо”-ны нөхцөл нь дор хаяж 5 хувийн N, P2O5 болон K2O гэсэн 3 анхдагч тэжээллэгийн бүрдлийг агуулсан ургацын тэжээллэгийн эх үүсвэр болно. Дээрхи 3-ын 5 хувиас доош тэжээллэг агуулсан бүтээгдэхүүнийг ургамлын өсөлтийг нэмэгдүүлдэг бусад

органик бодист оруулна. ХАА-н үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд бордооны нэг болон түүнээс дээш хэлбэрийг ашиглаж болно.

**Бодис** нь тариалангийн газарт хортон шавьжустгах зорилгоор ашигласан бодис юм.

**Бордоо, бодисыг** дараах байдлаар ангилна. Үүнд:

**Байгалийн гаралтай органик бордоо.** Боловсруулалт хийсэн ургамал болон амьтны биеэс эсвэл боловсруулалт хийгдээгүй дор хаяж 5 хувийн ургамлын тэжээлийг эрдэс бордоотой (тос, фосфор гэх мэт) нийлүүлэн гаргаж авсан бордоо юм. Органик бордоо нь яс, хоол, загасны хоол, арьс болон цус зэрэг амьтнаас гаргаж авсан зарим нэгэн органик бодисыг агуулна. Гүмины бордоо, биоалзмагийн бордоо, био бордоо, бактерийн бордоо зэрэг орно.

**Ургацын өсөлтийг нэмэгдүүлдэг бусад органик бордоо-** Хөрсний дутуу байгаа тэжээлийн агууламжийг болон бусад дутагдлыг нь нөхөхөд зориулагдсан. Өтөг бууц, шавар, холимог бордоо болон сангас гэх мэтийн бусад органик бодисууд нь шаардлагатай тэжээллэгээс бага тэжээл агуулдаг ба үүнийг “ургацын өсөлтийн нэмэгдүүлдэг бусад органик бордоо” гэж үздэг. Үүнд өтөг бууц, малын баас, холимог бордоо, шавар, зэрлэг жимс, үртэс, ургамлын үлдэгдэл, нийлэг хөрсний ангижруулагч гэх мэт багтана. **“Өтөг бууц”** нь малын үлдэц, баас, шивтэр, малын хэвтэр, бууц зэргээр хийсэн бордоо юм. **“Шавар”** нь усаар шингэлсэн эсвэл шингэлээгүй амьтны хатсан ялгадсыг шингэнтэй хольсон бордоо юм. **“Холимог бордоо”** нь ургамал, амьтны органик бодисын нэрмэлээс бүрдэнэ. **“Сангас”** нь бохирос гаргасан органик бодисын үлдэгдэл юм.

**Эрдэс бордоо-** органик биш бодисоос үйлдвэрийн аргаар гаргаж авсан бордоо юм. Эрдэс бордоог “химийн бордоо”, “байгалийн биш бордоо” болон “органик бус бордоо” гэх зэргээр нэрлэдэг. Азот, фосфор, кали, нийлмэл бордоо энэ хэсэгт орно.

**Пестицид** гэж мал, амьтан, ургамлыг аливаа өвчнөөс сэргийлэх, хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах зориулалттай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.

**Гербицид** таримал ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх зориулалттай.

**Инсектицид** хортон шавж устгах, ургамлыг өвчнөөс сэргийлэх, ялзрахаас хамгаалах зориулалттай.

**Фунгицид** үр тариа, төмс, хүнсний ногооны үр, агуулах, зоорь ариутгах зориулалттай.

**Родентицид** таримал ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх зориулалттай.

**Биологийн бэлдмэл** бэлчээрийн хөнөөлт шавж, мэрэгчтэй тэмцэх зориулалттайгаар хэрэглэгдэнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Эрдэс бордооны бүгд дүн нь бордооны төрөл тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр3=мөр4:мөр7)
- Пестицидийн нийт дүн нь пестицидийн төрөл тус бүрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. (мөр8=мөр9:мөр13)

## V. ХАА-Н ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ

**63. ХАА-н гаралтай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хураасан ургацын хэмжээг хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгуулагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хураасан

ургацын хэмжээг асууж нөхнө. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хураасан ургацын хэмжээг сануулах замаар ярилцаж, нөхнө.

Нийт үйлдвэрлэсэн, хураасан бүтээгдэхүүн, түүний хэрэглээ, зарцуулалтыг (үрэнд хэрэглэсэн, өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн) хүснэгтэд нэр заан өгсөн нэр төрлөөр асууж бүртгэнэ. Бүртгэхдээ хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжийг сайтар анхаарна.

Хариулагч хэмжих нэгжийг хүснэгтэд тавигдснаас өөрөөр хэлсэн тохиолдолд хүснэгтэд тавигдсан хэмжих нэгж рүү шилжүүлэхдээ доорх итгэлцүүрийг ашиглана.

#### Хэмжих нэгж шилжүүлэх итгэлцүүр

1 кг	=	1000 гр
1 т	=	1000 кг
1 л	=	1.03 кг

Хүснэгтэд нэр зааснаас өөр бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бол “Бусад” мөрөнд нэрийг бичиж бүртгэнэ.

Дараах балансын шалгалтыг хийнэ. Үүнд:

- Нийт үйлдвэрлэлт нь үрэнд болон өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлс, урамшуулалд олгосон, нөөцөлсөн болон бусад хэлбэрээр хэрэглэсэн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна. (багана1=багана2:багана8)
- Үр тарианы төрөл тус бүрийн дүнгийн нийлбэр нь нийт үйлдвэрлэсэн үр тариатай тэнцүү байна. (мөр1=мөр2:мөр6)

**64. Танайх бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг вэ? (Нэгээс дээш сонголт байж болно)** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж байгааг “Хувь хүн ирж авдаг”, “Аж ахуйн нэгж, байгууллагад”, “Зах зээлд өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Борлуулалтыг нөхөхдөө хамгийн их борлуулалт хийдэг 3-аас илүүгүй хэлбэрийг дугуйлна.

Бүтээгдэхүүнээ хөдөөд ярьж заншснаар мах, ноос, ноолуур, төмс, хүнсний ногоо зэргийг өөрсдөө ирж авдаг түүхий эдийн ченжүүд болон хувь хүнд борлуулсан бол “Хувь хүн ирж авдаг”, мах, ноос, төмс, хүнсний ногоо бэлтгэдэг компанийн төлөөлөгч өрх, хувь хүн, хоршоо зэрэгт борлуулсан бол “Аж ахуйн нэгж, байгууллагад”, сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол “Зах зээлд өөрсдөө борлуулдаг” гэсэн сонголтыг хийнэ. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол “бусад” гэсэн ангилалд оруулна.

**65. Танай бүтээгдэхүүний борлуулалттай холбогдон гардаг хүндрэлээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад гарч байгаа хүндрэлийг “Борлуулалт удаашралтай”, “Хэрэглэгч цөөн”, “Өрсөлдөгч олон”, “Зах зээлээс алслагдсан”, “Үнэ хямд”, “Бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж нөхнө. Хүндрэлийг нөхөхдөө хамгийн их тохиолддог 3-аас илүүгүй хүндрэлийг сонгоно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**66. Танайх бүтээгдэхүүнийхээ үнийг хэрхэн тогтоодог вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ үнээ хэрхэн тогтоож байгааг “Зардал дээр ашгийг нэмэх замаар”, “Хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр”,

”Өрсөлдөгчийн үнээс хамаарч”, “Зах зээлийн үнэ, ханшаар”, “Бусад” гэсэн төрлөөр асууж нөхнө. Үнээ тогтоодог 3-аас илүүгүй аргыг дугуйлна.

**67. Танайх 2011 онд ургац алдсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын алдсан ургацын хэмжээг асууж нөхнө. Ургац алдсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ургац алдаагүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, **Бүлэг VI руу** шилжинэ.

**68. Ургац алдсан шалтгаанаа нэрлэнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ургацаа алдсан шалтгааныг “Үерт автагдсан”, “Ган болсон”, “Мөндөрт цохиулсан”, “Цочир хүйтэрсэн”, “Цасанд даруулсан”, “Хүчтэй салхи, шуурганд цохигдсон”, “Зэрлэг ургамал, хортон шавж идсэн”, “Мал талхалсан”, “Тариалалтын горим алдагдсан”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж, бүртгэнэ.

## **VI. ГАЗАР, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

**69. Танайх өөрийн өмчийн газартай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн өмчийн газартай эсэхийг асууж газартай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, газаргүй бол Үгүй гэж 2 –ыг дугуйлж, **Асуулт 72 руу** шилжинэ.

**70. Газрын үнэлгээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын газрын үнэлгээг асууж, сая төгрөгөөр нөхнө. Газрын үнэлгээг тухайн хариулагчийн өөрийн хэлснээр бүртгэнэ.

**71. Газрын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиран зарцуулах эрх бүхий газрын хэмжээг асууж бүртгэнэ. Газрын хэмжээ нь га-гаар байна.

Га-д шилжүүлэхдээ дараах итгэлцүүрийг ашиглана:

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000м <sup>2</sup>	=	1 га

**72. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй юү?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага машин, тоног төхөөрөмжтэй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, машин, тоног, төхөөрөмжгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан **Бүлэг VII руу** шилжинэ.

**73. Хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийнхөө талаарх мэдээллийг хэлнэ үү.** Машин, тоног төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн машин болон түрээслэн ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоо, төрөл тус бүрээр нь нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжид** өөрийн, хамтын эзэмшлийнх болгосон эсвэл зээл болон лизингээр худалдаж авсан машин, тоног төхөөрөмжийг оруулна.

**Түрээсэлсэн машин, тоног төхөөрөмжид** төрийн байгууллагаас болон бусдаас түрээсэлсэн, төлбөртэй болон төлбөргүйгээр зээлж ашигласныг энд оруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанд** тухайн машин, тоног төхөөрөмжийг худалдаж авснаас хойш хэдэн жил болж байгаа хугацааг бүтэн жилээр илэрхийлж, нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг бүртгэхдээ** тухайн аж ахуйн нэгж, байгууллагын балансын үнээр бүртгэнэ. Үнийн дүнг **мянган төгрөгөөр** илэрхийлнэ.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийг дараах жагсаалтаас харж, хүснэгтэд тохирох кодыг тавина.

**Машин, тоног төхөөрөмжийн код:**

Анжис	01	Дуслын услалтын төхөөрөмж	17	Будаа цэвэрлэгч	33	Явган трактор , тоног төхөөрөмжийн иж бүрдлийн хамт (10 м.х-ээс бага )	49
Эргэдэг борной	02	Бороожуулагч төхөөрөмж (1 га хүртэл талбай услах)	18	Будаа ачигч	34	Бага оврын дугуйт трактор (10-20 м.х)	50
Бусад борной	03	Бороожуулагч төхөөрөмж (1-10 га талбай услах)	19	Механикжсан үтрэм	35	Дунд оврын дугуйт трактор (25-60 м.х)	51
Бул	04	Бороожуулагч төхөөрөмж (10 га-аас дээш талбай услах)	20	Хор цацагч	36	Зүтгэх хүчний дугуйт трактор (80-130 м.х)	52
Өргөн холбоо	05	Цайруулагч	21	Сэрээ	37	Дугуйт трактор (139-275 м.х)	53
Газар хагалагч	06	Үр тарианы комбайн	22	Бага оврын тракторын хадуур	38	Дугуйт трактор (275-аас дээш м.х)	54
Сийрүүлэгч, зээтүү, культиватор	07	Төмсний комбайн	23	Морин хадуур	39	Морин тэрэг	55
Сэндэчлүүр	08	Даршны өөрөө явагч комбайн	24	Бусад хадуур	40	Үхэр тэрэг	56
Үр тарианы үрлүүр	09	Даршны чиргүүлийн комбайн	25	Бага оврын тракторын тармуур	41	Тэмээн тэрэг	57
Тэжээлийн болон техникийн таримлын үрлүүр	10	Ногоон тэжээл хэрчигч комбайн	26	Морин тармуур	42	Суудлын машин	58
Төмсний үрлүүр	11	Өөрөө явагч жатка	27	Бусад тармуур	43	Ачааны машин	59
Хүнсний ногооны үрлүүр	12	Чиргүүлийн жатка	28	Хаман боогч	44	Мотоцикл	60
Хуурай эрдэс бордоо цацагч	13	Дүүжин жатка	29	Пресслэгч машин	45	Хөргөгч	61
Бууц цацагч	14	Төмс сортлогч	30	Нуруулдагч	46	Бусад төхөөрөмж	62
Нэвчүүлэх усжуулах төхөөрөмж	15	Нэг эгнээний төмс ухагч	31	Чиргүүл	47		
Мананжуулах услалтын төхөөрөмж	16	Хос эгнээний төмс ухагч	32	Гинжит трактор	48		

**VII. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ**

**74. Танайх хөдөө аж ахуйн зориулалтын барилга, байгууламжтай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас зориулалтын барилга, байгууламж ашигласан эсэхийг тодруулан асууж, ашигласан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, ашиглаагүй бол Үгүй гэж 2–ыг дугуйлж, **Бүлэг VIII руу** шилжинэ.

**75. Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгуулгаас ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн талаарх мэдээллийг асууж нөхнө. ХАА-н барилга, байгууламжийг тоо, ширхэг, багтаамжаар бүртгэж, эзэмшлийн төрлөөр нь ашиглаж байгаа, бусдад түрээслүүлсэн, ашиглахгүй байгаа гэсэн ангиллаар бүртгэнэ. Мөн бусдаас түрээсэлсэн хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн тоог асууж нөхнө.

ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн ашигласан хугацаа, хөрөнгийн үнэлгээг нэр төрлөөр, асууж бүртгэнэ. Хөрөнгийн үнэлгээг мянган төгрөгөөр илэрхийлнэ. Үнэлгээг бүртгэхдээ хариулагчийн өөрийн хэлсэн үнэлгээгээр нөхнө.

ХАА-н зорилгоос бусад зорилгоор ашиглаж байгаа орон сууцны бус барилга, байгууламжийг энд оруулахгүй.

Дээрх үзүүлэлтүүдийг “Албан газрын зориулалттай барилга”, “Хүлэмж”, “Агуулах”, “Зоорь”, “Үр тарианы элеватор”, “Үтрэм”, “ХАА-н техник хадгалах байгууламж буюу гарааш”, “ХАА-н техникийн засварын газар”, “Бусад” гэсэн ангиллаар асууж бүртгэнэ.

**ХАА-н техникийн засварын газарт** машины гарааш болон бусад тоног төхөөрөмж хадгалах байр багтана.

Агуулахад үр тариа, өвс, бусад материалыг хадгалах зориулалтаар мод, чулуу, тоосго, брезент, блок зэргийг ашиглан барьсан ХАА-н үйлдвэрлэлийн барилгыг хамруулна.

Зооринд төмс, хүнсний ногоо, мах хадгалах зориулалтаар газар ухаж гаргасан байрыг оруулна. Мөн төмс, хүнсний ногоог хүлээн авах, ялгах үйл ажиллагааг техникээр гүйцэтгэдэг, хадгалалтын горимыг автоматаар тохируулах боломжтой механикжсан зоорь, гар аргаар газар ухаж, дулаалга хийсэн энгийн зоорь, гэр, сууцны дотор талд мөн газар ухаж гаргасан нүхэн зоорь, мөн газрыг цооноглон ухаж хадгалах тасалгаа хийсэн нүхэн зоорийг зооринд тус тус хамруулна. Зоорь нь дангаараа төмс, хүнсний ногоо, махны мөн холимог байдлаар төмс, хүнсний ногооных гэсэн хэлбэрээр байж болно.

## VIII. ХУДАГ, УСАН САН

**76. Танайх өөрийн эзэмшлийн худаг, усан сантай юу?** Тухайнаж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил худаг, усан сантай эсэхийг асууж, хариултыг нөхнө.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил худаг, усан сантай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ.

Өөрийн эзэмшил худаг, усан сангүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлан Бүлэг IX руу шилжинэ.

**77. Худаг, усан сангийнхаа талаарх мэдээллийг хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа худаг, усан сангийн тоо, усан сангийн багтаамжийг байршил, ашиглалтын хэлбэрээр асууж, нөхнө.

Худаг, усалалтын системийг анх барьж байгуулахад гүйцэтгэсэн үйлжиллагаагаар нь өрөмдмөл(гүний), богино яндант болон энгийн гэж ялгана.

**Өрөмдмөл худаг, (гүний)**-Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор өрөмдөж, ханыг нь бэхэлж байгуулсан, босоо цооногийн уст үед байрлуулсан, ус шүүж оруулах яндан шүүртэй, дотор талдаа усны шахуурга, ус дамжуулах хоолойтой инженерийн байгууламжийг хэлнэ.Өөрөөр хэлбэл харьцангуй голч /150, 200, 250, 300, 350, 400 мм /-той, 30 метрээс доош гүнтэй цооног бүхий цахилгаан буюу дизель хөдөлгүүртэй ус өргүүртэй худгийг өрөмдмөл худаг гэнэ.

**Богино яндант худаг**-Газрын гүний усыг авч ашиглах зорилгоор том голчоор өрөмдөж ханыг нь 1м голч урттай бетон цагиргийг давхарлан 3м гүнд суулгасан, түүнээс доош 30м хүртэл гүнд бага голчтой цооног өрөмдөж төхөөрөмжилсөн өрөмдмөл худгийн зохион байгуулалттай ижил инженерийн байгууламжийг хэлнэ.Өөрөөр хэлбэл харьцангуй бага голч /150, 200, 250 мм /-той, 30 метр хүртэл гүнтэй цооног бүхий худгийг богино яндант худаг гэнэ.

**Энгийн уурхайн /гар худаг/-** Хөрс, геологийн тогтолцоог ажиглаж судалсны үндсэн дээр хөрсний өнгөн хэсэгт ус байх магадлал бүхий газарт 8м хүртэл гүн

ухаж гаргасан цооногийн ханыг мод, чулуу зэрэг материалаар хашиж бэхэлсэн худгийг хэлнэ.

**Усан сан** гэж улс, орон нутгийн хүчээр баригдсан 4 ба түүнээс дээш куб м багтаамжтай мал услах талбай, онгоцтой усалгааны цэгийг хэлнэ.

**Хийгдэх балансын шалгалт:**

- Нийт худгийн тооноос бэлчээрт байршдаг болон ашигладаггүй худгийн тоо нь сугарч харагдах бөгөөд дүнд барихгүй.(багана1>=багана3), (багана1>=багана4)
- Өрөмдлөгийн, богино, яндант, энгийн уурхайн, бусад төрлийн худгийн дүнгийн нийлбэр нь худгийн бүгд дүнтэй тэнцүү байна.(мөр1=мөр2:мөр5)

## **IX. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭ**

**78. Танайх эрсдлээс хамгаалах зориулалттай дараах төрлийн даатгалд үйлчилгээнд хамрагдсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага эрсдлээс хамгаалах даатгалын үйлчилгээнд хамрагдсан эсэхийг асууж нөхнө. Эрсдлээс хамгаалах даатгал малын индексжүүлсэн даатгал, арилжааны бусад даатгал, үрийн тариалангийн даатгал зэрэг хамрагдана. Бусад даатгалд дээрх 3 төрлөөс бусад төрлийг даатгал багтана.

**79. Танайх хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар сүүлийн 5 жилд зээл авсан уу.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг ХАА-н зориулалттай зээл авсан эсэхийг асууж, зээл авсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, зээл аваагүй бол Үгүй гэж 2–ийг дугуйлж, **асуулт 85** руу шилжинэ.

**ХАА-н зориулалттай зээлд** тухайн өрх нь үйл ажиллагаандаа зориулан авсан зээлийг оруулна. Үүнд, газар тариалан болон мал аж ахуйд ашиглагдах материал, орцыг худалдан авах, фермийн барилга, байгууламж барих болон тоног төхөөрөмж худалдан авахад зориулан авсан зээл хамрагдана.

Харин сууц, байшин барих, гэр бүлийн бусад бизнес, хэрэглээний зардал зэрэгтээ зориулан зээл авсан бол ХАА-н зориулалттай зээлд оруулахгүй. Авсан зээлд сүүлийн 5 жилд буюу 2007 оноос хойш авсан зээлийг хамруулна.

**80. Ямар хугацаагаар хэдэн удаа зээл авсан бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь хэдэн удаа зээл авсныг “Нэг удаа”, “Хоёр удаа”, “Гурав ба түүнээс дээш” гэсэн ангиллаар асууж, авсан зээлийн тоог хүснэгтэд нөхнө.

**81. Танайх зээлээ хаанаас авсан бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага зээлээ ямар эх үүсвэрээс авсныг тодруулан асууж нөхнө. Зээлийн эх үүсвэрийг “Арилжааны банкнаас”, “Банк бус санхүүгийн байгууллагаас”, “Хадгаламж, зээлийн хоршооноос”, “Хувь хүн, иргэдээс”, “Төрийн байгууллагаас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна. Нэгээс дээш сонголтыг хийж болно. Хэрэв тухайн аж ахуйн нэгж нь арилжааны банкнаас зээл авсан бол **Асуулт 82 руу** шилжинэ. Банкнаас бусад газраас зээл авсан бол **Асуулт 83 руу** шилжинэ. Төрийн байгууллагаас авсан зээлд Засгийн газрын болон бусад холбогдох яамд, газар, орон нутгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээлийн энд оруулна. Тухайлбал: сум хөгжүүлэх сан, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл орно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**82. Арилжааны банкны нэр код.** Арилжааны банкны нэрийг бичиж, кодыг хүснэгтийн дор хэсэгт байгаа кодоос харж тавина.

Голомт банк	1	ХААН банк	3	Хас банк	5	Бусад банк	7
Капитал банк	2	Хадгаламж банк	4	Худалдаа хөгжлийн банк	6		

**83. Танайх зээл авахдаа хөрөнгө барьцаалсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь зээл авахдаа хөрөнгө барьцаалсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Хөрөнгө барьцаалсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ, барьцаалаагүйбол Үгүй гэж 2-ыг дугуйлан **асуулт 85 руу шилжинэ.**

**84. Танайх зээл авахдаа барьцаалсан хөрөнгөө хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага авсан зээлийг барьцааг тодруулан асууж нөхнө. Барьцааг мал, газар, машин, тоног төхөөрөмж, бусад гэсэн төрлөөр ангилан асууна. Нэгээс дээш сонголт байж болно.

**85. Танайх ХАА-н салбарын талаар мэдээлэл авдаг эх сурвалжаа хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага ХАА-н үйл ажиллагаатайгаа холбоотой, мэдээллийг хүлээн авч байгаа эх сурвалжийг үүнд хамруулна. ХАА-н талаарх мэдээлэлд, цаг агаар, тариалалт, ургац хураалт, ХАА-н шинэлэг арга туршлагууд, машин, тоног төхөөрөмж, зээлийн үйлчилгээ, байгалийн гамшиг гадаад, дотоод зах зээл, ХАА-н эдийн засгийн байдал зэргийн талаарх ХАА-тай холбоотой бүх төрлийн мэдээлэл орно.

Эх сурвалж нь нэгээс дээш сонголттой байж болно. Мэдээллийг авч байгаа эх сурвалжийг “Радио”, “Телевиз”, “Сонин,сэтгүүл”, “Интернэт”, “Төрийн байгууллага”, “Төрийн бус байгууллагаас”, “Мэргэжлийн байгууллага”, “Иргэд”, “Гар утас”, “Бусад” гэсэн ангиллаар асууна.

**86. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ ихэвчлэн борлуулдаг зах зээл танайхаас хэр зайтай вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл хүртэлх зайг асууж, нөхнө. Зах зээл хүртэлх зайг 1-9 хүртэл км, 10-49 хүртэл км, 50-99 хүртэл км, 100 ба түүнээс дээш км гэсэн ангиллаар асууна. Зах зээл хүртэлх зайг 3,5 км гэж хариулсан бол 4 км гэж бүхэлд шилжүүлэн “1-9 хүртэл км” гэсэн ангилалд оруулна.

## БҮЛЭГ VII. ОЙН АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР

Ойн аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулах бөгөөд асуулга нь ойн аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын асуулга (ХААТ-4а) байна.

Асуулга нь ерөнхий мэдээллийн болон үндсэн 4 бүлэг асуултаас бүрдэнэ. Үүнд:

- I. Ерөнхий мэдээлэл
- II. Ойн аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт
- III. Ойн аж ахуйн бүтээгдэхүүний орлого, зардал
- IV. Газар, машин, тоног төхөөрөмж

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дугаарыг бичнэ. Тооллогын комиссын дугаарыг хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харна. Уг дугаар нь ХАА-н ам орон, сууцны тооллогод ашигласан дугаартай ижил байна.

**2. Аймаг, нийслэлийн нэр, код.** Энэ асуултад тухайн аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**3. Сум, дүүргийн нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж бичнэ.

**4. Баг, хорооны нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харж нөхнө.

**5. Тоологчийн нэр, дугаар.** Тоологч өөрийн нэрийг эцэг/ эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө: **Тоологчийн нэр, дугаар** гэсэн мөрийн 2 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрвээ 1 оронтой дугаар бол “01” гэх мэтчилэн өмнөх оронг “0” тавьж гүйцээнэ. Тоологчийн дугаарыг өгөхдөө сум, дүүрэг дотроо 01-ээс эхлэн дугаарлана. **Жишээ нь:** тухайн сум, дүүрэгт 5 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-05 хүртэлх дугаар өгнө, 2 дугаар сум, дүүрэгт 10 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-10 хүртэлх дугаар өгнө.

**6. Тооллогын асуулгын дугаар.** Тооллогын асуулгын дугаарыг тоологч бүр тоолж эхэлсэн эхний өрхөөс эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Хэрэв тухайн тоологч 2 багт ажиллах бол асуулгын хуудсыг баг тус бүрд 1-ээс эхлэн дугаарлана.

Тоологч тооллогын асуулгын дугаарыг давхардуулан олгож болохгүй.

**7. Шалгагч, кодлогчийн нэр, дугаар:** Сумын түвшинд тоологчоос тооллогын материалыг багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч шалган хүлээж авна. Аймгийн

түвшинд аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд сумдын тооллогын материалыг хүлээн авч, шалгах, кодлох ажлыг хийнэ.

Шалгагч, кодлогч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 1 оронтой дугаар бол "01" гэх ба өмнөх оронг "0" тавьж гүйцээж бичнэ. Шалгагч асуулгын хуудсыг үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон алхамыг зөв хийсэн эсэхийг хянаж, алдааг засварлана. Кодлохдоо аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, тоологч, шалгагч, гудамж, хороолол, бүсчлэл, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн зэрэг кодлолтыг хавсралтыг ашиглаж нөхнө.

**8. Шивэгчийн нэр, дугаар:** Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Шивэлтийг ҮСХ хариуцан хийх учраас шивэгч бүрт тусгайлан код олгоно.

## **I.2 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ**

**9. Аж ахуйн нэгж байгууллагын нэр.** Тухайн аж ахуйн нэгжийн нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө.

**10. Регистрийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн товчлохгүйгээр үнэн зөв нөхнө.

**11. Статистик нэгжийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын статистикийн регистрийн санд бүртгэгдсэн дугаар бөгөөд дугаарыг ҮСХ-ноос хүргүүлсэн жагсаалтаас харж тавина.

## **I.3 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭН/ДАРГА/ЗАХИРЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт тооллогод хамрагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын талаарх мэдээллийг асууж нөхнө.

**12. Эцэг (эх)-ийн нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын, эцэг (эх)-ийн нэрийг асууж, нөхнө.

**13. Нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын өөрийн нэрийг асууж, нөхнө.

**14. Хүйс.** Энэ асуулт ХАА-н үйлдвэрлэл дэх жендерийн байдлыг судлах ялангуяа, ХАА-н үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийг үнэлэх чухал үзүүлэлт болно. Энэ асуултын хариултыг нөхөхдөө аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, өрхийн тэргүүлэгчийн хүйсийг эрэгтэй гэж 1, эмэгтэй -2 гэсний аль тохирох кодыг дугуйлна.

**15. Нас (бүтэн жилээр).** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, өрхийн тэргүүлэгчийн насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь тооллого явагдаж байгаа жилээр гүйцэд тооцож тогтооно.

**16. Боловсролын түвшин.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын боловсролын түвшинг асууж, боловсролын түвшинд тохирох кодыг сонгон дугуйлна.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5

дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол**- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/-** Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**17. Ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын ажилласан жилд тухайн хүний хөдөлмөр эрхэлж эхэлсэн үеэс судалгаа авч байгаа үе /2011 он/ хүртэлх хугацааг оруулна. Дээрх хугацаанд хөдөлмөр эрхлээгүй үе гарвал тус хугацааг ажилласан жилд оруулахгүй. Ажилласан нийт жилийг бүтэн жилээр тавина.

Үүнээс: ойн аж ахуйн салбарт. Нийт ажилласан хугацаанаас хичнээн жилийг нь ойн аж ахуйн салбарт ажилласныг асууж, бичнэ. Амьдралынхаа туршид зөвхөн тус салбарт ажилд орсон цагаасаа ажиллаж ирсэн бол “Ажилласан жил” нь ойн аж ахуйн салбарт ажилласан жил”-тэй тэнцүү байна.

**18. Тухайн байгууллагын удирдлагаар ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын тухайн нэгждээ удирдлагаар ажилласан нийт жилийг асууж нөхнө.

**19. Тухайн байгууллагыг үүсгэн байгуулагчдын тоо.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг үүсгэн байгуулагчдын тоог асууж нөхнө.

#### **1.4 АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**20. Танайх 2011 онд ойн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг 2011 онд ойн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа

явуулсан эсэхийг асууж, хариултыг үйл ажиллагааны талаарх хариулттай уялдуулж шалгана.

Ойн аж ахуйн чиглэлээр 2011 онд ямар нэгэн үйл ажиллагаа эрхэлсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, **Асуулт 22 руу** шилжинэ, ойн үйл ажиллагаа эрхлээгүй гэж хариулсан бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, асуулгыг үргэлжлүүлнэ.

**21. Танайх 2011 онд ойн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаа хэлнэ үү.** Тухайн нэгж 2011 онд ойн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг асууж, хариултыг “Бусад ААНБ-тэй нэгдсэн”, “Үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн”, “Санхүүгийн боломжгүй байсан”, “Үйл ажиллагаагаа эхлээгүй”, “Бусад” гэсэн хариултаас сонгож нөхнө. **Бүлэг IV рүү** шилжинэ.

**22. Нийт ажиллагчдын тоо, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хүйсээр ялгаж, харгалзах нүдэнд нөхнө.

Ажиллагчдын тоонд аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, захирал нь орохгүй. Харин өрхийн гишүүд нь цалин хөлстэйгээр аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байвал ажиллагчдын тоонд оруулна.

Ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй, хүүхдийн хөдөлмөрийн тусгайлсан судалгаагаар энэ талаарх мэдээлэл цуглуулагдаж байна.

**23. Танайх ямар зориулалтаар ойн аж ахуй эрхэлдэг вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас 2011 онд ямар зориулалтаар ойн аж ахуй эрхэлсэнийг асууж, бүртгэнэ. Зориулалтыг дараах ангиллаар бүртгэнэ. Үүнд:

**Хэрэглээний** - сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хэрэглээний мод бэлтгэх, барилгын модон материал (банз, дүнз гэх мэт) бэлтгэх үйл ажиллагааг хэлнэ.

**Ойн арчилгаа, цэвэрлэгээний** - Ойг хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлүүдээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацанд нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, үйл ажиллагааг хэлнэ.

**Ойжуулалт, мод үржүүлэг** - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, борлуулах зорилгоор мод тарих, үрсэлгээ хийх үйл ажиллагааг хэлнэ.

**Бусад** - Дээрх гурваас бусад байдлаар үйл ажиллагаа эрхэлсэн бол “бусад” гэсэн ангилалд оруулж бичнэ.

**24. Танайх 2011 онд мод бэлтгэсэн үү?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага 2011 онд мод бэлтгэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг үргэлжлүүлнэ, мод бэлтгээгүй гэж хариулсан бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, **Асуулт 26 руу** шилжинэ.

**25. Бэлтгэсэн модны хэмжээг хэлнэ үү.** Тухайн нэгжийн бэлтгэсэн модны хэмжээ нь тухайн оны нийт дүнгээр байх ба хэмжих нэгж нь метр куб /м<sup>3</sup>/ байна.

**26. Танайх мод, сөөгний үр бэлтгэсэн үү?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас мод, сөөгний үр бэлтгэсэн эсэхийг асууж нөхнө. Тухайн аж ахуй нэгж, байгууллага 2011 онд мод, сөөгний үр бэлтгэсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг үргэлжлүүлнэ, мод, сөөгний үр бэлтгээгүй гэж хариулсан бол “Үгүй-2”-ыг дугуйлж, **Асуулт 28 руу** шилжинэ.

**27. Бэлтгэсэн мод, сөөгний нэр, үрийн хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн нэгжийн бэлтгэсэн модны үрийн хэмжээг мод, сөөгний нэрээр нь ангилж, кг-аар нөхнө.

**28. Танайх мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжтэй юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг мод үржүүлгийн болон тарьц, суулгацын хүлэмжтэй эсэхийг асууж мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжтэй гэвэл Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод үржүүлгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжгүй гэвэл Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 30 руу** шилжинэ.

**Тарьц-** Үрслүүлэх зорилгоор модны мөчрөөс тусгайлан авсан хэсэг эсвэл модны үрээр 3 хүртэл жил хөрсөнд суулгаж үрслүүлснийг тарьц гэнэ.

**Суулгац-** 3-аас дээш жил хөрсөнд суулгаж, үндэслүүлэн тарихад бэлэн болгосон тарьцыг суулгац гэнэ.

**29. Хүлэмжид байгаа мод үржүүлгийн тарьц, суулгацын талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас хүлэмжинд суулгасан модны нэр, тарьц, суулгацын тоог асууж, нөхнө.

**30. Танайх 2011 онд мод тарьсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага 2011 онд мод тарьсан эсэхийг асууж нөхнө. Мод тарьсан бол Тийм гэж 1-ийг дугуйлж, дараагийн асуулт руу шилжинэ. Мод тариагүй гэвэл Үгүй гэж 2-ыг дугуйлан **Асуулт 32 руу** шилжинэ.

**31. Тарьсан мод, суулгацын тоогоо хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас тарьсан модны тоог асууж, ширхэгээр нөхнө.

## **II. ОЙН АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ**

**32. Ойн гаралтай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ хэмжээг хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг 2011 оны байдлаар асууж нөхнө.

Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүний хэрэглээ, зарцуулалтыг өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн, бусад) хүснэгтэд нэр заан өгсөн ойн гаралтай бүтээгдэхүүний нэр төрлөөр асууж бүртгэнэ. Нийт үйлдвэрлэлт нь өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлс, урамшуулалд олгосон, нөөцөлсөн болон бусад хэлбэрээр хэрэглэсэн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна.

Ойгоос бэлтгэсэн бүтээгдэхүүнийг мод, самар, жимс, мөөг, суулгац, бусад гэсэн нэр төрлөөр бүртгэнэ.

Бүртгэхдээ хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжийг сайтар анхаарна. Хариулагч хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжээс өөрөөр хэлсэн тохиолдолд тавигдсан нэгж рүү шилжүүлэхдээ итгэлцүүрийг ашиглана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас асуух замаар, сайтар ярилцаж бүртгэнэ.

Хүснэгтэд нэр зааснаас өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бол бусдад нэрийг бичиж нөхнө.

**33. Танайх бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг вэ? (Нэгээс дээш сонголт байж болно)** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж байгааг “Хувь хүн ирж авдаг”, “Аж ахуйн нэгж, байгууллагад”, “Зах зээлд

өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Борлуулалтыг нөхөхдөө хамгийн их борлуулалт хийдэг 3-аас илүүгүй хэлбэрийг дугуйлна.

Бүтээгдэхүүнээ хөдөөд ярьж заншснаар мод, самар, жимс зэргийг өөрсдөө ирж авдаг түүхий эдийн ченжүүд болон хувь хүнд борлуулсан бол “Хувь хүн ирж авдаг”, мод, самар, жимс бэлтгэдэг компанийн төлөөлөгч өрх, хувь хүн, хоршоо зэрэгт борлуулсан бол “Аж ахуйн нэгж, байгууллагад”, сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол “Зах зээлд өөрсдөө борлуулдаг” гэсэн сонголтыг хийнэ. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол “бусад ” гэсэн ангилалд оруулна.

**34. Танай бүтээгдэхүүний борлуулалттай холбогдон гардаг хүндрэлээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад гарч байгаа хүндрэлийг “Борлуулалт удаашралтай”, “Хэрэглэгч цөөн”, “Өрсөлдөгч олон”, “Зах зээлээс алслагдсан”, “Үнэ хямд”, “Бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж нөхнө. Хүндрэлийг нөхөхдөө хамгийн их тохиолддог 3-аас илүүгүй хүндрэлийг сонгоно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**35. Танайх бүтээгдэхүүнийхээ үнийг хэрхэн тогтоодог вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ үнээ хэрхэн тогтоож байгааг “Зардал дээр ашгийг нэмэх замаар”, “Хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр”, “Өрсөлдөгчийн үнээс хамаарч”, “Зах зээлийн үнэ, ханшаар”, “ Бусад” гэсэн төрлөөр асууж нөхнө. Үнээ тогтоодог 3-аас илүүгүй аргыг дугуйлна.

### III. ОЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ

**36. Үйл ажиллагааныхаа нийт орлогыг нэр төрлөөр нь задалж хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ойн үйл ажиллагаанаас олсон орлогыг нийт болон үндсэн үйл ажиллагааны, түрээсийн, бусад орлого гэсэн төрлөөр асууж бүртгэнэ. Нийт орлого нь үндсэн үйл ажиллагаа, түрээс, бусад орлогын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

**37. Үйл ажиллагааныхаа нийт зардлыг нэр төрлөөр нь задалж хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ойн үйл ажиллагаандаа зарцуулсан зардлыг дурдсан ангиллын дагуу асууж, бүртгэнэ.

### IV. ГАЗАР, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

**38. Танайх өөрийн өмчлөлийн газартай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн өмчлөлийн газартай эсэхийг асууж газартай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, газаргүй бол Үгүй гэж 2–ыг дугуйлж, **Асуулт 44 рүү** шилжинэ.

**39. Газрын үнэлгээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын газрын үнэлгээг асууж, сая төгрөгөөр нөхнө.

**40. Газрын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж авсан захиран зарцуулах эрх бүхий газрын хэмжээг асууж нөхнө. Хэмжээг га-гаар илэрхийлнэ.

Га-д шилжүүлэхдээ дараах итгэлцүүрийг ашиглана:

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000м <sup>2</sup>	=	1 га

**43. Танайх ойн аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжтэй юу?**  
Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг ойн аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй эсэхийг асууж машин, тоног төхөөрөмжтэй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, машин тоног төхөөрөмжгүй бол Үгүй гэж 2-ыг дугуйлж, асуулгыг дуусгана.

**44. Машин, тоног төхөөрөмжийнхөө талаарх мэдээллийг хэлнэ үү.** Машин, тоног төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн машин болон түрээслэн ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоо, төрөл тус бүрээр нь нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжид** өөрийн, хамтын эзэмшлийнх болгосон эсвэл зээл болон лизингээр худалдаж авсан машин, тоног төхөөрөмжийг оруулна.

**Түрээсэлсэн машин, тоног төхөөрөмжид** төрийн байгууллагаас болон бусдаас түрээсэлсэн, төлбөртэй болон төлбөргүйгээр зээлж ашигласныг энд оруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанд** тухайн машин, тоног төхөөрөмжийг худалдаж авснаас хойш хэдэн жил болж байгаа хугацааг бүтэн жилээр илэрхийлж, нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг** бүртгэхдээ тухайн аж ахуйн нэгж, байгууллагын балансын үнээр бүртгэнэ. Үнийн дүнг **мянган төгрөгөөр** илэрхийлнэ.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийг дараах жагсаалтаас харж, хүснэгтэд тохирох кодыг тавина.

**Машин, тоног төхөөрөмжийн код:**

<i>Ачааны машин</i>	01	<i>Морин тэрэг</i>	06	<i>Сүх</i>	10	<i>Хувин</i>	14
<i>Бага оврын трактор</i>	02	<i>Мотоцикл</i>	07	<i>Тэмээн тэрэг</i>	11	<i>Цахилгаан хөрөө</i>	15
<i>Бензин моторт хөрөө</i>	03	<i>Пресслэгч машин</i>	08	<i>Үхэр тэрэг</i>	12	<i>Чиргүүл</i>	16
<i>Гар хөрөө</i>	04	<i>Суудлын машин</i>	09	<i>Хаман боогч</i>	13	<i>Шуудай</i>	17
<i>Гинжит трактор</i>	05						

## **БҮЛЭГ VIII. АН АГНУУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР**

Ан агнуурын тооллогод ан агнуурын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна.

Асуулга нь ерөнхий мэдээллийн болон үндсэн 4 бүлэг асуултаас бүрдэнэ.

- I. Ерөнхий мэдээлэл
- II. Ан амьтны гаралтай түүхий эдийн үйлдвэрлэлт, борлуулалт
- III. Ан агнуурын үйл ажиллагааны орлого, зардал
- IV. Газар, машин, тоног төхөөрөмж

### **I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

#### **I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ**

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын

дугаарыг бичнэ. Тооллогын комиссын дугаарыг хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харна. Уг дугаар нь ХАА-н ам орон, сууцны тооллогод ашигласан дугаартай ижил байна.

**2. Аймаг, нийслэлийн нэр, код.** Энэ асуултад тухайн аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”–оос харж нөхнө.

**3. Сум, дүүргийн нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”–оос харж нөхнө.

**4. Баг, хорооны нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”–оос харж нөхнө.

**5. Тоологчийн нэр, дугаар.** Тоологч өөрийн нэрийг эцэг/ эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө: **Тоологчийн нэр, дугаар** гэсэн мөрийн 2 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрвээ 1 оронтой дугаар бол “01” гэх мэтчилэн өмнөх оронг “0” тавьж гүйцээнэ. Тоологчийн дугаарыг өгөхдөө сум, дүүрэг дотроо 01-ээс эхлэн дугаарлана. **Жишээ нь:** тухайн сум, дүүрэгт 5 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-05 хүртэлх дугаар өгнө, 2 дугаар сум, дүүрэгт 10 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-10 хүртэлх дугаар өгнө.

**6. Тооллогын асуулгын дугаар.** Тооллогын асуулгын дугаарыг тоологч бүр тоолж эхэлсэн эхний өрхөөс эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Хэрэв тухайн тоологч 2 багт ажиллах бол асуулгын хуудсыг баг тус бүрд 1-ээс эхлэн дугаарлана.

Тоологч тооллогын асуулгын дугаарыг давхардуулан олгож болохгүй.

**7. Шалгагч, кодлогчийн нэр, дугаар:** Сумын түвшинд тоологчоос тооллогын материалыг багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч шалган хүлээж авна. Аймгийн түвшинд аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд сумдын тооллогын материалыг хүлээн авч, шалгах, кодлох ажлыг хийнэ.

Шалгагч, кодлогч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 1 оронтой дугаар бол “01” гэх ба өмнөх оронг “0” тавьж гүйцээж бичнэ. Шалгагч асуулгын хуудсыг үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон алхамыг зөв хийсэн эсэхийг хянаж, алдааг засварлана. Кодлохдоо аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, тоологч, шалгагч, гудамж, хороолол, бүсчлэл, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн зэрэг кодлолтыг хавсралтыг ашиглаж нөхнө.

**8. Шивэгчийн нэр, дугаар:** Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Шивэлтийг ҮСХ хариуцан хийх учраас шивэгч бүрт тусгайлан код олгоно.

## **1.2 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ**

**9. Аж ахуйн нэгж байгууллагын нэр.** Тухайн аж ахуйн нэгжийн нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө.

**10. Регистрийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн товчлохгүйгээр үнэн зөв нөхнө.

**11. Статистик нэгжийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын статистикийн регистрийн санд бүртгэгдсэн дугаар бөгөөд дугаарыг ҮСХ-ноос хүргүүлсэн жагсаалтаас харж тавина.

### **I.3 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭН/ДАРГА/ЗАХИРЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт тооллогод хамрагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын талаарх мэдээллийг асууж нөхнө.

**12. Эцэг (эх)-ийн нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын, эцэг (эх)-ийн нэрийг асууж, нөхнө.

**13. Нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын өөрийн нэрийг асууж, нөхнө.

**14. Хүйс.** Энэ асуулт ХАА-н үйлдвэрлэл дэх жендерийн байдлыг судлах ялангуяа, ХАА-н үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийг үнэлэх чухал үзүүлэлт болно. Энэ асуултын хариултыг нөхөхдөө аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, өрхийн тэргүүлэгчийн хүйсийг эрэгтэй гэж 1, эмэгтэй -2 гэсний аль тохирох кодыг дугуйлна.

**15. Нас (бүтэн жилээр).** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь тооллого явагдаж байгаа жилээр гүйцэд тооцож тогтооно.

**16. Боловсролын түвшин.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын боловсролын түвшинг асууж, боловсролын түвшинд тохирох кодыг сонгон дугуйлна.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол**- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/-** Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**17. Ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын ажилласан жилд тухайн хүний хөдөлмөр эрхэлж эхэлсэн үеэс судалгаа авч байгаа үе /2011 он/ хүртэлх хугацааг оруулна. Дээрх хугацаанд хөдөлмөр эрхлээгүй үе гарвал тус хугацааг ажилласан жилд оруулахгүй. Ажилласан нийт жилийг бүтэн жилээр тавина.

Үүнээс: ан агнуурын салбарт. Нийт ажилласан хугацаанаас хичнээн жилийг нь ан агнуурын салбарт ажилласныг асууж, бичнэ. Амьдралынхаа туршид зөвхөн тус салбарт ажилд орсон цагаасаа ажиллаж ирсэн бол “Ажилласан жил” нь ан агнуурын салбарт ажилласан жил”-тэй тэнцүү байна.

**18. Тухайн байгууллагын удирдлагаар ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын тухайн нэгждээ удирдлагаар ажилласан нийт жилийг асууж нөхнө.

**19. Тухайн байгууллагыг үүсгэн байгуулагчдын тоо.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг үүсгэн байгуулагчдын тоог асууж нөхнө.

#### **I.4 АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**20. Танайх 2011 онд ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг 2011 онд ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулсан эсэхийг асууж, хариултыг үйл ажиллагааны талаарх хариулттай уялдуулж шалгана.

Ан агнуурын чиглэлээр 2011 онд ямар нэгэн үйл ажиллагаа эрхэлсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, **Асуулт 22 руу** шилжинэ, ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа эрхлээгүй гэж хариулсан бол “Үгүй-2”-ыг дугуйлж, асуулгыг үргэлжлүүлнэ.

**21. Танайх 2011 онд ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаа хэлнэ үү.** Тухайн нэгж 2011 онд ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг асууж, хариултыг “Бусад ААНБ-тэй нэгдсэн”, “Үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн”, “Санхүүгийн боломжгүй байсан”, “Үйл ажиллагаагаа эхлээгүй”, “Бусад” гэсэн хариултаас сонгож нөхнө. **Бүлэг IV рүү** шилжинэ.

**22. Нийт ажиллагчдын тоо, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хүйсээр ялгаж, харгалзах нүдэнд нөхнө.

Ажиллагчдын тоонд аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, захирал нь орохгүй. Харин өрхийн гишүүд нь цалин хөлстэйгээр аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байвал ажиллагчдын тоонд оруулна.

Ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй, хүүхдийн хөдөлмөрийн тусгайлсан судалгаагаар энэ талаарх мэдээлэл цуглуулагдаж байна.

**23. Танайх ямар зориулалтаар ан хийсэн бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас ямар зориулалтаар ан хийсэн эсэхийг асууж, хариултыг нөхнө. Нэгээс дээш сонголт байж болно.

- **Ахуйн** - тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан ан агнахаар зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад төрлийн ан амьтныг агнасан бол ахуйн зориулалттай агнасан ан агнуурт хамрагдана.
- **Үйлдвэрлэлийн** - тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар зохих зөвшөөрлийн дагуу төлбөрийг төлж, ховор төрлийн амьтнаас бусад төрлийн ан амьтанг агнасан бол үйлдвэрлэлийн зориулалттай гэдэгт хамруулна.
- **Тусгай** - судалгаа, шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар, гадаадын болон Монгол Улсын иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр, сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор, спорт-агнуурын чиглэлээр хийсэн анг хамруулна.

**24. Танайх ангийн төлбөр, зөвшөөрлийн хураамжид хэдэн төгрөг төлсөн бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас ангийн төлбөр, зөвшөөрлийн хураамжид хэдэн төгрөг төлсөн эсэхийг асууж, мян. Төгрөгөөр нөхнө.

**25. 2011 онд агнасан ангийн тоогоо хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас агнасан ангийн тоог бүгд, үүнээс бор гөрөөс, зэрлэг гахай, цагаан зээр, загас, чоно, хярс, хар хур, нутгийн сойр, шивэр хөтүү, дагуурын ятуу, бусад амьтны төрлөөр нь ангилж, толгойн тоогоор нөхнө.

## II. АН АМЬТНЫ ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ

**26. Ан агнуурын гаралтай түүхий эдийн талаарх мэдээллээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг 2011 оны байдлаар асууж нөхнө.

Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүний хэрэглээ, зарцуулалтыг өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн, бусад) хүснэгтэд нэр заан өгсөн ойн гаралтай бүтээгдэхүүний нэр төрлөөр асууж бүртгэнэ. Нийт үйлдвэрлэлт нь өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлс, урамшуулалд олгосон, нөөцөлсөн болон бусад хэлбэрээр хэрэглэсэн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна.

Ан агнуурын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд дараах нэр төрлийг хамруулна.

- Бор гөрөөсний мах	- Чонын арьс	- Бусад 1 (бичих)
- Зэрлэг гахайн мах	- Зээрийн арьс	- Бусад 2 (бичих)
- Цагаан зээрийн мах	- Зэрлэг гахайн соёо	- Бусад 3 (бичих)
- Чонын мах	- Бугын эвэр	

- Шувууны мах		
---------------	--	--

Бүртгэхдээ хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжийг сайтар анхаарна. Хариулагч хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжээс өөрөөр хэлсэн тохиолдолд тавигдсан нэгж рүү шилжүүлэхдээ итгэлцүүрийг ашиглана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас асуух замаар, сайтар ярилцаж бүртгэнэ.

Хүснэгтэд нэр зааснаас өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бол бусдад нэрийг бичиж нөхнө.

**27. Танайх бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг вэ? (Нэгээс дээш сонголт байж болно)** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж байгааг “Хувь хүн ирж авдаг”, “Аж ахуйн нэгж, байгууллагад”, “Зах зээлд өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Борлуулалтыг нөхөхдөө хамгийн их борлуулалт хийдэг 3-аас илүүгүй хэлбэрийг дугуйлна.

Бүтээгдэхүүнээ хөдөөд ярьж заншснаар ангийн мах, арьс зэргийг өөрсдөө ирж авдаг түүхий эдийн ченжүүд болон хувь хүнд борлуулсан бол “Хувь хүн ирж авдаг”, ангийн мах, арьс бэлтгэдэг компанийн төлөөлөгч өрх, хувь хүн, хоршоо зэрэгт борлуулсан бол “Аж ахуйн нэгж, байгууллагад”, сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол “Зах зээлд өөрсдөө борлуулдаг” гэсэн сонголтыг хийнэ. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол “бусад ” гэсэн ангилалд оруулна.

**28. Танайх бүтээгдэхүүний борлуулалттай холбогдон гардаг хүндрэлээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад гарч байгаа хүндрэлийг “Борлуулалт удаашралтай”, “Хэрэглэгч цөөн”, “Өрсөлдөгч олон”, “Зах зээлээс алслагдсан”, “Үнэ хямд”, “Бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж нөхнө. Хүндрэлийг нөхөхдөө хамгийн их тохиолддог 3-аас илүүгүй хүндрэлийг сонгоно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**29. Танайх бүтээгдэхүүнийхээ үнийг хэрхэн тогтоодог вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ үнээ хэрхэн тогтоож байгааг “Зардал дээр ашгийг нэмэх замаар”, “Хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр”, “Өрсөлдөгчийн үнээс хамаарч”, “Зах зээлийн үнэ, ханшаар”, “Бусад” гэсэн төрлөөр асууж нөхнө. Үнээ тогтоодог 3-аас илүүгүй аргыг дугуйлна.

### III. АН АГНУУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ

**30. Үйл ажиллагааныхаа нийт орлогыг нэр төрлөөр нь задалж хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ан агнуурын үйл ажиллагаанаас олсон орлогыг нийт болон үндсэн үйл ажиллагааны, түрээсийн, бусад орлого гэсэн төрлөөр асууж бүртгэнэ. Нийт орлого нь үндсэн үйл ажиллагаа, түрээс, бусад орлогын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

**31. Ан агнах, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлыг нэр төрлөөр нь задалж хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас 2011 онд ан агнах, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нийт хэдий хэмжээний зардал гарсныг ангийн сэлбэг хэрэгсэл, сумны зардал, түлш, шатахуун, түрээс, тээвэр, цалин, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад гэсэн төрлөөр нь задалж, мянган төгрөгөөр тооцож нөхнө.

#### IV. ГАЗАР, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

**32. Танайх өөрийн өмчлөлийн газартай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн өмчлөлийн газартай эсэхийг асууж газартай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, газаргүй бол Үгүй гэж 2–ыг дугуйлж, **Асуулт 35 руу** шилжинэ.

**33. Газрын үнэлгээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын газрын үнэлгээг асууж, сая төгрөгөөр нөхнө.

**34. Газрын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж авсан захиран зарцуулах эрх бүхий газрын хэмжээг асууж нөхнө. Хэмжээг га-гаар илэрхийлнэ.

Га-д шилжүүлэхдээ дараах итгэлцүүрийг ашиглана:

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сом	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сом	=	10000м <sup>2</sup>	=	1 га

**35. Танайх ан агнуурын зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас ан агнуурын зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй эсэхийг асууж машин тоног төхөөрөмжтэй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, машин тоног төхөөрөмжгүй бол Үгүй гэж 2–ыг дугуйлж, асуулгыг дуусгана.

**36. Машин, тоног төхөөрөмжийнхөө талаарх мэдээллээ хэлнэ үү.** Машин тоног, төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн тоо, түрээслэн ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоог төрөл тус бүрээр нь нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжид** өөрийн, хамтын эзэмшлийнх болгосон эсвэл зээл болон лизингээр худалдаж авсан машин, тоног төхөөрөмжийг оруулна.

**Түрээсэлсэн машин, тоног төхөөрөмжид** төрийн байгууллагаас болон бусдаас түрээсэлсэн, төлбөртэй болон төлбөргүйгээр зээлж ашигласныг энд оруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанд** тухайн машин, тоног төхөөрөмжийг худалдаж авснаас хойш хэдэн жил болж байгаа хугацааг бүтэн жилээр илэрхийлж, нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг бүртгэхдээ** тухайн аж ахуйн нэгж, байгууллагын балансын үнээр бүртгэнэ. Үнийн дүнг **мянган төгрөгөөр** илэрхийлнэ.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийг дараах жагсаалтаас харж, хүснэгтэд тохирох кодыг тавина.

**Машин, тоног төхөөрөмжийн код:**

Ачааны машин	01	Завь	05	Мотоцикл	09	Тэмээн тэрэг	13
Буу	02	Загасны тор	06	Сал	10	Үхэр тэрэг	14
Гэрэлтүүлэг	03	Загасны уурга	07	Сум	11	Хавх	15
Дуран	04	Морин тэрэг	08	Суудлын машин	12	Бусад	16

## **БҮЛЭГ IX. ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР**

Загасны аж ахуйн тооллогод загасны аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна.

Асуулга нь ерөнхий мэдээллийн болон үндсэн 4 бүлэг асуултаас бүрдэнэ.

- I. Ерөнхий мэдээлэл
- II. Загасны гаралтай түүхий эдийн үйлдвэрлэлт, борлуулалт
- III. Загасны аж ахуйн үйл ажиллагааны орлого, зардал
- IV. Газар, машин, тоног төхөөрөмж

### **I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

#### **I.1 ХАЯГИЙН ХЭСЭГ**

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дугаарыг бичнэ. Тооллогын комиссын дугаарыг хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” –оос харна. Уг дугаар нь ХАА-н ам орон, сууцны тооллогод ашигласан дугаартай ижил байна.

**2. Аймаг, нийслэлийн нэр, код.** Энэ асуултад тухайн аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”–оос харж нөхнө.

**3. Сум, дүүргийн нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”–оос харж нөхнө.

**4. Баг, хорооны нэр, код.** Энэ асуултад тухайн сум, дүүргийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, холбогдох кодыг Хавсралт 1 буюу “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”–оос харж нөхнө.

**5. Тоологчийн нэр, дугаар.** Тоологч өөрийн нэрийг эцэг/ эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө: **Тоологчийн нэр, дугаар** гэсэн мөрийн 2 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрвээ 1 оронтой дугаар бол “01” гэх мэтчилэн өмнөх оронг “0” тавьж гүйцээнэ. Тоологчийн дугаарыг өгөхдөө сум, дүүрэг дотроо 1-ээс эхлэн дугаарлана. **Жишээ нь:** тухайн сум, дүүрэгт 5 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-05 хүртэлх дугаар өгнө, 2 дугаар сум, дүүрэгт 10 тоологч ажиллана гэвэл тоологч нарт 01-10 хүртэлх дугаар өгнө.

**6. Тооллогын асуулгын дугаар.** Тооллогын асуулгын дугаарыг тоологч бүр тоолж эхэлсэн эхний өрхөөс эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Хэрэв тухайн тоологч 2 багт ажиллах бол асуулгын хуудсыг баг тус бүрд 1-ээс эхлэн дугаарлана.

Тоологч тооллогын асуулгын дугаарыг давхардуулан олгож болохгүй.

**7. Шалгагч, кодлогчийн нэр, дугаар:** Сумын түвшинд тоологчоос тооллогын материалыг багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч шалган хүлээж авна. Аймгийн

түвшинд аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд сумдын тооллогын материалыг хүлээн авч, шалгах, кодлох ажлыг хийнэ.

Шалгагч, кодлогч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 1 оронтой дугаар бол "01" гэх ба өмнөх оронг "0" тавьж гүйцээж бичнэ. Шалгагч асуулгын хуудсыг үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон алхамыг зөв хийсэн эсэхийг хянаж, алдааг засварлана. Кодлохдоо аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, тоологч, шалгагч, гудамж, хороолол, бүсчлэл, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн зэрэг кодлолтыг хавсралтыг ашиглаж нөхнө.

**8. Шивэгчийн нэр, дугаар:** Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Шивэлтийг ҮСХ хариуцан хийх учраас шивэгч бүрт тусгайлан код олгоно.

## **1.2 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ**

**9. Аж ахуйн нэгж байгууллагын нэр.** Тухайн аж ахуйн нэгжийн нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө.

**10. Регистрийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн товчлохгүйгээр үнэн зөв нөхнө.

**11. Статистик нэгжийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын статистикийн регистрийн санд бүртгэгдсэн дугаар бөгөөд дугаарыг ҮСХ-ноос хүргүүлсэн жагсаалтаас харж тавина.

## **1.3 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭН/ДАРГА/ЗАХИРЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт тооллогод хамрагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын талаарх мэдээллийг асууж нөхнө.

**12. Эцэг (эх)-ийн нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын, эцэг (эх)-ийн нэрийг асууж, нөхнө.

**13. Нэр.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын өөрийн нэрийг асууж, нөхнө.

**14. Хүйс.** Энэ асуулт ХАА-н үйлдвэрлэл дэх жендерийн байдлыг судлах ялангуяа, ХАА-н үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийг үнэлэх чухал үзүүлэлт болно. Энэ асуултын хариултыг нөхөхдөө аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, ерхийн тэргүүлэгчийн хүйсийг эрэгтэй гэж 1, эмэгтэй -2 гэсний аль тохирох кодыг дугуйлна.

**15. Нас (бүтэн жилээр).** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь тооллого явагдаж байгаа жилээр гүйцэд тооцож тогтооно.

**16. Боловсролын түвшин.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын боловсролын түвшинг асууж, боловсролын түвшинд тохирох кодыг сонгон дугуйлна.

**Боловсролгүй** - Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг /2005 оноос хойш/ төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5

дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3/4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана. Хариулагч “боловсролтой” гэж хариулбал боловсролын хамгийн дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг бичнэ.

**Бага боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**Суурь боловсрол** - Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.

**Бүрэн дунд боловсрол** - Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.

**Техникийн болон мэргэжлийн боловсрол**- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**Тусгай мэргэжлийн дунд боловсрол** - Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

**Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/-** Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

**17. Ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын ажилласан жилд тухайн хүний хөдөлмөр эрхэлж эхэлсэн үеэс судалгаа авч байгаа үе /2011 он/ хүртэлх хугацааг оруулна. Дээрх хугацаанд хөдөлмөр эрхлээгүй үе гарвал тус хугацааг ажилласан жилд оруулахгүй. Ажилласан нийт жилийг бүтэн жилээр тавина.

Үүнээс: загасны аж ахуйн салбарт. Нийт ажилласан хугацаанаас хичнээн жилийг нь загасны аж ахуйн салбарт ажилласныг асууж, бичнэ. Амьдралынхаа туршид зөвхөн тус салбарт ажилд орсон цагаасаа ажиллаж ирсэн бол “Ажилласан жил” нь загасны аж ахуйн салбарт ажилласан жил”-тэй тэнцүү байна.

**18. Тухайн байгууллагын удирдлагаар ажилласан жил.** Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага (эзэн, дарга, захирал)-ын тухайн нэгждээ удирдлагаар ажилласан нийт жилийг асууж нөхнө.

**19. Тухайн байгууллагыг үүсгэн байгуулагчдын тоо.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг үүсгэн байгуулагчдын тоог асууж нөхнө.

#### **1.4 АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**20. Танайх 2011 онд загасны аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан уу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг 2011 онд ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа

явуулсан эсэхийг асууж, хариултыг үйл ажиллагааны талаарх хариулттай уялдуулж шалгана.

Загасны аж ахуйн чиглэлээр 2011 онд ямар нэгэн үйл ажиллагаа эрхэлсэн бол Тийм гэж 1-ийг дугуйлж, **Асуулт 22 руу** шилжинэ, загасны аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлээгүй гэж хариулсан бол “Үгүй-2”-ыг дугуйлж, асуулгыг үргэлжлүүлнэ.

**21. Танайх 2011 онд загасны аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаа хэлнэ үү.** Тухайн нэгж 2011 онд загасны аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг асууж, хариултыг “Үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн”, “Бусад ААНБ-тэй нэгдсэн”, “Санхүүгийн боломжгүй”, “Бусад” гэсэн хариултаас сонгож нөхнө. **БҮЛЭГ IV** рүү шилжинэ.

**22. Нийт ажиллагчдын тоо, хүйсээр, 2011 оны жилийн эцэст.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоог 2011 оны жилийн эцсийн байдлаар хүйсээр ялгаж, харгалзах нүдэнд нөхнө.

Ажиллагчдын тоонд аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, захирал нь орохгүй. Харин өрхийн гишүүд нь цалин хөлстэйгээр аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байвал ажиллагчдын тоонд оруулна.

Ажиллагчдын тоонд 15 хүртэлх насны хүүхдийг оруулахгүй, хүүхдийн хөдөлмөрийн тусгайлсан судалгаагаар энэ талаарх мэдээлэл цуглуулагдаж байна.

**23. Танайх ямар зориулалтаар загас барьсан бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас ямар зориулалтаар загасны барьсан эсэхийг асууж, хариултыг нөхнө. Нэгээс дээш сонголт байж болно.

**Ахуйн** - тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан загас барихаар зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу ховор загаснаас бусад загас барьсан бол ахуйн зориулалтад хамрагдана.

**Үйлдвэрлэлийн** - тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар (загас загасан бүтээгдэхүүн болон тос, консерв, махан таташ гэх мэт) зохих зөвшөөрлийн дагуу төлбөрийг төлж, ховор төрлийн загаснаас бусад төрлийн загас барьсан бол үйлдвэрлэлийн зориулалттай гэдэгт хамруулна.

**Тусгай** - судалгаа, шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар, гадаадын болон Монгол Улсын иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр, сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор, спорт-агнуурын чиглэлээр загас барьсан бол тусгай зориулалтад хамруулна.

**24. Танайх загас зөвшөөрлийн хураамжид хэдэн төгрөг төлсөн бэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас загас барих зөвшөөрлийн хураамжид хэдэн төгрөг төлсөн эсэхийг асууж, мянган төгрөгөөр нөхнө.

**25. Танайх 2011 онд нийт барьсан загасныхаа хэмжээг хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас барьсан загасны тоог бүгд, үүнээс цагаан загас, алгана загас, омуль загас, зарам загас, тул загас, сугас, цурхай, бусад гэсэн төрлөөр нь ангилж, кг-аар нөхнө.

## **V. ЗАГАСНЫ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ**

**26. Загасны аж ахуйн гаралтай 2011 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ мэдээллээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг 2011 оны байдлаар асууж нөхнө. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүний

хэрэглээ, зарцуулалтыг өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн, бусад) хүснэгтэд нэр заан өгсөн загасны гаралтай бүтээгдэхүүний нэр төрлөөр асууж бүртгэнэ. Нийт үйлдвэрлэлт нь өөртөө хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлс, урамшуулалд олгосон, нөөцөлсөн болон бусад хэлбэрээр хэрэглэсэн бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцүү байна.

Загасны гаралтай бүтээгдэхүүнд түүхий загас, утсан загас, хатаасан загас, загасны нөөш, загасны тос, бусад гэсэн нэр төрлөөр бүртгэнэ.

Бүртгэхдээ хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжийг сайтар анхаарна. Хариулагч хүснэгтэд тавигдсан хэмжих нэгжээс өөрөөр хэлсэн тохиолдолд тавигдсан нэгж рүү шилжүүлэхдээ итгэлцүүрийг ашиглана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас асуух замаар, сайтар ярилцаж бүртгэнэ.

Хүснэгтэд нэр зааснаас өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бол бусдад нэрийг бичиж нөхнө.

**27. Танайх бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг вэ? (Нэгээс дээш сонголт байж болно)** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж байгааг “Хувь хүн ирж авдаг”, “Аж ахуйн нэгж, байгууллагад”, “Зах зээлд өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар асууж нөхнө. Борлуулалтыг нөхөхдөө хамгийн их борлуулалт хийдэг 3-аас илүүгүй хэлбэрийг дугуйлна.

Бүтээгдэхүүнээ хөдөөд ярьж занснаар загас, загасны гаралтай бүтээгдэхүүнийг өөрсдөө ирж авдаг түүхий эдийн ченжүүд болон хувь хүнд борлуулсан бол “Хувь хүн ирж авдаг”, загас, загасны гаралтай бүтээгдэхүүнийг бэлтгэдэг компанийн төлөөлөгч өрх, хувь хүн, хоршоо зэрэгт борлуулсан бол “Аж ахуйн нэгж, байгууллагад”, сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол “Зах зээлд өөрсдөө борлуулдаг” гэсэн сонголтыг хийнэ. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол “бусад” гэсэн ангилалд оруулна.

**28. Танай бүтээгдэхүүний борлуулалттай холбогдон гардаг хүндрэлээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад гарч байгаа хүндрэлийг “Борлуулалт удаашралтай”, “Хэрэглэгч цөөн”, “Өрсөлдөгч олон”, “Зах зээлээс алслагдсан”, “Үнэ хямд”, “Бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай”, “Бусад” гэсэн хэлбэрээр асууж нөхнө. Хүндрэлийг нөхөхдөө хамгийн их тохиолддог 3-аас илүүгүй хүндрэлийг сонгоно. Бусад тохиолдол байвал нөхөж бичнэ.

**29. Танайх бүтээгдэхүүнийхээ үнийг хэрхэн тогтоодог вэ?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ үнээ хэрхэн тогтоож байгааг “Зардал дээр ашгийг нэмэх замаар”, “Хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр”, “Өрсөлдөгчийн үнээс хамаарч”, “Зах зээлийн үнэ, ханшаар”, “Бусад” гэсэн төрлөөр асууж нөхнө. Үнээ тогтоодог 3-аас илүүгүй аргыг дугуйлна.

## **VI. ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ**

**27. Үйл ажиллагааныхаа нийт орлогыг нэр төрлөөр нь задалж хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын загасны үйл ажиллагаанаас олсон орлогыг нийт болон үндсэн үйл ажиллагааны, түрээсийн, бусад орлого гэсэн төрлөөр асууж бүртгэнэ. Нийт орлого нь үндсэн үйл ажиллагаа, түрээс, бусад орлогын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

**28. Загас барих, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлыг нэр төрлөөр задалж хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас 2011 онд загас барих болон бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нийт хэдий хэмжээний зардал гарсан болон цалин,

загасны өгөөш, загасны хэрэгсэл, түлш, шатахуун, түрээс, тээвэр, түүнтэй адилтгах орлого, байгалийн нөөц ашигласны төлбөр, бусад зардалд хэдий хэмжээний төгрөг зарцуулсныг асууж, мянган төгрөгөөр тооцож нөхнө.

## VII. ГАЗАР, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

**32. Танайх өөрийн өмчлөлийн газартай юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн өмчлөлийн газартай эсэхийг асууж газартай бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, газаргүй бол Үгүй гэж 2–ыг дугуйлж, **Асуулт 35 руу** шилжинэ.

**33. Газрын үнэлгээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын газрын үнэлгээг асууж, сая төгрөгөөр нөхнө.

**34. Газрын хэмжээгээ хэлнэ үү.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж авсан захиран зарцуулах эрх бүхий газрын хэмжээг асууж нөхнө. Хэмжээг га-гаар илэрхийлнэ.

Га-д шилжүүлэхдээ дараах итгэлцүүрийг ашиглана:

1 га	=	10000м <sup>2</sup>	=	100м*100м
1 сот	=	100м <sup>2</sup>	=	10м*10м
100 сот	=	10000м <sup>2</sup>	=	1 га

**35. Танайх ойн аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй юу?** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг загасны аж ахуйн зориулалтын машин, тоног төхөөрөмжтэй эсэхийг асууж машин тоног төхөөрөмжтэй бол Тийм гэж 1-ийг дугуйлж, асуулгыг дарааллын дагуу үргэлжлүүлнэ, машин тоног төхөөрөмжгүй бол Үгүй гэж 2–ыг дугуйлж, **асуулгыг дуусгана.**

**36. Машин, тоног төхөөрөмжийнхөө талаарх мэдээллээ хэлнэ үү.** Машин тоног, төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн тоо, түрээслэн ашигласан машин, тоног төхөөрөмжийн тоог төрөл тус бүрээр нь нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжид** өөрийн, хамтын эзэмшлийнх болгосон эсвэл зээл болон лизингээр худалдаж авсан машин, тоног төхөөрөмжийг оруулна.

**Түрээсэлсэн машин, тоног төхөөрөмжид** төрийн байгууллагаас болон бусдаас түрээсэлсэн, төлбөртэй болон төлбөргүйгээр зээлж ашигласныг энд оруулна.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанд** тухайн машин, тоног төхөөрөмжийг худалдаж авснаас хойш хэдэн жил болж байгаа хугацааг бүтэн жилээр илэрхийлж, нөхнө.

**Өөрийн эзэмшлийн машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг бүртгэхдээ** тухайн аж ахуйн нэгж, байгууллагын балансын үнээр бүртгэнэ. Үнийн дүнг **мянган төгрөгөөр** илэрхийлнэ.

Тухайн байгууллагын ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийг дараах жагсаалтаас харж, хүснэгтэд тохирох кодыг тавина.

### **Машин, тоног төхөөрөмжийн код:**

Ачааны машин	01	Завь	04	Морин тэрэг	07	Суудлын машин	10
Гэрэлтүүлэг	02	Загасны тор	05	Мотоцикл	08	Үхэр тэрэг	11

Дээгээ	03	Загасны уурга	06	Сал	09	Хаалт	12
						Бусад	13

## БҮЛЭГ Х. ЗАСАГ ЗАХИРГААНЫ АНХАН ШАТНЫ НЭГЖИЙН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР

Засаг захиргааны анхан шатны нэгжийн судалгааны маягтыг сумын түвшинд нөхөх бөгөөд төрийн сангийн төлөөлөгч нь эрх бүхий албан тушаалтнаар гаргуулан авна.

Уг судалгаа нь анхан шатны нэгжийн түвшин дэх байгаль орчин, нийгэм эдийн засгийн байдлыг тодорхойлж, эдгээрийн хөгжилд нөлөө үзүүлж байгаа дэд бүтэц, үйлчилгээний салбарын хөгжил, байгалийн бэрхшээлийн нөлөөллийг тодорхойлон гаргахад чиглэнэ.

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байршлын бүртгэлийн хэсэг нь газарзүйн мэдээллийн системээр тооллогын үр дүнгийн тайланг гаргах болон мэдээллийг бусад эх үүсвэртэй холбоход ашиглана.

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн, хүн ам орон сууцны тооллогод ашигласан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дугаарыг нөхнө.

**2. Аймгийн нэр, код.** Тухайн аймгийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, кодыг энэ зааврын “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” Хавсралт 1-ээс харж, холбогдох кодыг арын дөрвөлжин нүдэнд нөхнө.

**3. Сумын нэр, код.** Тухайн сумын албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, кодыг энэ зааврын “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код” Хавсралт 1-ээс харж, холбогдох кодыг арын дөрвөлжин нүдэнд нөхнө.

**4. Асуулга өгсөн хүний овог, нэр.** Асуулгыг нөхсөн хүний нэрийн овгийн эхний үсгийн хамт бичнэ.

**5. Асуулга өгсөн хүний албан тушаал.** Асуулгыг нөхсөн хүний албан тушаалыг бичнэ.

### II. ГАЗАР ЗҮЙ, БАЙГАЛЬ ОРЧИН

**6. Сумынхаа байрлаж байгаа байгалийн бүсийг тодорхойлно уу?** Сумынхаа байрлаж байгаа байгалийн бүсийг маягтад тусгасан ангиллын дагуу нөхнө. Байгалийн бүсийг тодорхойлохдоо сумын байгаль орчин, газар, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнээс зөвлөгөө заавар авна.

**7. Сумынхаа хөрсний төрлийг тодорхойлно уу.** Тухайн сумын байрлаж байгаа байгалийн бүсийг маягтад тусгасны дагуу элсэрхэг, шаварлаг, хар шороон, хүрэн шороон гэсэн ангиллаар ялган бүртгэнэ. Хөрсний төрлийг тодорхойлохдоо сумын байгаль орчин, газар, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнээс зөвлөгөө заавар авна.

**8. Сумын ХАА-н эдэлбэр газрын хэмжээ, га.** ХАА-н эдэлбэр газрын хэмжээг 2011 оны байдлаар, маягтад заасан ангиллын дагуу сумын дүнгээр нөхөх бөгөөд ХАА-н эдэлбэр газрын хэмжээг газрын нэгдмэл сангийн тайлангаас нөхнө. ХАА-н эдэлбэр газрын хэмжээг нөхөхдөө сумын газрын байцаагчаас туслалцаа, зөвлөгөө авна.

### III. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

**9. Сумын өрхийн тоо, 2011 оны байдлаар.** Өрхийн тоог сумын дүнгээр, 2011 оны байдлаар нөхнө.

**10. Сумын эдийн засгийн голлох салбар.** Маягтад заасан ангиллын дагуу тухай сумын хэмжээнд голлон эрхэлж байгаа үйл ажиллагааг нөхөх бөгөөд хамгийн голоос нь дараалуулан сонголт хийнэ. Бусад гэсэн үйл ажиллагаанд барилга, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо зэрэг үйл ажиллагаа орно.

**11. Тухайн сум төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдсон эсэх.** Сум нь цахилгаан станц буюу өндөр хүчдэлийн цахилгаан хангамжид холбогдсон бол тийм, харин дизель болон бусад төрлийн хангамжтай бол үгүй гэж хариулна.

**12. Сумын төвөөс өөрийн аймгийн төв хүрэх замын төрөл.** Сумаас төвлөрсөн хот, сууринд хүрэх замын төрлийг маягтад заасан автозамын ангиллын дагуу дараахь тодорхойлолтыг сайтар харгалзан нөхнө. Нэгээс дээш сонголт хийж болно.

- **Хатуу хучилттай** /цемент, асфальт, хөнгөвчилсэн хар зам/
- **Хайрган зам** /засч, сайжруулсан хөрсөн зам дээр хайрга, чулуу асгаж нягтруулсан/
- **Сайжруулсан хөрсөн зам** /энгийн хөрсөн замыг тэгшлэн, засч, нягтруулсан/
- **Энгийн шороон зам буюу ердийн хөрсөн зам** /хээрийн зам/

**13. Сумын усан хангамжийн байдал.** Сумын усан хангамжийн байдлыг төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, хамгаалагдсан худаг, хамгаалагдсан булаг, шанд төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдаагүй булаг, шанд, зөөврийн ус, Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, задгай ус гэсэн ангиллаар ялган, бүртгэнэ. Нэгээс дээш сонголт хийж болно.

### IV. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

**14. Боловсрол, соёл, үйлчилгээний байгууллагын тоо.** Тухайн сумын иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын тоог маягтад заасан ангиллын дагуу гаргаж, 2011 оны байдлаар нөхнө.

**15. Сумын түвшинд ХАА-н чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа цэг, нэгжийн тоо.** Маягтад заасан ангиллын дагуу 2011 оны байдлаар нөхнө. ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэг гэдэгт ноос, арьс, шир, цагаан идээ, сүү зэргийг борлуулах тусгайлсан цэгийг, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах агуулахад үр тариа, өвсний агуулахыг, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах зооринд төмс, хүнсний ногоо, махны зоорийг, ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах цэг, үйлдвэрт ноос, арьс, шир, цагаан идээ, сүү, жимс, жимсгэнэ боловсруулах цэг, үйлдвэрийг тус тус оруулна.

### V. ХАА-Н ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

**17. ХАА-н чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, тоогоор.** Тухайн суманд засгийн газар, (тухайлбал ХХААХҮЯ, БОАЖЯ), олон улсын байгууллага, (НҮБ, Дэлхийн банкны харьяа байгууллагууд), төрийн бус байгууллага, бусад (хувь хүн, УИХ-ын гишүүн) зэргээс иргэд, орон нутаг, байгаль орчин зэргийг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн тоог 2011 оны байдлаар нөхнө.

## VI.БУСАД

**17.Малчид, газар тариаланчдын бүлгийн тоо.** Сумын хэмжээнд бүртгэгдсэн малчид, газар тариаланчдын бүлгийн тоог нөхнө.

**18.Байгалийн гамшигт өртсөн байдал, оноор, (оныг сонгон тэмдэглэнэ).** Тухайн сум байгалийн гамшигт буюу ган, зудад өртсөн байдлыг сүүлийн 10 жилээр нөхнө. Ган, зудад өртсөн оныг сонгон тэмдэглэнэ.

## БҮЛЭГ IX. ГАЗРЫН ЗУРАГ АШИГЛАХ ЗААВАР

### 1. Тоологчийн газрын зургийг ашиглах зорилго

1. Тооллогын нэгж<sup>1</sup> -ийн байршлыг тодорхойлох;
2. Тооллогын нэгжийг тооллогод бүрэн хамруулах;
3. Тооллогын нэгжийн хамрагдалтыг шалгах, хянах;

### 2. Ач холбогдол

1. Тооллогын нэгжийн байршлыг нарийн тодорхойлох;
2. Тоологч өөрийн хариуцах тооллогын нутаг дэвсгэрийн нэгж<sup>2</sup> -ийн тооллогын нэгжийн хамрагдалтыг хянах;
3. Тоологч өдөр бүрийн тоолох ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тооллого хийх нутаг дэвсгэрийнхээ хаанаас эхэлж хаагуур явах маршрутаа тогтоох;

### 3. Гар зургийг бэлтгэх заавар

1. Тоологч гар зургаа бэлтгэхдээ сум, хорооны тооллогын комисс (цаашид комисс гэх)-ын удирдлага, заавар, зөвлөгөөгөөр ажиллана.
2. Гар зургийн зөвхөн төв суурин газарт буюу нийслэл, аймаг, сумын төв, тосгоны газрын зураг (кадастрын зураг) -т үндэслэн үйлдэнэ. Хөдөөгийн газрын зураг (байрзүйн зураг) ашиглахдаа гар зураг үйлдэхгүй.
3. Комисс тоологчийг гар зургаа бэлтгэхийн өмнө тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хилийг тодорхойлон, тоологчоор хуваарилсан байна. Тоологч комиссын хуваарилсан газрын зургийг үндэслэн өөрийн гар зургийг үйлдэнэ.
4. Зургийг АЗ хэмжээтэй цаас дээр тоологч өөрөө, гараар зурна.
5. Тоологч өөрт хуваарилагдсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хил бүхий газрын зургийг сайтар ажиглаж, АЗ цаас дээр байгаа хэмжээгээрээ багтах эсэх, томсгож эсвэл багасгаж зурах, АЗ цаасаа босоо болон хөндлөн байрлалын алинаар нь зурахаа тодорхойлно.
6. Комиссоос тоологчид хуваарилсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн газрын зургийн хэлбэрээс хамаарч, тоологч АЗ цаасыг босоо, эсвэл хөндлөн хэлбэрээр гар зургаа үйлдэх бөгөөд үүнээс хамаарч зургийн үндсэн агуулга<sup>3</sup> -ын байрлал дараах 2 төрөлтэй байна.


<sup>1</sup> Тооллогын нэгж гэж тооллогод хамрагдах газар тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг,

<sup>2</sup> Тооллогын нутаг дэвсгэрийн нэгж гэж нэг тоологчийн хариуцаж тоолох тооллогын нэгжийн харьяалагдах нутаг дэвсгэрийг ойлгоно.

<sup>3</sup> Газрын зургийн үндсэн агуулга гэж хаяг, баталгаажуулалтын хэсэг, гар зургийн хэсэг, таних тэмдэг шалгалтын хэсгийг хэлнэ.

Газрын зураг дээрх өөрт хуваарилагдсан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хил бүхий зураг нь хөндлөн эсвэл босоо байрласнаас хамаарч дараах байдлаар гар зургийн үндсэн агуулгыг байрлуулна (зураг 1).

Зураг 1. Хөндлөн гар зургийн



Зураг 2. Босоо гар агуулгын байрлал зургийн агуулгын байрлал

Тоологч баг, хорооны газрын зургаас зөвхөн өөрт хуваарилагдсан хэсгийг харж зурах бөгөөд А3 цаасны “II. Гар зургийн хэсэг”-т **балын харандаагаар** торлол<sup>4</sup>-ыг татаж, дөрвөлжин нүд<sup>5</sup>-нүүдэд хуваана (зураг 3). Ингэснээр газрын зургийн элементүүдийг том хэмжээтэй талбай бус, жижиг нүднүүдэд буулгаж, оронзайн баримжаатайгаар алдаагүй, зөв зурахад ихээхэн дөхөмтэй болно.

<sup>4</sup> Торлол гэж зургийг хэвтээ болон босоогоор нь хуваасан шулуун шугамуудыг,

<sup>5</sup> Нүд гэж торлол татахад үүссэн хааш хаашаа ижил хэмжээтэй дөрвөлжин зайг ойлгоно.

Торлолыг хийхдээ шугам ашиглаж шулуун зураасаар зурна. Торлолын хэмжээ, нүдний тоо нь баг, хорооны газрын зургаас харж зурах тооллогын нутаг дэвсгэрийн нэгжид хичнээн нүд багтаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, торлолын

**I. Хаяг, баталгаажуулалтын хэсэг**

А3 цаасны дээд хэсэгт 5 см зайд тоологчийн гар зургийн нэр, баталгаажуулсан баг, хорооны түр товчооны даргын нэр, гарын үсэг, шийдвэрийн дугаарыг бичих зай байна.

**II. Гар зургийн хэсэг**

А3 цаасны дунд хэсэгт гар зураг зурахыг хөнгөвчилсөн торлол бүхий хэсэг байна.


**III. Таних тэмдгийн хэсэг**

А3 цаасны хөндлөн зургийн баруун хэсгээс, босоо зургийн доод хэсгээс 8 см зайд таних тэмдэг, зүг зовхисын тэмдэг, зургийг шалгасан шалгалтын хэсэг байрлана.

нүдний тоо нь газрын зургаас тоологчийн хариуцах хэсэгт сонгогдсон нүдний тоотой тэнцүү байх ёстой. Ингэснээр газрын зургийн харгалзах нүдэнд байгаа элементийг гар зургийн торлолын нүд тус бүрт харалдуулан зурах боломжтой болно.

Гар зургийн торлолыг татахдаа тоологч эхлээд өөрийн хариуцах тооллогын нутаг дэвсгэрийн нэгжид хөндлөнгөөр болон босоогоор хичнээн нүд оногдож байгааг тооцно.


Зураг 2. Түр товчооны газрын зургаас торлолыг тооцох



Газрын зураг дээрх торлолын нүдийг тогтоосны дараа гар зураг зурах АЗ цаасны “II. Гар зургийн хэсэг”-т түүнтэй ижил тооны нүд бүхий торлолыг зурна. Гар зураг дээр зурах торлолын нүдний хэмжээ баг, хорооны комиссын зургийнхтай заавал ижил хэмжээтэй байх албагүй. Учир нь газрын зураг дээрх тооллогын нутаг дэвсгэрийн нэгж яг тэр хэмжээгээрээ АЗ цаас дээр багтахгүй байж болно. Тийм учраас тоологч хэрвээ комиссын газрын зургийн торлол АЗ цаасны “II. Гар зургийн хэсэг”-т багтахгүй бол жижигрүүлэх, бага хэмжээтэй бол томруулах байдлаар зурна. Өөрөөр хэлбэл, торлолын хэмжээ бус тоо нь чухал юм.

7. Гар зургийг зурахдаа хойд зүгийг газрын зургийн толгой хэсэгт урд зүгийг зургийн доод хэсэгт байхаар тооцно (зураг 5).

Зураг 3. Гар зургийн чиглэл




8. Комиссын газрын зураг болон гар зургийн торлолын харгалзах нүднүүдэд адил дугаар олгоно. Ингэснээр комиссын газрын зураг дээрх элемент<sup>6</sup> бүрийг хаана, хаашаа чиглэлтэй, ямар хэлбэртэй байгаагаар нь гар зурагт адилаар буулгах бололцоо бүрдэнэ.
9. Газрын зургийн торлол буюу нүднүүдэд харгалзах элементийг гар зургийн харгалзах нүдэнд тэмдэгт<sup>7</sup> болгон зурна. Жишээлбэл, газрын зургийн босоогоор 3-р нүд, хөндлөнгөөр 4-р нүдэнд байгаа хашаа байшинг зурахдаа гар зургийн мөн адил босоогоор 3-р нүд, хөндлөнгөөр 4-р нүдэнд зурна (зураг 5).

<sup>6</sup> Газрын зургийн элемент гэж газрын зурагт дүрслэгдсэн бүх төрлийн биетүүд (худаг, хашаа, хайс, байшин, барилга, зам гэх мэт)-ийг хэлнэ.

<sup>7</sup> Тэмдэгт гэж газрын зургийн элементүүдийг гар зурагт тодорхой тэмдэглээгээ ашиглан тэмдэглэснийг хэлнэ.

Зураг 4. Газрын зургийн элементийг тэмдэгт болгосон байдал



10. Газрын зурагт байгаль дээрх биетүүдийг эгц дээрээс харсан байдлаар дүрсэлдэг бөгөөд тоологч ч үүний адил гар зургаа эгц дээрээс харсан байдалтайгаар, комиссын газрын зурагтай аль болох адилхан байхаар зурна.
11. Гар зургийн агуулгад дараах зүйлсийг заавал тэмдэглэнэ.

#### 11.1 I. хаяг, баталгаажуулалтын хэсэгт:

- Гар зургийн баталгаажуулалт: комиссын даргын нэр, гарын үсэг;
- Гар зургийг баталгаажуулсан огноо;
- Гар зургийн гарчиг;

Гар зургийн гарчгийг **ТОМ ҮСГЭЭР** бичнэ. Гарчиг нь тоологч бүрийн харьяалагдах баг, хорооны нэр болон тоологчийн дугаараас бүрдэнэ. Жишээлбэл, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 01-р тоологчийн гар зураг, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 2-р хорооны 08-р тоологчийн гар зураг гэх мэт.

#### 11.2 II. Гар зургийн хэсэг:

- Тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хил;

Тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хил буюу тоологчийн хил нь өрх, хүн ам орхигдох, давтагдахаас сэргийлэх гол хүчин зүйл юм. Тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хилийг бусад шугаман тэмдэгт (зам, баг, хороо, сум, дүүргийн хил гэх мэт)-ээс илт ялагарахуйцаар **өргөн, тод** зураасаар зурна.

*Зураг 5. Гар зургийн хэсэг*



### 11.3 III. таних тэмдгийн хэсэгт:

- Гар зургийн таних тэмдэг;

Тоологч баг, хорооны газрын зургийн элементүүдийг гар зурагт тэмдэгт болгон зурсны дараа тэмдэгтүүдийн тайлбар буюу “таних тэмдэг”-ийг заавал хийнэ. Хүснэгт 1-д заасан стандарт тэмдэгтүүдийг гар зурагт хэрэглэх бөгөөд заагдаагүй бусад тэмдэгтийг өөрт ойлгогдох дүрсийг ашиглан тэмдэглэж болно. Энэ тохиолдолд шинээр тэмдэглэсэн тэмдэгтийн тайлбарыг “таних тэмдэг”-т заавал тусгасан байна.

Хүснэгт 1. Гар зурагт хэрэглэгдэх стандарт таних тэмдгүүд

№	Таних	Агуулга	Тайлбар тэмдэг
<b>Нийтлэг хэрэглэгдэх стандарт таних тэмдэг</b>			
		Тоологчийн хил	Энэ нь гар зургийн хамгийн чухал элемент учирт <b>өргөн, тод</b> зураасаар тэмдэглэнэ.
		Зам	Тасархай зураасаар тэмдэглэх бөгөөд зарим тохиолдолд зурагт ороогүй өөрийн мэддэг замаа тэмдэглэж болно.
		Төмөр зам	
		Худаг, уст цэг	Гүний, гар, моторт, богино яндант гэх мэт бүх төрлийн худгийг тэмдэглэнэ. Өөрийн мэдэх худгийг зөв байршуулан нэмж тэмдэглэж болно.
		Аймаг, нийслэлийн хил	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийг тоологчийн хилээс ялгарахуйцаар зурна.
		Сум, дүүргийн хил	
		Баг, хорооны хил	
		Гол, горхи	
		Нуур, цөөрөм	
		Тариалангийн талбай	
		Элс	

## Төв суурин газрын гар зурагт хэрэглэгдэх стандарт таних тэмдэгт

	Сургууль	
	Цэцэрлэг	
	Эмнэлэг	
	Цагдаагийн газар	
	Төрийн захиргааны болон төв байгууллагын байр	Тухайн сум, дүүрэг, баг, хороонд байрлах яам, агентлаг, ЗДТГ гэж ойлгож болно.
	Албан байгууллага	
	Орон сууц	
	Орон сууцны дугаар	
	Зочид буудал	
	Ресторан, цайны газар, кафе	
	Хүнсний дэлгүүр	
	Барааны дэлгүүр	
	Гэр хорооллын гудамжны дугаар	
15	Хашааны дугаар	

Гар зураг дээрх тэмдэгтүүд нэр, хаяг, дугаартай байна. Үүнд: байшин барилга, гудамж, хашаа, орон сууцны нэр, дугаар зэрэг орно.

- Зүг зовхис;

Гар зурагт хойд, урд, баруун, зүүн зүгийг илэрхийлсэн зүг зовхисын тэмдэг байрлуулах бөгөөд үнэн, зөв байх ёстой.

- Тоологчийн эцэг/ эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр, гарын үсэг;
- Шалгагчийн эцэг/ эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр, гарын үсэг;

Тоологч гар зургийг зурж дуусаад шалгагчаар шалгуулж өөрийн эцэг/ эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэрийг бичиж, гарын үсэг зуран баталгаажуулна.

Зураг 6. Гар зургийн Таних тэмдгийн хэсэг


## Гар зургийг зурах заавар

ТАНИХ ТЭМДЭГ			
Хурх тосгоны захиргаа	Цагдаагийн хэсэг	Хүнсний дэлгүүр	- - - - - Зам
Эмнэлэг	Орон сууц	Барааны дэлгүүр	————— Тоологчийн хил
Сургууль	Албан газар	Орон сууцны дугаар	
Цэцэрлэг	Цайны газар		
Зурсан тоологч: .....		Шалгасан Комиссын дарга: .....	
		Шалгагч: .....	

1. Юуны өмнө дээр дурьдсан 3.7 болон 3.8 дахь аргачлал, зарчмын дагуу гар

- зургийн торлолыг татаж нүднүүдэд хуваана.
2. Гар зургийг эхлээд балын харандаагаар зурж дадлагажсаны дараа өөрийн тооллогод ашиглах сүүлийн хувилбарыг хөх өнгийн балаар зурна. Ялангуяа том нутаг дэвсгэр хуваарилагдсан тоологчийн хувьд комиссын газрын зургаас өөрийн гар зургийг зурахад нилээн хүндрэлтэй байх бөгөөд эхлээд шууд, алдаагүй зөв зурах бололцоо бага юм. Тиймээс балын харандаагаар ноорог цаас дээр 1-2 удаа зурсны дараа дадлагажиж, өөрийн тоолох үед ашиглах сүүлийн хувилбараа алдаагүй, зөв зурах боломжтой болно. Ийм учраас тоологч бүрт 2 ширхэг А3 цаас хуваарилагдсан байгаа.
  3. Тоологчийн хилийг гар зурагт хамгийн сүүлд зурна.
  4. Газрын зураг дээрх элементүүдийн байршил, хэлбэр дүрс, хоорондын зай зэргийг гар зураг дээрээ маш тодорхой зөв буулгана.
  5. Гар зураг нь дээрх заавар, загварт өгөгдсөнөөс бусад уран сайхны болон чимэг зүүлтгүй байна.

*Зураг 7. Тоологчийн хилийг зурсан байдал*



6. Газрын зураг дээрх үндсэн элементүүдээс эхэлж зурах бөгөөд түүн дотроо тоологчийн өөрт оногдсон хэсгийн хамгийн том талбай эзэлж буй элементээс эхэлж зурна.

7. Газрын зургаас элементүүдийг зурж дууссаны дараа тэдгээр зурагдсан тэмдэгтийн таних тэмдэг, тэмдэглэгээг хийнэ. Таних тэмдэгийг бүрэн гүйцэд хийсний дараа зүг зовхисын тэмдгийг зурна. Зүг зовхисын тэмдэг нь тоологч гар зураг дээр ажиллахдаа зүг чиг, хол ойрын зайг тодорхойлох зэрэгт ашиглана.




Зураг 8. Гар


зургийн таних тэмдэг, зүг зовхисын тэмдэгийг зурсан байдал

8. Үүний дараа гар зургийг баталгаажуулах комиссын даргын нэр, гарын үсэг бичих зай, он, сар, өдөр зэргийг бичих зайг бичнэ. Ингэхдээ зургийн **I хэсэгт** (зүүн дээд булан) бичих бөгөөд гар зургийн нэр бичих зайг үлдээх ёстойг анхаарах хэрэгтэй.

Зураг 9. Гар зургийн баталгаажуулалтыг бичсэн байдал



9. Гар зургийн хамгийн сүүлд бичих зүйл бол гар зургийн нэр юм. Нэрийг бичихдээ гар зургийг **I хэсэгт** баталгаажуулах тэмдэглэгээний доод талд том үсгээр голлуулж бичих ёстой.



Зураг 10. Гар зургийн нэрийг бичсэн байдал

10. Гар зургаа зурж дууссаны дараа тооллогын комиссоор хэлэлцүүлж, шалгагч болон комиссын даргаар шалгуулсан байх ёстой бөгөөд зохих шаардлагыг хангасан гэж үзэж тооллогод ашиглах зөвшөөрөл олгосон тохиолдолд гар зургийг зурж дууссан гэж үзнэ.

Зураг 11. Гар зургийг түр товчооны дарга, шалгагч

ТАНИХ ТЭМДЭГ			
Хурх тосгоны захиргаа Эмнэлэг Сургууль Цэцэрлэг	Цагдаагийн хэсэг Орон сууц Албан газар Цайны газар	Хүнсний дэлгүүр Барааны дэлгүүр <div style="border: 1px solid black; display: inline-block; padding: 2px 5px;">5</div> Орон сууцны дугаар	Зам Тоологчийн хил 

Зурсан тоологч: ..... Шалгасан Комиссын дарга: .....  
 Шалгагч: .....

*нараар шалгуулж гарын үсэг зуруулсан байна.*

11. Комисс гар зургийг дутуу, буруу зурсан гэж үзвэл тоологч алдаагаа засч дахин шинээр зурах ёстой.
12. Комиссоор гар зургийг шалгуулсны дараа харандаагаар зурсан гар зургийн хэсгийг тодруулж торлолыг баллуурдаж арилгана.
13. Гар зургийг комиссоор шалгуулж ашиглах зөвшөөрөл авсны дараа түүнийг урагдах, гэмтэхээс хамгаалах үүднээс зөвхөн ар талыг нь наалддаг тууз (скоч)-аар наана. Харин урд хэсэг дээр нь аж ахуйн нэгжийн байршил, дугаарыг бичиж тэмдэглэх учраас наалддаг тууз (скоч) нааж болохгүй.

*Зураг 12. Тоологчийн гар зураг бэлэн болсон байдал*

Батлав: Комиссын дарга ..... 2012 оны ... сарын ..... өдөр

*Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 2-р хорооны  
5-р тоологчийн гар зураг*

ТАНИХ ТЭМДЭГ			
Хурх тосгоны захиргаа Эмнэлэг Сургууль Цэцэрлэг	Цагдаагийн хэсэг Орон сууц Албан газар Цайны газар	Хүнсний дэлгүүр Барааны дэлгүүр <div style="border: 1px solid black; display: inline-block; padding: 2px 5px;">5</div> Орон сууцны дугаар	Зам Тоологчийн хил 

Зурсан тоологч: ..... Шалгасан Комиссын дарга: .....  
 Шалгагч: .....


### 5. Гар зураг дээр ажиллах заавар

1. Баг, хорооны комиссоос тоологчийн хариуцаж тоолох нутаг дэвсгэрийг

хуваарилж, тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хил заагийг тодорхойлж өгөх бөгөөд тоологч зөвхөн тэрхүү хуваарилсан нутаг дэвсгэр дэхь тооллогын нэгжийг тоолно.

2. Тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэхдээ асуулгыг бүрэн гүйцэд авсны дараа асуулгад хариулагчийг орхин явахаасаа өмнө хаяг, байршлыг сайтар тодруулж асуусны эцэст тэмдэглэнэ.
3. Тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэхдээ маш зөв, тодорхой, нарийвчлал сайтайгаар **цэглэж** тэмдэглэнэ.
4. Тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэсэн цэгийн хажууд тухайн тооллогын нэгжийн **асуулгын дугаарыг** бүтнээр нь (0-ийг оролцуулан) бичсэн байна.


Зураг 13. Тооллогын нэгжийн байршлын дугаарыг гар зурагт тэмдэглэсэн байдал



5. Тоологчийн гар зураг нь тооллогын асуулгын хуудастай адил чухал баримт материал учир түүнийг гэмтэх, урагдах, хаягдаж гээгдэхээс сэргийлж байх хэрэгтэй.
6. Нэг асуулгаар мэдээллийг нь авсан боловч 2 болон түүнээс дээш байршилтай тариалсан талбайн асуулгын дугаарыг бичихдээ байршлын цэг бүрийн дэргэд асуулгын ижил дугаарыг бичих бөгөөд таримлын төрлүүд нь өөр бол дэргэд нь таримлын төрлийг бичиж болно.

Зураг 14. Тооллогын нэгжийн байршлын дугаарыг


гар зурагт тэмдэглэсэн байдал



## 6. Газрын зураг дээр ажиллах заавар

1. Кадастрын зурагт тооллогын нэгжийн байршлын цэгийг гар зургаас хуулах.
  - 1.1. Тоологч өдөр бүрийн тооллогын дараа тооллогын нэгжийн байршил тэмдэглэсэн гар зургаа өөрийн шалгагчдаа шалгуулж байх шаардлагатай. Шалгагч нь тоологчийн гар зураг дээрх тооллогын нэгжийн дугаарыг асуулга дээрх дугаартай харьцуулж тулгах, тооллогын нэгжийн байршил зөв газар, бүрэн тэмдэглэгдсэн эсэхийг шалгах үүрэгтэй юм.
  - 1.2. Тоологч **өдөр бүр** өөрийн гар зураг дээр тэмдэглэсэн тооллогын нэгжийн байршлыг шалгагчийн хамт тухайн шатны тооллогын комиссын газрын зураг дээр хуулж тэмдэглэнэ. Ингэхэд түр товчооны газрын зураг нь гар зурагтай харьцуулахад нилээд дэлгэрэнгүй, нарийвчлал өндөртэй, оронзайн дүрслэл сайтай байдаг учир тооллогын нэгжийн байршил зөв тэмдэглэгдэх учиртай. Иймд тоологч гар зургаас түр товчооны газрын зурагт тооллогын нэгжийн байршлыг буулгахдаа аль болох алдаа багатай, оновчтой байршуулахыг хичээх хэрэгтэй. Энэ ажлыг тоологч тухайн өдрийн тооллогын нэгжийн байршлаа сайн санаж байх, 7 хоногийн дараа бүх тооллогын нэгжийн байршил хуулж өөртөө ачаалал үүсгэхгүй байлгах зэрэг давуу талтай байдгаас хамаарч **өдөр бүрийн тооллогын дараа** хуулах хэрэгтэй.
  - 1.3. Гар зурагт тооллогын нэгжийн байршил тэмдэглэсэн цэгийн хажууд тухайн тооллогын нэгжийн асуулгын дугаарыг тэмдэглэж байсан бол гар зургаас кадастрын зурагт тооллогын нэгжийн байршлыг хуулахдаа байршлын дугаарыг шинээр үүсгэн тухайн кадастрын зургийн хувьд дэс дараалуулан тэмдэглэнэ.


Зураг 15. Тооллогын нэгжийн байршлыг гар зургаас



газрын зурагт хуулсан байдал

- 1.4. Кадастрын зургийн баруун талын бэлэн хүснэгтэд тухайн тооллогын нэгжид харгалзах байршлын дугаар, багийн дугаар, тоологчийн дугаар, асуулгын дугаарыг бичнэ.
  - 1.5. Өмнөх тоологч гар зургаас кадастрын зурагт тооллогын нэгжийн байршлыг хуулсны дараа дараагийн тоологч байршлын дугаарыг өмнөх тоологчийн дуусгасан дугаарыг үргэлжлүүлэн дугаарлах байдлаар тэмдэглэнэ.
  - 1.6. Баруун талын бэлэн хүснэгтэд тэмдэглэгээ хийж дүүрсэн тохиолдолд нэмэлт А4 форматын цаасан дээр тэмдэглэж газрын зурагт үдэж хавсаргана.
2. Хөдөөгийн буюу сансрын болон байрзүйн зурагт тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэх.
    - 2.1. Гар зураг ашиглаагүй буюу төв суурин газраас бусад хөдөөгийн газрын зураг (сансрын болон байрзүйн)-т тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэхдээ **талбайг хүрээлж** тэмдэглэнэ.
    - 2.2. Хүрээгээр тэмдэглэсэн талбайн хажууд байршлын дугаарыг бичнэ. Байршлын дугаарыг тэмдэглэхдээ тооллогын нэгжийг 1-ээс эхлэн дэс дараалуулан дугаарлаж тэмдэглэнэ.


*Зураг 16. Сансрын зурагт тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэсэн байдал*



3. Тооллогын асуулгад хариулагч болон тооллогын нэгжийн байршил өөр байгаа тохиолдолд тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэх. Тухайлбал, тоологдож буй газар тариалангийн талбай Сэлэнгэ аймагт, тооллогын асуулгын асуулгад хариулагч Улаанбаатар хотод байх тохиолдолд дараах байдлаар тооллогын нэгжийн байршлыг тэмдэглэнэ.

3.1. Газар тариалангийн талбай эзэмшигч боловч өөр газар байрлаж байгаа иргэн аж ахуйн нэгжийн мэдээллийг газар тариалангийн талбай байршиж буй засаг захиргааны нэгжийн тооллогын комисст урьдчилан хүргүүлсэн байх болно. Энэ мэдээлэл дээрээс үндэслэн газрын зургийн хүснэгтийн тоологчийн болон асуулгын дугаар бичих нүдэнд тухайн газар тариалангийн талбайг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг бичнэ.

Зураг 17. 2 болон 5 дугаартай талбайн регистрийн дугаарыг бичсэн байдал



## ЯРИЛЦЛАГЫН ТӨГСГӨЛ

Тооллогын асуулгын нөхөлтийн үнэн зөвийг шалгахад дараах зүйлийг анхаарна.

- a. Тооллогын асуулгын асуулт бүрийг зохих журмын дагуу нөхөгдсөн эсэхийг нэн тэргүүнд шалгана.
- b. Тооллогын асуулгын бүх асуултын хариултыг туйлын анхааралтай үзэж шалгана. Тодорхой нэмэлт хариулт зарим асуулт, түүнчлэн алгасах ёстой асуултуудаас бусад бүх асуултыг тоологдсон нэгж хариулсан байх ёстой.
- c. Асуултын хариултыг шалгахдаа логик, бодох, тооцоолох, харьцуулах аргыг хэрэглэнэ. Нэг асуултад олон хариултыг нөхөгдсөн бол энэ төрлийг зөвшөөрсөн асуулт эсэхийг нягтална.
- d. Хариулт нь тоогоор бичигдэх асуултын зохих тоог зөв бөгөөд нүдэнд багтаан бичсэн, үгээр бичигдэх хариултыг дармал үсгээр, гаргацтай, цэвэр нямбай бичсэн, хариултын зохих кодыг зөв нөхөгдсөн эсэхийг шалгана. Нүдэнд тавигдах тооны орон нь нүдний оронгийн тооноос бага байвал өмнө нь "0" тавьж урагш гүйцээж бичсэн байх ёстой.
- e. Асуулгыг ахлагчдаа өгнө.

----- оОо -----

**Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код, Тооллогын комиссын дугаар**

(Хөдөө аж ахуйн улсын тооллогод зориулав)

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Архангай</b>	<b>65</b>	<b>266</b>
Эрдэнэбулган	01	267
Батцэнгэл	04	268
Булган	07	269
Жаргалант	10	270
Их тамир	13	271
Өгийнуур	16	272
Өлзийт	19	273
Өндөр-Улаан	22	274
Тариат	25	275
Төвшрүүлэх	28	276
Хайрхан	31	277
Хангай	34	278
Хашаат	37	279
Хотонт	40	280
Цахир	43	281
Цэнхэр	46	282
Цэцэрлэг	49	283
Чулуут	52	284
Эрдэнэмандал	55	285

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Баянхонгор</b>	<b>64</b>	<b>242</b>
Баянхонгор	01	243
Баацагаан	04	244
Баянбулаг	07	245
Баянговь	10	246
Баянлиг	13	247
Баян-Овоо	16	248
Баян-Өндөр	19	249
Баянцагаан	22	250
Богд	25	251
Бөмбөгөр	28	252
Бууцагаан	31	253
Галуут	34	254
Гурванбулаг	37	255
Жаргалант	40	256
Жинст	43	257
Заг	46	258
Өлзийт	49	259
Хүрээмарал	52	260
Шинэжинст	55	261
Эрдэнэцогт	58	262

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Баян-Өлгий</b>	<b>83</b>	<b>366</b>
Өлгий	01	367
Алтай	04	368
Алтанцөгц	07	369
Баяннуур	10	370
Бугат	13	371
Булган	16	372
Буянт	19	373
Дэлүүн	22	374
Ногооннуур	25	375
Сагсай	28	376
Толбо	31	377
Улаанхус	34	378
Цэнгэл	37	379

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Булган</b>	<b>63</b>	<b>222</b>
Булган	01	223
Баян-Агт	04	224
Баяннуур	07	225
Бугат	10	226
Бүрэгхангай	13	227
Гурван булаг	16	228
Дашинчилэн	19	229
Могод	22	230
Орхон	25	231
Рашаант	28	232
Сайхан	31	233
Сэлэнгэ	34	234
Тэшиг	37	235
Хангал	40	236
Хишиг-Өндөр	43	237
Хутаг-Өндөр	46	238

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Говь-Алтай</b>	<b>82</b>	<b>344</b>
Есөнбулаг	01	345
Алтай	04	346
Баян-Уул	07	347
Бигэр	10	348
Бугат	13	349
Дарив	16	350
Дэлгэр	19	351
Жаргалан	22	352
Тайшир	25	353
Тонхил	28	354
Төгрөг	31	355
Халиун	34	356
Хөхморьт	37	357
Цогт	40	358
Цээл	43	359
Чандмань	46	360
Шарга	49	361
Эрдэнэ	52	362

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Дорноговь</b>	<b>44</b>	<b>129</b>
Сайншанд	01	130
Айраг	04	131
Алтанширээ	07	132
Даланжаргалан	10	133
Дэлгэрэх	13	134
Замын-Үүд	16	135
Иххэт	19	136
Мандах	22	137
Өргөн	25	138
Сайхандулаан	28	139
Улаанбадрах	31	140
Хатанбулаг	34	141
Хөвсгөл	37	142
Эрдэнэ	40	143

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Дорнод</b>	<b>21</b>	<b>014</b>
Хэрлэн	01	015
Баяндун	04	016
Баянтүмэн	07	017
Баян-Уул	10	018
Булган	13	019
Гурванзагал	16	020
Дашбалбар	19	021
Матад	22	022
Сэргэлэн	25	023
Халх гол	28	024
Хөлөнбуйр	31	025
Цагаан-Овоо	34	026
Чойбалсан	37	027
Чулуунхороот	40	028

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Завхан</b>	<b>81</b>	<b>316</b>
Улиастай	01	317
Алдархаан	04	318
Асгат	07	319
Баянтэс	10	320
Баянхайрхан	13	321
Дөрвөлжин	16	322
Завханмандал	19	323
Идэр	22	324
Их-Уул	25	325
Нөмрөг	28	326
Отгон	31	327
Сантмаргаз	34	328
Сонгино	37	329
Тосонцэнгэл	40	330
Түдэвтэй	43	331
Тэлмэн	46	332
Тэс	49	333
Ургамал	52	334
Цагаанхайрхан	55	335
Цагаанчулуут	58	336
Цэцэн-Уул	61	337
Шилүүстэй	64	338
Эрдэнэхайрхан	67	339
Яруу	70	340

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Дундговь</b>	<b>48</b>	<b>174</b>
Сайнцагаан	01	175
Адаацаг	04	176
Баянжаргалан	07	177
Говь-Угтаал	10	178
Гурвансайхан	13	179
Дэлгэрхангай	16	180
Дэлгэрцогт	19	181
Дэрэн	22	182
Луус	25	183
Өлзийт	28	184
Өндөршил	31	185
Сайхан-Овоо	34	186
Хулд	37	187
Цагаандэлгэр	40	188
Эрдэнэдалай	43	189

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Өмнөговь</b>	<b>46</b>	<b>155</b>
Даланзадгад	01	156
Баяндалай	04	157
Баян-Овоо	07	158
Булган	10	159
Гурвантэс	13	160
Мандал-Овоо	16	161
Манлай	19	162
Ноён	22	163
Номгон	25	164
Сэрвэй	28	165
Ханбогд	31	166
Ханхонгор	34	167
Хүрмэн	37	168
Цогт-Овоо	40	169
Цогтцэций	43	170

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Өвөрхангай</b>	<b>62</b>	<b>199</b>
Арвайхээр	01	200
Баруунбаян-Улаан	04	201
Бат-Өлзий	07	202
Баянгол	10	203
Баян-Өндөр	13	204
Богд	16	205
Бүрд	19	206
Гучин-Ус	22	207
Есөн зүйл	25	208
Зүүнбаян-Улаан	28	209
Нарийнтээл	31	210
Өлзийт	34	211
Сант	37	212
Тарагт	40	213
Төгрөг	43	214
Уянга	46	215
Хайрхандулаан	49	216
Хархорин	52	217
Хужирт	55	218

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Сүхбаатар</b>	<b>22</b>	<b>032</b>
Баруун-Урт	01	033
Асгат	04	034
Баяндэлгэр	07	035
Дарьганга	10	036
Мөнххаан	13	037
Наран	16	038
Онгон	19	039
Сүхбаатар	22	040
Түвшинширээ	25	041
Түмэнцогт	28	042
Уулбаян	31	043
Халзан	34	044
Эрдэнэцагаан	37	045

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Сэлэнгэ</b>	<b>43</b>	<b>108</b>
Сүхбаатар	01	109
Алтанбулаг	04	110
Баруунбүрэн	07	111
Баянгол	10	112
Ерөө	13	113
Жавхлант	16	114
Зүүнбүрэн	19	115
Мандал	22	116
Орхон	25	117
Орхонтуул	28	118
Сайхан	31	119
Сант	34	120
Түшиг	37	121
Хүдэр	40	122
Хушаат	43	123
Цагааннуур	46	124
Шаамар	49	125

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Төв</b>	<b>41</b>	<b>070</b>
Зуунмод	01	071
Алтанбулаг	04	072
Аргалант	07	073
Архуст	10	074
Батсүмбэр	13	075
Баян	16	076
Баяндэлгэр	19	077
Баянжаргалан	22	078
Баян-Өнжүүл	25	079
Баянхангай	28	080
Баянцагаан	31	081
Баянцогт	34	082
Баянчандмань	37	083
Борнуур	40	084
Бүрэн	43	085
Дэлгэрхаан	46	086
Жаргалант	49	087
Заамар	52	088
Лүн	55	089
Мөнгөнморьт	58	090
Өндөрширээт	61	091
Сүмбэр	64	092
Сэргэлэн	67	093
Угтаалцайдам	70	094
Цээл	73	095
Эрдэнэ	76	096
Эрдэнэсант	79	097

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Увс</b>	<b>85</b>	<b>404</b>
Улаангом	01	405
Баруунтуруун	04	406
Бөхмөрөн	07	407
Давст	10	408
Завхан	13	409
Зүүнговь	16	410
Зүүнхангай	19	411
Малчин	22	412
Наранбулаг	25	413
Өлгий	28	414
Өмнөговь	31	415
Өндөрхангай	34	416
Сагил	37	417
Тариалан	40	418
Түргэн	43	419
Тэс	46	420
Ховд	49	421
Хяргас	52	422
Цагаанхайрхан	55	423

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Ховд</b>	<b>84</b>	<b>383</b>
Жаргалант	01	384
Алтай	04	385
Булган	07	386
Буянт	10	387
Дарви	13	388
Дөргөн	16	389
Дуут	19	390
Зэрэг	22	391
Манхан	25	392
Мөнххайрхан	28	393
Мөст	31	394
Мянгад	34	395
Үенч	37	396
Ховд	40	397
Цэцэг	43	398
Чандмань	46	399
Эрдэнэбүрэн	49	400

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Хөвсгөл</b>	<b>67</b>	<b>289</b>
Мөрөн	01	290
Алаг-Эрдэнэ	04	291
Арбулаг	07	292
Баянзүрх	10	293
Бүрэнтогтох	13	294
Галт	16	295
Жаргалант	19	296
Их-Уул	22	297
Рашаант	25	298
Рэнчинлхүмбэ	28	299
Тариалан	31	300
Тосонцэнгэл	34	301
Төмөрбулаг	37	302
Түнэл	40	303
Улаан-Уул	43	304
Ханх	46	305
Цагааннуур	49	306
Цагаан-Уул	52	307
Цагаан-Үүр	55	308
Цэцэрлэг	58	309
Чандмань-Өндөр	61	310
Шинэ-Идэр	64	311
Эрдэнэбулган	67	312

Аймаг, сумын нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Хэнтий</b>	<b>23</b>	<b>049</b>
Хэрлэн	01	050
Батноров	04	051
Батширээт	07	052
Баян-Адрага	10	053
Баянмөнх	13	054
Баян-Овоо	16	055
Баянхутаг	19	056
Биндэр	22	057
Галшар	25	058
Дадал	28	059
Дархан	31	060
Дэлгэрхаан	34	061
Жаргалтхаан	37	062
Мөрөн	40	063
Норовлин	43	064
Өмнөдэлгэр	46	065
Цэнхэрмандал	49	066
Бор-Өндөр	52	067

Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Дархан-Уул</b>	<b>45</b>	<b>147</b>
Дархан	01	148
Орхон	04	149
Хонгор	07	150
Шарын гол	10	151

Аймгийн нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Орхон</b>	<b>61</b>	<b>193</b>
Баян-Өндөр	01	194
Жаргалант	04	195

Нийслэл, дүүргийн нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Улаанбаатар</b>	<b>11</b>	<b>001</b>
Багануур дүүрэг	01	002
Багахагай дүүрэг	04	003
Баянгол дүүрэг	07	004
Баянзүрх дүүрэг	10	005
Налайх дүүрэг	13	006
Сонгинохайрхан	16	007
Сүхбаатар дүүрэг	19	008
Хан-Уул дүүрэг	22	009
Чингэлтэй дүүрэг	25	010

Аймгийн нэр	Код	Тооллогын комиссын дугаар
<b>Говьсүмбэр</b>	<b>42</b>	<b>101</b>
Сүмбэр	01	102
Баянтал	04	103
Шивээговь	07	104

## Монгол Улсын тосгон (хот маягийн суурин)-ы жагсаалт

(Зөвхөн Хөдөө аж ахуйн улсын анхны тооллогод зориулав)

Тосгоны нэр	Код	Харьяалагдах аймаг, сум
Цагааннуур	01	Баян-Өлгий, Ногооннуур сум
Шаргалжуут	02	Баянхонгор, Баянхонгор сум
Хялганат	03	Булган, Хангал сум
Гуулин	04	Говь-Алтай, Дэлгэр сум
Баянтоорой	05	Говь-Алтай, Цогт сум
Замын-Үүд	06	Дорноговь, Замын-Үүд сум
Зүүнбаян	07	Дорноговь, Сайншанд сум
Хархорин	08	Өвөрхангай, Хархорин сум
Зүүнхараа	09	Сэлэнгэ, Мандал сум
Хөтөл	10	Сэлэнгэ, Сайхан сум
Хатгал	11	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум
Бэрх	13	Хэнтий, Батноров сум
Хэрлэнбаян-Улаан	14	Хэнтий, Дэлгэрхаан сум
Өлзийт	15	Хэнтий, Хэрлэн сум
Хурх	16	Хэнтий, Өмнөдэлгэр сум
Тахилгат	17	Хэнтий, Хэрлэн сум